



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ТҮГЭЭМЭЛ
ХӨГЖИЛ



БОЛОВСРОЛД
ТЭГШ
БОЛОМЖ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ХҮНИЙ ЭРХ





НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ТҮГЭЭМЭЛ
ХӨГЖИЛ



БОЛОВСРОЛД
ТЭГШ
БОЛОМЖ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ХҮНИЙ ЭРХ

ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2020 он



ННА 67.3
ДАА 340.009
А-179

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ХҮНИЙ ЭРХ

Гарын авлагыг боловсруулсан:

Я.АВИРМЭД, Түгээмэл хөгжил ТББ-ын Гүйцэтгэх захирал

Р.БУДХАНД, Боловсролд тэгш боломж ТББ-ын Гүйцэтгэх захирал

© Нээлттэй Нийгэм Форум, 2020

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-9919-9678-0-2

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	5
ӨМНӨХ ҮГ	6
“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ХҮНИЙ ЭРХ” СУРГАЛТЫН СЭДЭВЧИЛСЭН ХӨТӨЛБӨР.....	7
Модуль 1. Хөгжлийн бэрхшээлийг хүний эрхийн байр сууринаас ойлгох нь	8
Сэдэв 1.1. Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлагууд ба хүний эрх.....	8
Сэдэв 1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ба хөгжлийн бэрхшээлийн талаарх хэвшмэл ойлголт, тэдгээрийн үр дагавар	9
Сэдэв 1.3. Оролцооны саад тотгор, хүртээмжгүй ба хүртээмжтэй орчин	10
Модуль 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах эрх зүйн орчин	12
Сэдэв 2.1. НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц, түүний нэмэлт протоколын агуулга, бүтэц	12
Сэдэв 2.2. ХБХЭК-оор хамгаалагдсан эрхүүд, Конвенцын хэрэгжилтийг хянах механизмууд	13
Модуль 3. Сурч боловсрох эрх.....	14
Сэдэв 3.1. Боловсрол дахь тэгш байдал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрх	14
Сэдэв 3.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах нь.....	16

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ХҮНИЙ ЭРХ” СУРГАЛТЫН МОДУЛИУД	17
Модуль 1. Хөгжлийн бэрхшээлийг хүний эрхийн байр сууринаас ойлгох нь	18
Сэдэв 1.1. Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлагууд ба хүний эрх	18
Сэдэв 1.2: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ба хөгжлийн бэрхшээлийн талаарх хэвшмэл ойлголт, тэдгээрийн үр дагавар	29
Сэдэв 1.3: Оролцооны саад тотгор, хүртээмжгүй ба хүртээмжтэй орчин.....	40
Модуль 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах эрх зүйн орчин	48
Сэдэв 2.1. НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц, түүний нэмэлт протоколын агуулга, бүтэц	48
Сэдэв 2.2. ХБХЭК-оор хамгаалагдсан эрхүүдийн тойм, Конвенцын хэрэгжилтийг хянах, хангуулах механизмууд.....	64
Модуль 3. Сурч боловсрох эрх.....	78
Сэдэв 3.1. Боловсрол дахь тэгш байдал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрх	78
Сэдэв 3.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах нь.....	89
Хавсралт 1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ	113
Хавсралт 2. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ	116

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ХБХЭК	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц
ХБХЭХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
АХБ	Азийн Хөгжлийн Банк
УИХ	Улсын Их Хурал
ХЭТТ	Хүний эрхийн түгээмэл тунхаг
ХБХЭ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх

ӨМНӨХ ҮГ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр, тэгш боломжийн үндсэн дээр эрх эзэмшигч хэмээн хүлээн зөвшөөрч, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) батлан гаргасан билээ. Энэхүү конвенцын хэрэгжилт хүнд илэрч болох хөгжлийн бэрхшээл бол нэг хүний нөгөөгөөс ялгарах нэг хэлбэр гэж хүлээн зөвшөөрч, хүндэтгэн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхээ эдлэхэд нь саад болж байгаа тогторыг арилгахаас эхэлнэ. Манай улс Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль баталж, хэрэгжүүлж эхэлснээс хойш 4 жил өнгөрч байгаа хэдий ч зөвхөн хууль батлан, сайн туршлага бий болгосноор хүний эрхийг хангаж байна гэж үзэх аргагүй юм. Хүн бүрийн үг, үйлдэл, хандлага, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдний эрх ашгийн төлөө хүчин чармайлт гарган ажилладаг бүх талын үүрэг, оролцоотойгоор хүний эрх баталгаажна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах тогтолцоог бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилгоор Тэгш хамран сургах боловсролын иргэний нийгмийн сүлжээ нь 2014 онд байгуулагдсан. Уг Сүлжээний гишүүн байгууллагууд өөр өөрийн эрхэм зорилго, үйл ажиллагааны давамгай чиглэлийг баримталдаг хэдий ч чанартай боловсролыг тэгш хамрагдалттай болгон тэлж хот, хөдөөгийн бүх хүүхдийг сургуульд хамруулахын төлөө үйл ажиллагаагаа нэгтгэн ажилласаар ирлээ. Энэхүү гарын авлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, тэдгээрийг хамгаалах зорилготой олон улсын болон үндэсний эрх зүйг танилцуулж, хэрэгжилтийг хянахад хэрхэн оролцох талаар мэдлэг, мэдээлэлтэй болоход туслах болно. Уг гарын авлага нь хөгжлийн бэрхшээл, хүний эрх, сурч боловсрох асуудлаар Та бүхний мэдлэг, нөлөөллийн ажилд нэмэр болно хэмээн найдаж байна.

Бидний санаачилгыг дэмжин, энэхүү гарын авлагыг бэлтгэхэд зөвлөн тусалсан Нээлттэй Нийгэм Форумд талархлаа илэрхийлье.

Зохиогчид

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ
БА ХҮНИЙ ЭРХ**

СУРГАЛТЫН СЭДЭВЧИЛСЭН ХӨТӨЛБӨР





Модуль 1. Хөгжлийн бэрхшээлийг хүний эрхийн байр сууринаас ойлгох нь

ЗОРИЛТ: Модуль 1-ийг судалснаар оролцогчид хөгжлийн бэрхшээлд хандах хүний эрхийн хандлага, хөгжлийн бэрхшээлийн талаарх хувьсан өөрчлөгдөж ирсэн ойлголт хандлагыг ялгаж, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудалд хүний эрхийн байр сууринаас хандах мэдлэгтэй болох



СЭДЭВ 1.1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ ХАНДЛАГУУД БА ХҮНИЙ ЭРХ

Хөгжлийн бэрхшээлд хандах өглөг хандивын, эмнэлгийн, хүний эрхийн, нийгмийн гэсэн 4 хандлага нь олон нийтийн ойлголт, бодлогын суурь болдог. Аль хандлага давамгайлж байгаагаас шалтгаалж тухайн нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бодлогын ямар дэмжлэг үзүүлэх, тусгай байлгах уу, оролцоог нь хангах уу гэдэг нь шийдэгдэж байдаг. Эдгээр хандлагыг судалж ойлгох нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бодлогын үйл явцад эрхээ хамгаалсан байх сууринаас оролцох мэдлэгтэй болоход тусална.

Хүний ойлголт, итгэл үнэмшил болж, хийж байгаа үйлдэл, гаргаж байгаа хандлагад нөлөөлж байдаг хэр нь хүн тэр бүр яагаад ийм хандлага гаргаж байгаа, энэ нь ямар үр дагавартай тухай бодож тунгаадаггүй. Итгэл үнэмшил нь далдуур хүнд нөлөөлж байдаг. Энэ хичээл нь оролцогчдод хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг судалж, хөгжлийн бэрхшээлд хүний эрхийн, нийгмийн хандлагаар хандах ухамсарт сонголт хийхэд нь тус болох юм.



СЭДЭВ 1.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХ БА ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТАЛААРХ ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТ, ТЭДГЭЭРИЙН ҮР ДАГАВАР

Хүмүүсийн ойлголт, хандлагад гэр бүл, орчин тойрныхны хандлага, мөн хэвлэл мэдээлэл, урлаг чухал нөлөө үзүүлдэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандах нийгэмд давамгайлж буй хандлага нь нь хэвлэл мэдээлэл, кино, номоор дамжин улам тэлж, дараа дараагийн үед уг хандлагыг түгээх үр дагавартай. Энэ дүр төрх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст өөрсдөд нь хүчтэй нөлөөлж, төрөөс юу шаардах, гэр бүлийн хүмүүстээ хэрхэн хандах, олон нийтийн дунд биеэ хэрхэн авч явахад хүртэл нөлөөлдөг. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүний эрхийн байр сууринаас эрхээ шаардаж нөлөөлөл хийх нь нэмэгдэж байгаа ч жагсаал цуглаан хийж, халамж шаардах нь хэвээр, зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс дундаа харилцаанд орох хүсэл нь хэвээр байна (сонсголын бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуулийн захирлаар сонсголгүй хүн тавих шаардлага, хараагүй хүүхдүүдийн сургуулийн тендерийг хараагүйчүүдийн байгууллагаар гүйцэтгүүлэх шаардлага гэх мэт).

Энэ хичээлээр хэвлэл мэдээлэл, урлагийн бүтээлд хөгжлийн бэрхшээлтэй хүн хэрхэн, ямар дүрээр тусаж байгааг судалж, өмнөх сэдвийн хүрээнд үзсэн хөгжлийн бэрхшээлийн 4 хандлагаар шинжлэн, уг дүр төрх өргөн тархсанаар бий болох үр дагаврыг ярилцах юм.



СЭДЭВ 1.3. ОРОЛЦООНЫ СААД ТОТГОР, ХҮРТЭЭМЖГҮЙ БА ХҮРТЭЭМЖТЭЙ ОРЧИН

Энэ хичээлээр хөгжлийн бэрхшээлийн талаарх хомсдолд суурилсан ойлголт, хандлагыг өөрчлөх юм.

Хөгжлийн бэрхшээл бол үйлийн үр биш, согог эмгэг ч гэлээ эмчлэгдэхгүй тул хүнд өвчин, шаналалт зовуурь биш. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бол бие эрхтэн, мэдрэхүй, оюун санааны согог, эмгэгтэй хүн биш. Харин тэдний ялгаатай байдлыг тооцолгүй бий болгосон хүртээмжгүй орчны улмаас оролцоо, хөгжил нь хязгаарлагдсан, бэрхшээлтэй болсон хүн юм. Согог, эмгэг нь дангаараа хөгжлийн бэрхшээл үүсгэхгүй. Харин ийм согог, эмгэгтэй хүн нийгмийн харилцаанд орох гэхээр ийм согоггүй, эмгэггүй хүмүүст зориулж бий болгосон биет орчин, мэдээллийн үрсгал, дүрэм журам, мөн бусад хүний ойлголт хандлага нь оролцоог нь хязгаарлах нөлөө үзүүлсний улмаас хөгжлийн бэрхшээл тулгарна.

Үнэг, тогорууны үлгэрээс харвал, хоол байгаа хэр нь савны хэлбэрээс болоод аль нэг амьтан нь хоолгүй хоцорно. Үүнээс хоёр дүгнэлт хийж болох бөгөөд

- (i) Агуулга нь байгаа ч хүргэх арга зам нь хүмүүсийн ялгаатай хэрэгцээнд нийцэхгүй бол оролцож чадахгүй;
- (ii) Хүргэх арга хэлбэр нь өөрөө саад болох боломжтой тул хүргэх арга хэлбэр буюу орчин нь өөрөө хүртэх боломжийг олгосон буюу хүртээмжтэй байх ёстой.

Хүртээмжгүй орчин зөвхөн байшин барилга, шат довжоо, давчуу гудамж зэрэг биет байгууламжаар хязгаарлагдахгүй. Орчны хүртээмжийг хязгаарлаж байдаг саад, тотгоруудыг биет байгууламж, мэдээллийн, институцийн (хууль, дүрэм журам), хандлагаас үүдэлтэй саадунд гэж ангилж харж болно.

Дэлхийн улс орнууд дөрвөн саадыг нэг нэгээр нь арилгаж байна. Хамгийн амжилттай хэрэгжиж байгаа нь институцийн хүртээмжтэй орчин бий болгох ажил бөгөөд НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц (ХБХЭК), Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хууль (ХБХЭХ) нь үүний тодорхой жишээ. Сүүлийн үед Түгээмэл загвар гэх нэгэн сонирхолтой хөдөлгөөн эрчтэй хөгжиж, хэрэгжиж байна. Энэ нь бараа бүтээгдэхүүний дизайн янз бүрийн боломж, чадавх, онцлог хэрэгцээтэй хүмүүс бүгд ашиглаж болох хэлбэртэй болгох хөдөлгөөн юм. Боловсролд энэ санааг арга зүйн хэлбэрээр нэвтрүүлж байгаа бөгөөд Сурахуйн түгээмэл загварын сайн туршлагауд бий болж байна.



Модуль 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах эрх зүйн орчин

ЗОРИЛТ: Модуль 2-ыг судалснаар оролцогчид НҮБ-ын ХБХЭК болон Нэмэлт протоколын талаар тодорхой мэдлэгтэй болж, хүний эрхийн эрх зүйн баримт бичгүүдийг нөлөөллийн ажилдаа ашиглах бэлтгэлтэй болно.



СЭДЭВ 2.1. НҮБ-ын ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ, ТҮҮНИЙ НЭМЭЛТ ПРОТОКОЛЫН АГУУЛГА, БҮТЭЦ

ХБХЭК нь 2006 оны 12 дугаар сард НҮБ-аар батлагдаж, Монгол Улс 2009 оны 12 дугаар сард нэгдэн орсон билээ. Конвенц нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шинэ эрх нээж өгөөгүй, зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах үүргийг төрд сануулах, тэдний эрхийг хангах, хамгаалахад төрийн анхаарлыг хандуулах, энэхүү үйл явцад хяналт тавих олон улсын механизмуудыг бий болгох зорилготой. ХБХЭК-ыг олон улсын хүний эрхийн бусад гэрээтэй хамтаар нь харж ашиглах ёстой.

ХБХЭК-д хөгжлийн бэрхшээлийг тодорхойлоогүй. Харин хөгжлийн бэрхшээлд хандах нийгмийн загварыг ашигласан хүний эрхийн тодорхойлолтыг өгсөн. Өөрөөр хэлбэл хүний согог, эмгэг нь орчин, харилцааны саадтай тулгарснаар хүний оролцоо хязгаарлагддаг тул эдгээр саадыг арилгаснаар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх хангагдана гэдгийг тайлбарласан. Монгол Улсын хуулиудад “байнгын согогтой хүн” гэсэн ойлголт байдаг бол ХБХЭК-д “урт хугацааны согог” гэж тусгасан байдаг.

Тодорхойлолтыг нарийвчлан судалсны дараа энэ сэдвийн хүрээнд ХБХЭК-ын нийтлэг зарчмууд, төрийн хүлээх нийтлэг үүргүүдийг судална. Үүнд хүртээмж хэмээх нэр томьёог гүнзгийрүүлэн, боломжит тохируулга/тохирох хэрэглэгдэхүүнийг тухай ойлголт өгнө. Дараа нь тэгш боломж буюу боломжийг тэгшитгэх тухай ойлголтыг танилцуулахын зэрэгцээ де юре (эрх зүйн баримт бичигт туссан) болон де факто (бодит амьдрал дээрх) тэгш байдлын тухай тогтож ярилцах замаар хууль боловсруулахаас гадна хуулийн хэрэгжилт, тодорхой хүн бүр буюу тохиолдол бүрт хууль хэрэгжихийн ач холбогдолд оролцогчдын анхаарлыг татна.



СЭДЭВ 2.2. ХБХЭК-оор ХАМГААЛАГДСАН ЭРХҮҮД, КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ МЕХАНИЗМУУД

ХБХЭК нь 50 бүлэгтэй ба Удиртгалаар эхэлж, 1 дүгээр зүйлд Конвенцын зорилго, 2 дугаар зүйлд зарим нэр томьёог тайлбарлаад, 3 дугаар бүлэгт Конвенцын зарчмууд, 4 дүгээр бүлэгт төр засгийн хүлээх үүргийг заасан байх ба дараа дараагийн бүлэгт тодорхой эрхүүдийг заасан бүтэцтэй.

ХБХЭК -ын бүтэцтэй гүйлгэн танилцсаны дараа бүлэг бүрийн товч агуулгыг уншиж, өмнөх бүлгүүдийн агуулгатай холбон ярилцана (хөгжлийн бэрхшээлтэй холбоотой алдаатай хэвшмэл ойлголт, буруу хандлагыг бууруулах, ямар саадыг арилгах, хэрхэн оролцоог нэмэгдүүлэх, де факто тэгш байдлыг хэрхэн дэмжих үр нөлөөтэй аргууд байгаа зэргийг хэлэлцэх болно)

Конвенц нь хэрэгжилтийг хянах механизмтай бөгөөд ХБХЭК-ын хувьд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороо хэмээх бие даасан экспертүүдийн зөвлөлийн бүтэц, чиг үүрэг, үйл ажиллагааг судална. Нэмэлт Протоколоор уг Хорооны эрх мэдэл өргөжсөн бөгөөд уг механизмыг хэрхэн ашиглаж болох тухай мөн ярилцана.



Модуль 3. Сурч боловсрох эрх

ЗОРИЛТ: Модуль 3-ыг судалснаар оролцогчид хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрх, тэгш хамран сургах боловсролын талаар мэдлэгтэй болж, нөлөөллийн ажилдаа НҮБ-ын ХБХЭК болон манай улсын эрх зүйн орчны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролтой холбоотой зүйл заалтуудыг ашиглах мэдлэг, туршлагатай болно.



СЭДЭВ 3.1. БОЛОВСРОЛ ДАХЬ ТЭГШ БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуульд элсэхгүй, элссэн ч завсардах, эсвэл тусгай сургуульд сурах нь түгээмэл байдаг ч эдгээр нь эцсийн дүндээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нийгмийн хамтын амьдралд оролцох мэдлэг, чадвар дутмаг болох, өөртөө итгэх итгэл дутах үр дүн авчирдаг. Энэ нь нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүн чадваргүй гэсэн ойлголтыг өдөөж, хөгжлийн бэрхшээлд хандах халамжийн, эмнэлгийн загварыг улам бэхжүүлдэг.

Энэ сэдвийн хүрээнд тусгай сургуулийн түүхэн хөгжилтэй танилцаж, 17-18 дугаар зуунд дэвшилттэйд тооцогдож байсан тусгай сургууль нь тухайн үеийн анагаах ухааны хөгжлийн ололт амжилтыг тусгаж байсан бол өнөөдөр эмнэлгийн загварыг бэхжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг үе тэнгийнхнээс нь тусгаарлах нөлөө үзүүлж, нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тусгаарлаж хандах хандлагыг бий болгож байгаа тухай ярилцана.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тусгай сургуульд сургахгүй, энгийн сургууль бусад хүүхэдтэй хамт сургах эхний оролдлогууд нь сургууль дотроо тусгаарлагдах үр дүн авчирсан интеграцчилал болсон түүхийг судална. Монгол Улсад өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай анги нээх (БСШУЯ), Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төв байгуулах (АХБ) үйл явц идэвхтэй өрнөж байгаа энэ үед интеграцчилал нь дангаараа, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын нэмэлт хэлбэрээр хэрэгжихгүй бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн зөрчил болж болохыг судална.

Эцэст нь, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан үзэл санааны түүхийг судлангаа уг үзэл баримтлалын суурь болсон хөгжлийн бэрхшээлд хандах нийгмийн загвар, орчны саадүүдыг арилгахад чиглэсэн боломжит тохируулга болон түгээмэл загвар, де факто тэгш байдлын зарчмууд, жишээг давтана.



СЭДЭВ 3.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ НЬ

Энэ сэдвийн хүрээнд тэгш хамруулах боловсролыг хөгжүүлэх эрх зүйн буюу де юре орчин бүрдсэн тухай танилцуулаад, олон улсын болон үндэсний эрх зүйн тоймыг өгнө.

Дараа нь ХБХЭК, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн боловсролтой холбоотой зүйл заалтуудыг харьцуулан судалж, эргэлзээтэй асуудлуудаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхий хорооны зөвлөмжийг эш татан дүн шинжилгээ хийх замаар Улсын Их Хурал (УИХ)-аар 2016 онд баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан журам, удирдамжуудыг танилцуулж, давуу болон сул талыг гаргаж ярилцана. Эцэст нь тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай асуудал, зарчмуудтай танилцах замаар тэгш хамруулан сургах боловсролын тогтоолцоог бүхэлд нь зураглаж харна.

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ
БА ХҮНИЙ ЭРХ**

СУРГАЛТЫН МОДУЛИУД





Модуль 1. Хөгжлийн бэрхшээлийг хүний эрхийн байр сууринаас ойлгох нь

Модуль 1-ийг судалснаар оролцогчид хөгжлийн бэрхшээлд хандах хүний эрхийн хандлага, түүний талаарх хувьсан өөрчлөгдөж ирсэн ойлголт хандлагыг ялгаж, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудалд хүний эрхийн байр сууринаас хандах мэдлэгтэй болсон байна.



СЭДЭВ 1.1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ ХАНДЛАГУУД БА ХҮНИЙ ЭРХ

Хүний эрх бол хүний төрөлхийн заяагдмал хэрэгцээнээс эх үндэстэй бөгөөд хүн бүр нэр төртэй амьдрах ёстой хийгээд нэр төртэй амьдрахад хүн бүрт суурь нөхцөл, нөөц шаардлагатай болохыг энэхүү эрхээр хангаж, хүлээн зөвшөөрдөг. Хүний эрхүүд нь түгээмэл, төрөлхийн, салшгүй гэсэн мөн чанараараа бусад зарчмаас ялгаатай:

- **Түгээмэл эрх:** хүн бүр хүний бүхий л эрх, эрх чөлөөг ямар нэг ялгаварлалгүй, ямарваа ялгааг эс харгалзан адил тэгш эдэлнэ. Хүний эрх нь бүх хүнд ижил тэгш хамаарна.
- **Заяагдмал эрх:** хүн болж төрснөөр хүний эрхийг эдлэх эрхтэй болно.

- **Салшгүй эрх:** хүний эрхийг хүнд ямар нэг эрх мэдэл бүхий байгууллага, төр засгаас олгодоггүй, мөн хүнээс хүний эрхийг нь ямар нэг байгууллага, төр засаг салгаж авахгүй. Хүний эрх тань зөрчигдөж байхад ч Та эрхээ шаардаж, эдлэх эрхтэй.

Хүний эрхүүд нь салшгүй, харилцан хамааралтайн дээр нэг нь нөгөөдөө нөлөөлж байдаг мөн чанартай. Өөрөөр хэлбэл, хүний нэг эрхийг эхэлж хангаад нөгөөг дараа нь гэж хандах боломжгүй бөгөөд нэг эрх зөрчигдөхөд бусад эрх нь зөрчигдөх эрсдэлтэй. 1948 онд батлагдан, өдгөө 72 “нас хүрч байгаа” НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ) болон хүний эрхийн олон улсын бусад гэрээ, конвенц нь эрх эдлэгч иргэн нь хүний эрхүүдээ үүрэг хүлээгч төрөөс нэхэх боломжтой гэж тодорхойлдог.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусадтай адил тэгшээр хүний бүх эрхээ эдлэх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн заяагдмал хүний эрхүүдээ эдэлж, хэн нэгэн эрх мэдэлтэн юм уу, байгууллагаас түүнд эрхийг нь олгохыг хүлээлгүй, хүний эрхийг нь салгаж авахыг зөвшөөрөхгүй, нэр төртэй амьдрах эрхтэй. Нэр төртэй амьдрахад нь тодорхой суурь нөхцөл, нөөц шаардлагатай бөгөөд хүний эрхийг хүндэтгэн, хангаж, хамгаалах үүрэгтэй төрөөс эдгээр нөхцөл, нөөцийг шаардах эрхтэй. Харин өөр бусад хүний эрхийг зөрчилгүйгээр, өөрийн эрхийг хамгаалах нь хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй бүх хүний үүрэг юм.

Хөгжлийн бэрхшээлийг хүн төрөлхтөн түүхэн хөгжлийн явцад, өөр өөр соёлын орчинд янз бүрээр ойлгож ирсэн. Эдгээр ойлголт нь тухайн нийгэмд нийтлэг, давамгайл ойлголт болж төлөвшин, хөгжлийн бэрхшээлийн талаарх тухайн нийгмийн хандлага болж он удаан жилээр хадгалагддаг ажээ. Хөгжлийн бэрхшээлд хандах түүхэн хандлагуудад хүн төрөлхтний нийгэм, шинжлэх ухааны хөгжлөөс улбаатай хэвшмэл ойлголтууд (*bias*) маш хүчтэй туссан байдаг. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлийг бүрхны гэсгээл гэж ойлгож байсан европчууд

сэргэн мандалтын үед анагаах ухаан хөгжихийн хэрээр хөгжлийн бэрхшээл бие, сэтгэцийн эмгэг, согог гэсэн ойлголтоор халж, улмаар хөгжлийн бэрхшээлийг ойлгох өглөг хандивын загвар нь эмнэлгийн загвараар солигджээ. Монгол Улсад ч мөн Ардын хувьсгалаас өмнө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өглөг хандиваар тэтгэх соёл хот, хөдөөгүй өргөн тархсан байснаа орчин үеийн эмнэлгийн үйлчилгээ бий болсноор хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эмнэлэг, сувиллын үйлчилгээгээр хангах эмнэлгийн загвар давамгайлах болсон.

Ер нь хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрхийг хангуулахад тулгардаг хамгийн том саад бэрхшээл бол хөгжлийн бэрхшээлийн талаарх хүмүүсийн хандлага, хэвшмэл ойлголтыг өөрчлөх ажил байдаг. Тиймээс хөгжлийн бэрхшээлийн талаарх хандлагуудыг судлан, суурь хэвшмэл буруу ойлголт, үр дагаврыг нь ойлгож мэдэж байх нь чухал. Учир нь:

- “Хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт буюу загварууд нь хөгжлийн бэрхшээлийн тодорхойлолт болдог.
- Хөгжлийн бэрхшээлийн загварууд нь учир шалтгааны холбоос болох үүрэг хариуцлагын холбоосыг бий болгож өгдөг.
- Хөгжлийн бэрхшээлийн загварууд нь (төсөөлж буй) хэрэгцээнд суурилдаг.
- Хөгжлийн бэрхшээлийн загварууд бодлого боловсруулалт, хэрэгжилтийг чиглүүлдэг.
- Хөгжлийн бэрхшээлийн загварууд үнэт зүйлээс ангид биш.
- Хөгжлийн бэрхшээлийн загварууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх судалгааг эрдэм шинжилгээний аль салбар/чиглэл тэргүүлэхийг тодорхойлж өгдөг.
- Хөгжлийн бэрхшээлийн загварууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрсдийнх нь итгэл үнэмшил, өөрийн талаарх төсөөллийг бүрдүүлдэг.
- Хөгжлийн бэрхшээлийн загварууд ялгаварлан гадуурхалтын шалтгаан болж магад”¹

¹ <http://www.scielo.org.za/pdf/hts/v74n1/06.pdf>

Ингээд хөгжлийн бэрхшээл (ХБ)-ийн талаарх хамгийн нийтлэг тархсан загваруудтай танилцъя. (Хүснэгт 1, 2 - ыг харна уу).

Хүснэгт 1. Хөгжлийн бэрхшээлийн өглөг хандивын болон эмнэлгийн загвар

ХБ-д хандах хандлага	Хүний амьдралын хэв маягийн түвшин	ХБ-ийн талаарх хэвшмэл ойлголт	ХБ-тэй хүний дүр зураг	Монголын нийгэм, соёлын орчин дахь жишээ	Үр дагавар
Өглөг хандивын загвар	Биологийн түвшин	Зовлон, эмгэнэл	Үйлийн үрээ эдэлж зовж яваа амьтан	Дутуу заяатай, “аль насандаа хийсэн нүглээр” гэсэн ойлголт (өмнөх нас, энэ насанд хийсэн нүглийг амсаж байгаа учир хөгжлийн бэрхшээл бол үйлийн үр, үүнийг хүн өөрийн биеэр эдэлж дуусгах ёстой. Бусад хүн зовсон амьтантай буянаасаа хуваалцаж өглөг хандиваар дэмжвэл өөрт нь буян болно.	Өөрөө биш, асран хамгаалагч нь шийдвэр гаргадаг.
	Хувь хүний түвшинд	Асуудлыг нь өглөг, хандив, асрамж, халамжаар шийднэ	Хүнд нөхцөлд байгаа хохирогч, зовж буй амьтан	Чадахгүй гэснээс үүдэлтэй хүлээлтээ бууруулж, өөрсдөд нь эрх мэдэл олгодоггүй.	Халамж, асран халамжлагчаас хараат болно.

ХБ-д хандах хандлага	Хүний амьдралын хэв маягийн түвшин	ХБ-ийн талаарх хэвшмэл ойлголт	ХБ-тэй хүний дүр зураг	Монголын нийгэм, соёлын орчин дахь жишээ	Үр дагавар
	Нийгмийн түвшинд	Тусгаарлаж оролцуулахгүй	Нийгмийн халамжаар амьдрах хүн	Өөрөө чадваргүй тул төр халамжилж, “харж үзнэ”. Сурч, хөдөлмөрлөж чадахгүй гэсэн итгэл үнэмшлээс үр чадвар эзэмшихгүй, хөгжлийн гадна үлдэж ядуурах, нийгмээс тусгаарлагдах магадлалтай.	Хүний идэвх оролцоо хязгаарлагдана.
Эрүүл мэндийн (эмнэлгийн) загвар	Биологийн түвшинд	Бие махбодын функц/ажиллагаа алдагдсан, биеийн бүтэц нь “эвдэрсэн”, өвчилсөн.	Эмчилж хэвийн болгох, ядаж сүвилах ёстой бие эрхтний согогтой өвчтөн.	Эхлээд эмчилж, сайжруулах нь чухал гэж үздэг тул эмнэлэг, сувиллын үйлчилгээ давамгайл төлөвлөдөг. Эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэх, хэвийн болгох нь эн тэргүүний хэрэгцээ	Амьдрал, нийгмийн оролцооны талаарх гол шийдвэрийг эмч эмнэлгийн мэргэжилтэн гаргана.

Хүснэгт 1-ийн үргэлжлэл

ХБ-д хандах хандлага	Хүний амьдралын хэв маягийн түвшин	ХБ-ийн талаарх хэвшмэл ойлголт	ХБ-тэй хүний дүр зураг	Монголын нийгэм, соёлын орчин дахь жишээ	Үр дагавар
	Хувь хүний түвшинд	Үйлдлийн чадваргүй (хомсдолын хандлага)	Тахир дутуу, бусадтай харьцуулахад дутуу, сул дорой, өвчтөн	Согогийн улмаас тахир дутуу болж, сурч хөдөлмөрлөх чадваргүй, халамж аваад гэртээ суух нь дээр гэж үздэг. ХБ-гүй хүнтэй харьцуулж, чадвар алдсан хувь хэмжээг нь хэмжих, тоогоор илэрхийлэх, боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэхийг нь дэмжихийн оронд жилд нэг удаа сувилалд үнэгүй амраах зэрэг арга хэмжээ авдаг.	Өвчин эмгэг нь сурч хөгжих ажил эрхлэх боломжийг нь хязгаарладаг учир эмчлүүлж, эдгээж, хэвийн болгох ёстой.

ХБ-д хандах хандлага	Хүний амьдралын хэв маягийн түвшин	ХБ-ийн талаарх хэвшмэл ойлголт	ХБ-тэй хүний дүр зураг	Монголын нийгэм, соёлын орчин дахь жишээ	Үр дагавар
	Нийгмийн түвшинд	Бусадтай тэгш байхад нь саад болж буй хөгжлийн бэрхшээлийн шалтгааныг тогтоох, бэрхшээлийн төрөл тус бүрт тохирох шинжлэх ухаанч арга хэмжээ авах.	Өвчин эмгэгээ даван туулж нийгмийн амьдралд өөрөө дасан зохицох ёстой.	ХБ-тэй хэр нь ... гэсэн хандлага, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэж, тусгай төв, сургууль, эмнэлгээр хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ хүргэх тогтолцоо бий болгохыг эрмэлзэнэ.	Дасан зохицож чадсаныг нь магтан алдаршуулж, чадаагүйг нь шүүмжлэх хандлага гаргана.

Өглөг хандивын загварт шашны нөлөө их хүчтэй туссан байдаг бөгөөд орчин үеийн нийгэмд энэ загвар бараг мартагдсан хэдий ч суурь ойлголт нь тодорхой хэмжээнд оршин тогтносоор байгаа бөгөөд энгийн/ердийн болон тусгай хэрэгцээ, “хөгжлийн бэрхшээлтэй хэр нь...” зэрэг үг хэллэгээр илэрдэг.

Хөгжлийн бэрхшээлд хандах өглөг хандивын загварын нэг хэлбэр нь эмнэлгийн загвар юм. Энэ загвараар хөгжлийн бэрхшээлийг өвчин зовлон гэж ойлгон, хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралыг эмч нар шийддэг онцлогтой.

Хөгжлийн бэрхшээлд хандах дээрх хоёр хандлага нь ялгаварлан гадуурхалтад хүргэх эрсдэл агуулж байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бусдаас дутуу,

бусадтай адил байж чадахгүй, ур чадваргүй гэж хандан, өөр хэн нэгний халамжид амьдруулах нь хүний эрхийн зөрчилд хүргэх эрсдэлтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүний заяагдмал, түгээмэл эрхийг нь хязгаарлан, хэн нэгний халамжид оруулан, шийдвэр гаргах, оролцох эрхийг нь хохироох эрсдэлтэй энэ хоёр хандлага аажмаар суларч байгаа ч өнөөдөр ялангуяа нийгмийн салбарт хүчтэй хэвээр байна.

Харин хүний эрхэд суурилсан, хүн бүрийн эрх тэгш байдлыг хүлээн зөвшөөрсөн хандлагаар хөгжлийн бэрхшээлийг хэрхэн ойлгож болохыг Хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2. Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн болон хүний эрхийн загвар

Хөгжлийн бэрхшээлд хандах хандлага	Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт	Хөгжлийн бэрхшээлтэй хүний дүр зураг	Монгол дахь жишээ	Үр нөлөө
Нийгмийн загвар	Эмгэг бол хүний мөн чанар, хөгжлийн бэрхшээл бол орчны саад, хөгжлийн бэрхшээл нь хүнийг бүхлээр нь тодорхойлохгүй.	Эмгэг согогоос үүдэлтэй хэрэгцээг нь дэмжсэн орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хөгжин, нийгмийн оролцоотой байна.	Хөгжлийн бэрхшээлийн шалтгаан болж байгаа хүртээмжийн саадуудыг арилгаж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хүлээн зөвшөөрч, оролцоог хангах ажил эхэлсэн.	Тохирох хэрэглэгдэхүүний ойлголт бүрэлдэн бий болж байгаа бөгөөд эмгэг согогоос үүдсэн хэрэгцээг хангахад чиглэсэн нэмэлт болон туслах хэрэгсэл, үйлчилгээ, программ хангамжийн дэмжлэгтэйгээр нийгмийн амьдралд хөгжлийн бэрхшээлтэй хүний бүрэн дүүрэн оролцох боломжийг бүрдүүлнэ. Тохирох хэрэглэгдэхүүн нь хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хязгаарлаж байгаа саадыг арилгах ба саад гэдэгт биет орчин, мэдээлэл, эрх зүйн, хандлагын саад тотгорууд багтана.

Хөгжлийн бэрхшээлд хандах хандлага	Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт	Хөгжлийн бэрхшээлтэй хүний дүр зураг	Монгол дахь жишээ	Үр нөлөө
Хүний эрхийн загвар	Хөгжлийн бэрхшээл бол хүний ялгаатай байдлын нэг хэлбэр учир хүрээлэн буй орчныг бүрдүүлэхдээ бүх хүнд ээлтэй байхыг тооцоолж, түгээмэл загварыг нэвтрүүлэх.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн ээлтэй орчинд бусдаас хамаарахгүй бие даан амьдрах эрхтэй, боломжтой.	Тохируулгаар хангадсанаар хөгжлийн бэрхшээлтэй хүн бусадтай адил нийтийн үйлчилгээнээс үр ашиг хүртдэг.	Нийгмийн загвар хүрээлэн буй орчны саад нь асуудал үүсгэдэг гэж үздэг бол хүний эрхэд суурилсан хандлага нь ялгаварлан гадуурхалт асуудал үүсгэдэг гэж үздэг. Манай улсад хөгжлийн бэрхшээлийг хүнд, хөнгөж гэж ялгах, тусгай сургуульд хөнгөвчилсөн хөтөлбөрөөр сургах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байр, үйлдвэр барих зэрэг хандлага нь хүний эрхийн хандлага төлөвшөөгүй байгаагийн жишээ болно.

Нийгмийн болон хүний эрхийн загвараар харах юм бол хөгжлийн бэрхшээл нь нийгмийн олонхын зүгээс бий болгосон сул тал, жинхэнэ утгаараа нийгмийн олонхын дарангуйллын нэг хэлбэр гэж судлаачид тайлбарладаг. Тухайлбал, хүний бие, мэдрэхүй, оюуны согогийн нийгмийн бий болгосон саад тотгор буюу хөгжлийн бэрхшээлээс салгаж ойлгох нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангаж, хамгаалахад хамгийн гол түлхүүр болно гэж үзжээ (Schipper, 2006). Хүний бие, үйлдлийн согогоос үл хамааран нийгмийн амьдралд оролцох эрх нь бусадтай ижил тэгш байх ёстой бөгөөд нийгэм нь харин согогоос үүдэлтэй онцлог хэрэгцээг нь хангаж, саад болохгүй орчин бий болгох, шаардлагатай бол согогоос нь үүдсэн онцлог хэрэгцээнд нь тохирох хэрэглэгдэхүүн бий болгох хэрэгтэй юм.

Дасгал 1.1.1.

Дараах асуултуудад хариулна уу?

1. Танд хөгжлийн бэрхшээлийн аль загвар хамгийн ойлгомжтой байна вэ? Яагаад? Энэ нь таны хамгийн ихээр дэмжиж байгаа загвар мөн үү? Яагаад?
2. Таны бодлоор, манай улсад өнөөдөр хамгийн хүчтэй, нийтлэг нь аль загвар вэ? Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хэвлэл мэдээлэл, хөдөлмөр эрхлэлт гээд тодорхой салбарт аль загвар нь давамгайлж байна вэ? Та энэ байдлыг зөв зүйтэй гэж дэмжиж байна уу? Яагаад?
3. Одоо дээрх 4 загвар бүр нь хөгжлийн бэрхшээлийн тодорхойлолт, учир шалтгааны холбоос болох үүрэг хариуцлагын холбоос, (төсөөлж буй) хэрэгцээ, төрийн бодлого боловсруулалт, түүний хэрэгжилт, үнэт зүйлс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх судалгааг эрдэм шинжилгээний аль салбар/чиглэл тэргүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрсдийнх нь итгэл үнэмшил, өөрийн талаарх төсөөлөл, мөн ялгаварлан гадуурхалтын шалтгаан болж байгааг тодорхой жишээгээр тайлбарлана уу? Доорх матрицыг ашиглаж болно.
Дээрх 4 загвараас гадна эдийн засгийн загвар (улс орон, өрх гэрийн эдийн засагт хувь хүний оруулах хувь нэмрийг чухалчлах хандлага), экспертийн загвар (эмнэлгийн загварын нэг салаа, хөгжлийн бэрхшээлээр тусгайлан бэлтгэгдсэн, мэргэшсэн мэргэжилтнүүдэд даатгах хандлага) зэргийг доорх матрицын дагуу судалж үзээрэй.

Дасгал 1.1.1-ийн үргэлжлэл

Хөгжлийн бэрхшээлийн загвар	Өглөг хандивын загвар	Эмнэлгийн загвар	Нийгмийн загвар	Хүний эрхийн загвар
Нөлөө				
Хөгжлийн бэрхшээлийн тодорхойлолтод хэрхэн нөлөөлөх				
Хөгжлийн бэрхшээлийн шалтгаан, хариуцлагыг хэрхэн тайлбарлах				
Хөгжлийн бэрхшээлтэй хүний (төсөөлж буй) хэрэгцээг хэрхэн ойлгуулах				
Тухайн загварт шингэсэн үнэт зүйлс буюу хэвшмэл ойлголт (<i>bias</i>)				
Энэ загвараар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх судалгааг эрдэм шинжилгээний аль салбар/чиглэл тэргүүлэх вэ?				
Энэ загвар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрсдийнх нь итгэл үнэмшил, өөрийн талаарх төсөөлөлд хэрхэн нөлөөлөх вэ?				
Энэ загвар нь ялгаварлан гадуурхалтын шалтгаан болж буй жишээ				



**СЭДЭВ 1.2: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХ БА
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТАЛААРХ ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТ,
ТЭДГЭЭРИЙН ҮР ДАГАВАР**

Хөгжлийн бэрхшээлийн талаарх бидний ойлголт, хандлага бүрэлдэхэд зөвхөн дэлхий нийтийн мэдлэг, шинжлэх ухааны дэвшил, үйл явдлууд төдийгүй үндэсний соёл, орон нутаг, гэр бүлийн соёл, хувь хүний итгэл үнэмшил хүчтэй нөлөөлдөг. Хувь хүн өөрөө анзаарахгүй хэр нь соёлын хэм хэмжээ, тухайн нийгэмд давамгайлж байгаа итгэл үнэмшил нь нийгмийн тодорхой бүлгүүдийн нийгмийн оролцоог дэмжих юм уу, хязгаарлах нөлөө үзүүлж байдаг бөгөөд зарим сөрөг ойлголт, хэвшмэл хандлага нь хөгжлийн бэрхшээлээр гадуурхах шалтгаан болж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн оролцоо, өдөр тутмын амьдралд сөргөөр нөлөөлөх магадлалтай.

Дэлхийн өнцөг булан бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өдөр тутамдаа сөрөг хандлагаас үүдэлтэй саад тотгортой учирч, ялгаварлан гадуурхалт, дарамт, хүлээн зөвшөөрөгдөхгүй байх, оролцооны хязгаарлалт, тэр ч байтугай бүр айдастай нүүр тулж байна. Сөрөг, үл дэмжих хандлагын улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ авах, нэр төртэйгөөр хөдөлмөр эрхлэх, амьдрах газар болон хамтран амьдрах хүнээ сонгох, гэрлэж гэр бүлтэй болох, өөрийн орондоо эрх чөлөөтэйгөөр зорчих боломж хязгаарлагдаж, хүнээс хараат болох, хүчирхийлэлд өртөх, хамгаалалтгүй болох эрсдэл нэмэгддэг.

Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт нь тодорхой бүс нутаг, тэр ч байтугай тодорхой улс орны хүрээнд нэгэн жигд байдаггүй. Зарим хүн, бүлгүүд олон нийт, орон нутаг, өөрийн гэр бүлийн хүрээнд давамгайлж байгаа ойлголт хандлагаас өөр итгэл үнэмшилтэй байж болно. Монгол Улсад ч бас хөгжлийн бэрхшээлийн талаар эерэг болон сөрөг хандлага, итгэл үнэмшилтэй янз бүрийн хүмүүс, бүлгүүд байгаа бөгөөд бидний хийж чадах хамгийн чухал зүйл бол сөрөг итгэл үнэмшлээ илрүүлж ойлгон, засаж авахын зэрэгцээ эерэг хандлага ойлголтоо мөн л илрүүлж ойлгон, тараан түгээх, бусдад мэдүүлэн манлайлах явдал юм. Хандлага, ойлголт, итгэл үнэмшил нь бодлого, шийдвэрт нөлөөлж, арга хэмжээний суурь болдог тул сөрөг хандлагаа ойлгож хязгаарлах, эерэг итгэл үнэмшлээ ойлгож түгээх нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, баталгаажуулахад дэм болно.

Дасгал 1.2.1

Хөгжлийн бэрхшээлийн талаарх манай нийгмийн сөрөг хандлага

Доорх жишээтэй танилцаад, түүний шалтгаан, үр дагаврыг тодорхойлно уу. Дасгал жишээн дээр ажиллахдаа дээр танилцуулсан хөгжлийн бэрхшээлд хандах 4 хандлагыг ашиглан, тухайн жишээн дээр аль хандлага илүү нөлөөлж, үүнээс болж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчийн амьдралд ямар нөлөө бий болж байгаа тухай бодоорой.

- Манай сумын бүх хүүхэд сургуульд явж байгаа. Сургуульд явдаггүй 10-аад л хүүхэд бий, бүгд хөгжлийн бэрхшээлтэй, албан ёсны оноштой, сурч чадахгүй.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ Улаанбаатарт тусгай сургуульд өгөхийг эцэг эхэд нь зөвлөсөн. Тэнд хүүхдэд нь хэрэгтэй орчин байгаа, багш нар нь мэргэшсэн хүмүүс. Манай орон нутгийн сургуулиас хамаагүй дээр сургаад өгнө.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн хүүхэд төрүүлж чадахгүй, өсгөж чадахгүй. Хүүхэд маш их анхаарал, арчилгаа шаардана. Ээж нь харж дийлэхгүй.
- Манайх удам сайтай айл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гарах нүгэл хийгээгүй.
- Хөгжлийн бэрхшээлтэй хэр нь хөдөлмөр эрхлэхийг хүсэж байгаа энэ хүнд нэг компани нийгмийн хариуцлагынхаа хүрээнд ажлын байр гаргаж өгөөд, нэг ч гэсэн хүнд тусламжийн гараа сунгахыг уриалж байна.
- Аав ээж нь асуудалтай, архи уудаг болохоор хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй төрсөн байх.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажил хийж чадахгүй болохоор халамжийг нь сайн нэмээд, гэртээ суух боломжийг хангаж өгөх хэрэгтэй.

Дасгал 1.2.1-ийн үргэлжлэл

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бол төрөөс харж үзэх шаардлагатай бүлэг мөн. Байр орон сууц барьж өгдөггүй юмаа гэхэд сайхан асрамжийн газар бариад, мэргэжлийн үйлчилгээ, асаргаагаар хангах ёстой юм биш үү?
- Энэ хүүхэд маань хөгжлийн бэрхшээлтэй, би өмнөөс нь ярья.
- Чи хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд өсгөж чадахгүй учраас хэнээс ч хамаагүй хүүхэд гаргаад, эцэг эхийгээ амьд дээр нь өсгүүлээд ав.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй нэг ангид хүүхдээ сургахгүй ээ. Гэнэт уурлаад, цохиод авбал яах вэ? Манай хүүхэд энэ жил олимпиадад орно, багш нь бэлтгэх ёстой. Багш хамаг цагаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулах хэрэгтэй болно.
- Манай хорооны байр гаднаа тэргэнцрийн зам барьсан, хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний оролцоог хангаж байна.
- Эцэг эхчүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ нуудаг байсан. Одоо нуух явдал багасаж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан өдөрлөг хийж, хорооны хэмжээнд байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нэг өдөр баярлуулж, аж ахуйн нэгжүүдээс бэлэг гардуулсан.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн яагаад харуул манаа, цэвэрлэгээний ажил хийж болохгүй гэж?
- Хөгжлийн бэрхшээлтэй энэ хүнийг дагуулж яваа хүнтэй нь уулзаж, эрүүл мэндийн байдал, эмчилгээг нь сайн зааж өгье.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ нуудаг байсан.
- Танай хүүхэд үзэг барьж чадахгүй болохоор энэ жил 1-р ангид өгөлгүй, сайн эмчлүүлж байгаад дараа жил ирээрэй.
- Энэ залуу хөгжлийн бэрхшээлтэй, мөнгөө хянаж чадахгүй, ээжийг нь дуудаад цалинг нь өгчих.

Өдөр тутмын амьдрал дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ийнхүү нийгэм, бусад хүмүүсийн зүгээс сөрөг хандлага, хэвшмэл буруу ойлголттой тулгардаг. Энэ ойлголт, хандлага нь мөн урлагийн салбарт хадгалагдаж, уран сайхны бүтээлүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг чадваргүй, сул дорой, бусдаас дутуу байдлаар дүрслэн харуулах нь бий. Уран сайхны бүтээл нь хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөж, сэтгэлд нь хоногшдог тул хөгжлийн бэрхшээлийн талаарх сөрөг хандлага, буруу ойлголтыг улам бэхжүүлэх, дараагийн үед дамжуулан, өргөн хүрээнд тараан түгээх өндөр эрсдэлтэй. Харин уран сайхны бүтээл нь хөгжлийн бэрхшээлийг хүний эрхийн хандлагаар ойлгох үзэл баримтлалыг түгээж чадах юм бол хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалахад дэмжлэг болж чадна. Энэ утгаараа хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өргөн олон түмэнд хүрдэг, уран сайхны биш ч гэлээ цаг үеийн мэдээллийн найдвартай эх сурвалж болдог утгаараа хөгжлийн бэрхшээлд хандах хүний эрхийн хандлагыг баримтлах нь чухал юм. Сэтгүүлчийн өөрийнх нь хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт, төсөөлөл, туршлага нь түүний нийтлэл, сурвалжилга, мэдээнд тусаж байдаг тул сэтгүүлчид ч хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар хангалттай сайн мэдлэг олж авсан байх нь чухал.

Дасгал 1.2.2.

**Урлагийн бүтээл, хэвлэл мэдээлэл дэх хөгжлийн
бэрхшээлтэй хүний дүр төрх**

Дараах нийтлэл/киноны хэсэгтэй танилцаад, хөгжлийн бэрхшээлтэй хүний ямар дүр төрх бүтээж байгаа, энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хэрхэн нөлөөлөх, хөгжлийн бэрхшээлд хандах ямар хандлагад суурилсан байгаа тухай тэмдэглэл бичээрэй.

- Эрүүл мэндийн яам, Итали Улсын төрийн бус АИФО байгууллагаас Дорнод аймагт “Тэгш дүүрэн” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд удаагүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм хамт олонд нь түшиглэн сэргээн засах зорилготой тус хөтөлбөрт аймгийн хэмжээнд 29,925 иргэн хамрагджээ.
- “Илүү сартай зун” киноны хэсэг

Хөгжлийн бэрхшээлийн талаарх сөрөг, буруу ойлголт хандлагыг улам бэхжүүлэх нөлөө үзүүлдэг өөр нэг чухал домэйн бол төрийн бодлого юм. Бодлого, шийдвэрийг төрийн албан тушаалтан гаргадаг бөгөөд тухайн хүний өөрийнх нь итгэл үнэмшил, хэвшмэл ойлголт нь бодлогын шийдэл, хувилбарыг сонгоход нөлөө үзүүлдэг. Гагцхүү сонгосон шийдвэр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхээ эдлэхэд дэм, эсвэл саад болно.

Дасгал 1.2.3.

Дараах шийдвэрүүд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэрхэн нөлөөлж болохыг ярилцана уу?

Тэргэнцэртэй хүн нийтийн унаагаар харгалзан дэмжих хүнтэй зорчих журам Улаанбаатар хотод 2010 он хүртэл үйлчилж байсан.

- ... хөтөлбөрийн хүрээнд 2006 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн тушаалаар “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг илрүүлэх” судалгааны болон тайлангийн маягтыг баталсан (тайлангаас);
- Ерөнхий боловсролын тусгай сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх, бие даалгах үйлчилгээ үзүүлж, бага, суурь, бүрэн дунд боловсрол болон, мэргэжил эзэмшүүлэх сургалтын байгууллага мөн (Бага, дунд боловсролын тухай хуулийн 13. 1 дүгээр заалт);
- Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоодог бөгөөд хөдөлмөрийн чадвараа 0-50%, 50-69%, 70-100% алдсан хэмээн 3 ангилдаг.
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч этгээд монгол хэл мэдэхгүй бол өөрийн эх хэл буюу мэддэг хэл, бичгээр, хэрэв хараагүй, хэлгүй, дүлий зэрэг шалтгааны улмаас төрийн албан ёсны хэл, бичгээр харилцаж чадахгүй бол дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан шүүхэд тайлбар, мэдүүлэг өгөх, үг хэлэх, нотлох баримт гаргаж өгөх эрхтэй (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.2).

Ихэнхдээ хөгжлийн бэрхшээлийн талаарх сөрөг ойлголт хандлага нь хөгжлийн бэрхшээлийн төрөл хэлбэрээр ялгаатай байдаг. Сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамгийн их сөрөг хандлагатай тулгардаг. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс илүү их ялгаварлалтад өртдөг бол олдмол бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн дэмжлэг, сүлжээ нь хүчтэй хэвээр байдаг тул нийгмээс тусгаарлагдах нь арай бага байх хандлагатай. Нийгэм, эдийн засгийн байдал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст давхар нөлөөлдөг бөгөөд орлого багатай, ядуу өрхийн хүмүүс ижил хөгжлийн бэрхшээлтэй ч боломжийн амьдралтай нэгнээсээ илүү их ялгаварлагдах эрсдэлтэй ажээ.

Хөгжлийн бэрхшээлийн талаарх буруу, ташуу ойлголт, сөрөг хэвшмэл хандлагыг өөрчлөх, даван туулах нь амаргүй боловч итгэл үнэмшлийг өөрчилж болох бөгөөд цаг хугацааны явцад тэдэнд хандах соёлыг өөрчилж болно.

Тэгвэл хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх ойлголт ямар байвал эерэг гэж үзэх вэ? Хөгжлийн бэрхшээлийн талаарх хүний эрхийн хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бусдаас ялгахгүй, эрх тэгш байх үзэл баримтлал байдаг бол нийгмийн хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүрэн дүүрэн оролцоог хангах арга хандлага болдог байна. Жишээлбэл, хүний эрхийн хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүний эрхээ төрөөр хүндэтгүүлэх, хангуулах, хамгаалуулах эрхтэйг тунхаглаж, нийгмийн хандлагаар хөгжлийн бэрхшээлтэй хүний бүрэн дүүрэн оролцоо, эрх тэгш байдалд саад болж байгаа саад тотгоруудыг арилгахыг зорино.

Тэргэнцэртэй хүн хүнсний дэлгүүр орох гэтэл шат нь саад болоод орж чадсангүй. **Эмнэлгийн загвараар** тэргэнцэртэй хүнийг хөл дээр нь босгох боломжийг эрэлхийлж онош тавих, эмчлэх оролдлого хийх бөгөөд энэ нь буруу биш боловч эмчлүүлж байх хугацаанд дэлгүүр орох боломжийг нь хангах шийдэл хайхгүй, мөн эмчилж чадахгүй бол “эмчилгээгүй” гээд гаргах бөгөөд дэлгүүр орж чадахгүй байгаа асуудал нь шийдэгдэхгүй. Тэргэнцэртэй тэр хүн өөрөө гэртээ суугаад, өөр хэн нэгэн хүнийг гүйж дэлгүүр явуулах болно. Харин **Хүний эрхийн загвараар** тэргэнцэртэй хүн нийтийн үйлчилгээгээр үйлчлүүлж чадахгүй байх, наад захын хэрэгцээгээ хангахдаа хүнээс хараат болох, өөрийн мөнгийг хүнд найдаж өгөх, өөрөө сонголт хийж чадахгүй түүний өмнөөс бусдын хийсэн сонголтоор амьдарч байгаа зэрэг асуудлууд тодорхой харагдах юм. Тухайн орон нутгийн хүмүүс бүгд дэлгүүрээр үйлчлүүлж байхад тэргэнцэртэй хүн шатнаас болоод чадахгүй байгаа нь хүний эрхийн зөрчил мөн. Энэ хүний жишээн дээр төр засагт хандаж иргэнийхээ эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх арга хэмжээ авхуулаад зогсохгүй бусад орон нутагт байгаа бүх ийм зөрчлийг арилгах бодлого, стандарт гаргуулна.

Үүнтэй зэрэгцээд нийгмийн загвараар энэ тохиолдолд ямар арга хэмжээ авах ямар саад учирсныг тогтоож, байшин барилгын стандартуудаа эргэн харж, шатгүй байшин барилгатай болох, боломжгүй тохиолдолд шат ашиглахгүйгээр орж, гарч болох шийдлийг шаардлага болгож нэвтрүүлэн, нийтийн үйлчилгээний бүх байшин барилгадаа үзлэг хийх, ажиллаж байгаа хүмүүстээ тайлбарлан хандлагыг нь өөрчлөх зэрэг ажил өрнөнө. Энэ бол энгийн жишээ бөгөөд нийгмийн амьдралын бүхий л салбар, чиглэлд ашиглаж болох загвар юм.

Нийгмийн амьдралд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс оролцох нь зөвхөн тэдний амьдралын чанарыг сайжруулаад зогсохгүй нийгмийн амьдралд тэдний оруулах хувь нэмэр нэмэгдэхийн хэрээр татварын бааз суурь тэлж, халамжид зарцуулах төсөв багасаж нийгмийн бүтээмж өсөж, нийгмийн ялгаварлал буурч, эв нэгдэл бий болно гэх мэтчилэн маш олон эерэг үр дүн гарна.

Хөгжлийн бэрхшээлд хандах хүний эрхэд суурилсан нийгмийн загвар нь өөрт хамаатай амьдралын аливаа асуудлаар бусадтай ижил тэгш байдлаар сонголт хийх хувь хүний боломжийг хязгаарлаж байгаа саад тотгоруудыг арилгах явдал юм. Энэ нь хөгжлийн бэрхшээлийг нь бус, харин хүнийг өөрийг нь хардаг хандлага тул оролцож чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал гэж үзэлгүй, харин ялгаатай хэрэгцээг тооцолгүй бий болгосон орчныг өөрчлөх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангахыг зорьдог загвар юм. Энэ бол жинхэнэ утгаараа хүн төвтэй хөгжлийн хандлага. Ер нь зарим хүний хэрэгцээнд нийцээгүй орчин бий болгоод, түүнийг ашиглаж чадахгүй байгаа нэгнийгээ сул дорой, чадваргүй гэж хандах нь Орос ардын үнэг, тогорууны үлгэрийг санагдуулна.

Дасгал 1.2.4.

“Үнэг, тогоруу хоёр” үлгэрийг уншаад/ сонсоод ярилцах

Унших:

<http://khuukhed-khugjil.mn/content>Сонсох: <https://www.youtube.com/watch?v=ed0nbrRdNGM>

Нарийн хүзүүтэй вааранд л хоол хийгээд байвал үнэг өлсөх, харин хавтгай тавагт хийгээд байвал тогоруу өлсөх, гэтэл уг нь хоол бэлэн, хэмжээ хангалттай. Энэ нийгэмд зөвхөн “үнэгнүүдийг” анхаараад байвал тогоруунууд яах вэ? Цөөн хэдэн “үнэг” баахан “тогоруун” дунд амьдарвал “тогоруунууд” нийгэм орчноо нарийн хүзүүтэй ваарнуудаар дүүргээд, түүнээс хоол хүртэж чадахгүй байгаа нь “үнэгний” буруу гэх нь зөв үү? Ярилцацгаая.



СЭДЭВ 1.3: ОРОЛЦООНЫ СААД ТОТГОР, ХҮРТЭЭМЖГҮЙ БА ХҮРТЭЭМЖТЭЙ ОРЧИН

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бэрхшээлгүй бүх хүний нэгэн адил эрүүл байх, сайн сайхан байх, эдийн засаг, нийгэм, улс төрийн амьдралд оролцох, сурах, чадвараа хөгжүүлэх, ажилтай байх зэрэг хэн бүхэнд ойлгомжтой хэрэгцээтэй. Иргэдийнхээ энэ хэрэгцээг хангахад улс орнууд янз бүрийн тогтолцоо, салбар, үйлчилгээг хөгжүүлж, бүх иргэн ижил тэгшээр оролцох боломжийг хангахыг хичээдэг. Харамсалтай нь, амьдралд ийм шударга, эрх тэгш нийгэм цөөн бөгөөд ихэнх улс оронд зарим хүний нийгмийн оролцоог хязгаарласан саад тотгорууд оршсоор байна. Эдгээр саад тотгор нь хөгжлийн бэрхшээлтэй, ядуу, шилжин суурьшсан, үндэсний цөөнх, зарим оронд эмэгтэйчүүд зэрэг эмзэг бүлгийнхэнд илүү хүчтэй нөлөөлдөг.

Оролцох, хамрагдах боломжийг **хүртээмж** гэсэн нэр томъёогоор илэрхийлдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүний нийгмийн оролцоог хязгаарладаг, гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамгийн нийтлэгээр тохиолддог хүртээмжийн саад тотгоруудыг судлаачид 4 бүлэглэжээ.

Биет саад: Энэ бол хүрээлэн буй орчны аливаа саад, үүний дотор барилга байгууламж, дэд бүтцийн саадууд юм. Эдгээр нь нүдэнд ил байдаг тул хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай ярианд хамгийн түрүүнд хөндөгддөг асуудал. Жишээлбэл, тэргэнцэртэй хүнд байшин руу орох, гарах шат, өрөөний үүдний босго, тэргэнцэр багтах ааргүй нарийхан хаалга, замын хашлага, давчуу ариун цэврийн өрөө саад болох бол хараагүй хүнд явган зам дээр тавьсан сурталчилгааны самбарыг тойрч гарах, том эмнэлгийн байшин дотор чиглүүлэгч байхгүй буюу байсан ч ойлгож хэрэгтэй газраа олж очиход бэрхшээл үүсгэнэ. Нүдэнд тусахгүй биед саадууд бас байдаг ба жишээлбэл, ихэнх одой хүнд хаалганы бариул хэт өндөрддөгийг бид тэр бүр анзаардаггүй.

Мэдээллийн саад: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мэдээллээс хоцорсны улмаас үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдаж чадахгүй үлдэх нь элбэг. Тэдэнд мэдээллийн хэлбэр болон агуулгын аль аль нь саад учруулах магадлалтай. Жишээлбэл, жижиг үсгээр бичсэн, ялгарал муутай зар, телевизийн дүрсэн мэдээ нь харааны бэрхшээлтэй хүмүүст хүртээмжгүй байна. Бас аман мэдээлэл нь сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжгүй байдаг. Энгийн хэл найруулгад оруулаагүй мэдээллийг оюуны бэрхшээлтэй хүмүүс ашиглаж чадахгүй. Тодорхой нэг газар, жишээлбэл, хороон дээр очиж мэдээлэл авахаар зохион байгуулбал хөдөлгөөний хязгаарлалттай хүнд бэрхшээл болно.

Институцийн саад: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо, хүртээмжийг шууд болон шууд бусаар хязгаарласан хууль, дүрэм, журам, процедурууд үүнд багтана. Жишээлбэл, саяхныг хүртэл хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврээр үйлчлүүлэхдээ заавал туслах хүнтэй явах журам нийслэлийн хэмжээнд үйлчилж байсан бөгөөд дагуулаад явах хүн байхгүй үед хөгжлийн бэрхшээлтэй хүн явах боломжгүй болдог байв. Автобусны жолооч ийм туслахгүй яваа хүнийг орхиод явдаг байсан үе саяхан. Хориглох, эсвэл дэмжихгүй байхын зэрэгцээ эс үйлдэл нь институцийн хамгийн том бэрхшээл болдог. Тухайлбал, дохионы хэлний орчуулгагүй телевизийн мэдээ, УИХ-ын чуулганы дамжуулалт, шүүх хурал нь сонсголгүй хүмүүст хүртээмжгүй, сонгуулийн үеэр харааны бэрхшээлтэй хүн саналаа хэрхэн өгөх зохицуулалт байхгүй үед тэд улс төрийн эрхээ эдэлж чадахгүйд хүрч байжээ.

Хандлагаас үүдэлтэй саад: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамгийн их тохиолддог саад бол бусад хүний хандлагатай холбоотой байдаг. Хөгжлийн бэрхшээлийн талаар буруу ойлголттой, тэднийг сул дорой, шийдвэр гаргаж чадахгүй, ойлгохгүй гэсэн итгэл үнэмшлээрээ, эсвэл нийгэмд төлөвшсөн хэвшмэл ойлголтын нөлөөгөөр өөрөө ч анзааралгүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлах үйлдэл гаргах нь бий. Жишээлбэл, эмч үзүүлэхээр ирсэн хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй биш дагаж

яваа хөгжлийн бэрхшээлгүй хүнтэй харьцаж өмнөөс нь шийдвэр гаргах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сурч чадахгүй гэж бодсоны улмаас сургуульд авахгүй, авсан ч сурлагын амжилтад анхаарахгүй байх явдал түгээмэл байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн үйлчилгээ, нийтийн арга хэмжээнд хамруулах зохицуулалт хийхийн оронд “тусгай үйлчилгээ”-нд хамруулах нь хамгийн түгээмэл хандлага бөгөөд тусгай буюу параллель үйлчилгээний тогтолцоо нь нийтийн үйлчилгээг чанарын хувьд гүйцдэггүй, өртөг зардал нь өндөр, нийгмийн ялгаварлалыг бий болгох эрсдэлтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахтай холбоотой нэг асуудал бол хүртээмжтэй орчин буюу бүх нийтийн үйлчилгээ, нийгмийн амьдралд оролцоход саад болж байгаа зүйлсийг арилгах явдал юм. Давтан хэлэхэд, хүртээмжтэй орчин бол зөвхөн биет орчноор хязгаарлагдахгүй мэдээллийн, институцийн болон хандлагаас үүдэлтэй саадүүдыг арилгахыг шаардана.

Хүн бүрийн хэрэгцээ өөр. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ч нэгдмэл нэг бүлэг биш, харин олонлог юм. Энэхүү ялгаатай хэрэгцээг нийтээр нь хангах боломжтой юу? Хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй олон хүнд хүртээмжтэй арга хэлбэр байж болох уу?

Олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд түгээмэл (нийтлэг) загвар гэсэн ойлголт байдаг.

Түгээмэл загвар (***universal design***) гэж ямарваа нэг нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардагдахгүйгээр бүх хүн ашиглахад хамгийн дээд зэргээр тохиромжтой байж болох бүтээгдэхүүн, байрлал, программ болон үйлчилгээний хэв маягийг хэлдэг ажээ. Дэлхийн олон оронд шинэ бүтээгдэхүүн, хөтөлбөр, үйлчилгээ бий болгохдоо, шинэ барилга байшин, спортын байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, сургууль, эмнэлэг барихдаа түгээмэл загвартай байх шаардлага ч тавьж эхлээд байна. Түгээмэл загвар ямар байх ёстойг зарчмын хувьд дараах байдлаар тодорхойлдог:

- Тэнцүү ашиглах боломжтой (янз бүрийн чадавхтай хүмүүст хэрэгтэй, худалдан авах сонирхлыг төрүүлэх дизайнтай байх);
- Хэрэглээний хувьд уян хатан байх (загвар нь олон хүний хэрэгцээ, сонирхол, чадавхад нийцсэн байх);
- Энгийн бөгөөд ойлгомжтой (загварын зориулалт, ажиллагааг ойлгоход амар, хэрэглэгчийн мэдлэг, туршлага, хэлний чадвар, боломж зэргээс хамааралгүй байх);
- Мэдээллийг хүлээж авахад хялбар байдлаар хүргэх (загвар нь шаардлагатай мэдээллийг оновчтой хүргэж чаддаг байх, хэрэглэгчийн тухайн үеийн нөхцөл байдал, мэдрэх чадвараас хамаарахгүй байх);
- Алдааг тэсвэрлэх чадвар (болгоомжгүй, санаандгүй үйлдлээс гарах аюулт болон сөрөг үр дагавар хамгийн бага байх);
- Биеийн хүч бага шаардахаар байх (биеийн хүчийг аль болох шаардахгүйгээр үр ашигтай, биед тавтай хэрэглэж болохуйц байх);
- Ашиглах, хүрч очиход тохиромжтой хэмжээ, орон зайтай байх (хэрэглэгчийн бие, чадавхаас үл шалтгаалан хүрч очих, авах, өөрчлөн ашиглах боломжтой хэмжээ, орон зайтай байх).

Түгээмэл загвар бол зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан нэмэлт арга хэмжээ биш гэдэг нь дээрх тайлбараас тодорхой харагдаж байна. Жишээлбэл, их хүч шаардагдахгүй байх нь өндөр настай хүн, хүүхэд, бие нь муу байгаа хүмүүст өгөөжтэй. Зураг дээрх хайч нь энгийн хайч хэрэглэж чаддаггүй солгой хүмүүст бас хэрэгтэй загвартай хайч юм.



Бодит амьдралын зарим жишээ:

- 4 ширхэгтэй Панасоник хуруу зайны баглаа боодол нь цоолбортой тул үрж салгах, онгойлгоход хүч орохгүй, ойлгомжтой, гадна тал дээрээ “шинэ” гэсэн бичигтэй тул хуучин зайтай андуурагдахгүй байх давуу талтай.²
- “Явган хүнд ээлтэй байдлын аудит”арга зүй. Ирландын 8 хотыг хамруулан 2014 онд хийсэн энэ үйл ажиллагаа нь явган хүн гудамжаар явахад хэр хялбар, хүссэн газраа төөрч будилалгүй хүрч очих хаяг, чиг хэр сайн байгааг шалгасан энэ үйл ажиллагаа байсан юм. Үүнээс үндэслэн хот, суурин газрын зам, гудамж, хаягжилтад түгээмэл загвар ашиглах аль болох олон хүнд ээлтэй болгоход анхаарах ёстой зүйл гэж дүгнэжээ.
- Урт босоо цонх нь өндөр нам, зогсоо болон суусан бүх хүнд гадагш харах боломж олгож байна. Ихэнх одой, тэргэнцэртэй хүн цонхонд хүрдэггүй боловч хүүхэд шиг хүнээр өргүүлээд шагайх боломжгүй байдаг.
- Тэгш хамруулан сургаж байгаа анги танхимд ашиглах сургалтын стратеги болох Сурахуйн түгээмэл загварыг багш нар түршин хэлбэржүүлж байна. Манай улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд түгээмэл загвар хөгжүүлэх тухай дурдсан байдаг.



² <http://universaldesign.ie/what-is-universal-design/case-studies-and-examples/examples/battery-pack/battery-pack.html>

Хөгжлийн бэрхшээлийн талаарх сөрөг, дутуу үнэлсэн ойлголт хандлага нь хүний эрхийн мэдлэг, мэдрэмжтэй шууд холбоотой. Хөгжлийн бэрхшээлийн асуудалд хүний эрхийн байр сууринаас хандах нь харьцангуй саяхнаас эхэлсэн хэдий ч хурдацтай бэхжин тогтворжиж байгаа үзэл баримтлал юм. Хөгжлийн бэрхшээлд хүний эрхийн байр сууринаас хандана гэдэг нь хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхахгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусадтай адил тэгш байх боломж бий болгохыг хэлнэ.

Хөгжлийн бэрхшээлгүй хүмүүс төрийн болон орон нутгийн зарим суурь үйлчилгээ, боломжийг хүртэхэд гардаг саад тотгорыг тэр бүр анзаардаггүй. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гадагшаа гарах, дэлгүүр орохоос эхлээд төрийн үйлчилгээ авах, эмчид үзүүлэх, телевизээр мэдээлэл авах зэрэгт саад, тотгортой тулгарах нь түгээмэл байдаг. Хэдий тийм боловч энэ саадыг даван туулах нь хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийнх нь хариуцах асуудал мэт хандлагатай байнга шахуу тулгардаг. Гэтэл хуулиараа Монгол Улсын иргэний хувьд хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хүн бүр нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын эрхээ эдлэх нь баталгаажсан байдаг ч бодит байдал дээр адил тэгш байх нөхцөл нь бүрдээгүй байдаг. Биет болон мэдээллийн саадгүй, хандлага ойлголтын болон институцийн эерэг дэмжлэгтэй хүртээмжтэй орчин бол хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхээ эдлэх боломжийн суурь нөхцөл нь юм.

Хүртээмжтэй орчин бол давуу эрх, ямба биш харин хүний эдлэх ёстой үндсэн эрх юм.

Модуль 1 (Хөгжлийн бэрхшээлийг хүний эрхийн байр сууринаас ойлгох нь)-ийн гол дүгнэлт

- Хөгжлийн бэрхшээлийн асуудалд хүний эрхийн байр сууринаас хандах нь чухал.
- Үүний зэрэгцээ хөгжлийн бэрхшээлийн талаарх нийтлэг ойлголт хандлагуудыг ойлгож, өнөөгийн манай нийгэмд байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хязгаарласан бодлого шийдвэр, арга хэмжээ, үйлдэл хийхэд түлхэж буй буруу ташаа ойлголт, хэвшмэл ойлголтыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Манай улс хөгжлийн бэрхшээлийн талаар эмнэлгийн загвар баримталж байгаа нь тусгай үйлчилгээ, нийгмийн халамж, эмч нарын шийдвэрт түлхүү анхаарахад хүргэж, хүний эрх, оролцооны асуудал нь хоёрдугаарт тавигдах үр дагаварт хүргэж байна.
- Хөгжлийн бэрхшээл бол хүний ялгаатай байдлын нэг хэлбэр, эмчлэх ёстой өвчин юм уу, гай зовлон биш гэдгийг хүлээн зөвшөөрсөн, хөгжлийн бэрхшээлийн хүний эрхэд суурилсан загварыг түгээн дэлгэрүүлэх хэрэгтэй. Ингэж чадсан нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эмчлэх, хандив, халамжаар дэмжин амьдруулах арга хандлагаас татгалзаж, тэгш оролцоог нь хязгаарлаж байгаа саад, тотгоруудыг арилгахад чиглэсэн хөгжлийн бэрхшээлд хандах нийгмийн загвараар бодлого, үйл ажиллагаа, харилцаагаа шинэчлэх боломжтой.
- Дэлхийн улс орнуудад бүх хүн ашиглах боломжтой дизайн, загвар боловсруулах ажил хийгдэж байна. Хотын нийтийн зам талбай, байшин барилга, бүтээгдэхүүн, үйлчилгээний дизайныг бүх нийтэд хүртээмжтэй болгоход чиглэсэн түгээмэл загварын ойлголт хэвшин төлөвшиж байна. Боловсролд энэ санааг “Сурахуйн түгээмэл загвар” гэж нэрлэн хөгжүүлж байгаа билээ.

- Түгээмэл загвар бол зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд төвлөрөөгүй, бүх хүн ашиглах боломжтой дизайныг бий болгосноор хөгжлийн бэрхшээлтэй, хөгшин настай, хүүхэд гээд янз бүрийн бүлэгт зориулж тусгай дизайн гаргахгүй, нэг дизайнаар ялгаатай хэрэгцээнүүдийг хангах зорилготой юм.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн оролцоог хязгаарлаж байгаа зүйл бол ээлгүй орчин юм. Ээлтэй орчны хүртээмж гэдэг нэр томъёогоор нэрлэнс биет, мэдээллийн, институцийн, хандлагын эерэг орчин нь хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцох боломж буюу хүртээмжийг бүрдүүлнэ. Хүртээмжтэй орчин бол хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн оролцооны суурь нөхцөл бөгөөд бүх хүний хувьд хүртээмж бол давуу байдал, ямба биш эрх нь юм.



Модуль 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах эрх зүйн орчин

Модуль 2-ыг судалснаар оролцогчид НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц болон Нэмэлт протоколын талаар тодорхой мэдлэгтэй болж, хүний эрхийн эрх зүйн баримт бичгүүдийг нөлөөллийн ажилдаа ашиглах бэлтгэлтэй болно.



СЭДЭВ 2.1. НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ, ТҮҮНИЙ НЭМЭЛТ ПРОТОКОЛЫН АГУУЛГА, БҮТЭЦ

Яагаад тусдаа Конвенц батлан гаргах болсон бэ? Хүний эрхийн түгээмэл тунхаглал, олон улсын бусад гэрээ конвенц, улс орнуудын Үндсэн хууль нь бүх хүний эрхийг хамгаалдаг тул эдгээрээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалж болохгүй юм уу?

Нэгдүгээрт, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс дэлхийн болон ихэнх улс орны түвшинд хамгийн том цөөнх болж, бодлого шийдвэр гаргаж байгаа олонх нь тэднийг эмчлэн сувилах шаардлагатай өвчтэй хүмүүс гэж харж байсан тул эрх эдлэгч статусыг нь баталгаажуулах зорилгоор Конвенцыг баталсан.

Хоёрдугаарт, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс онолын хувьд хүний бүх эрхээ эдлэх ёстой ч тэдний энэ эрхийг хамгаалах, хариуцах эзэн байхгүй байв. Эмчилгээ сувилалд хамрагдаад, халамж авч амьдрах нь хангалтгүй тул хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүх эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах үүргийг төр засаг хариуцах амлалтыг Конвенцоор бий болгож байгаа юм.

Гуравдугаарт, хүний эрхийн бусад гэрээ конвенцод хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхүүдийг хангах, хамгаалах боломжууд агуулагдаж байсан хэдий ч тэр боломжийг ажил хэрэг болгох механизм хэрэгтэй байсан юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шинэ эрх нээж өгөөгүй, зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэдэг нийгмийн бүлэгт хүний эрхийн талаас анхаарал татах зорилготой юм.

ХБХЭК нь 2006 оны 12 дугаар сард НҮБ-ээр батлагдаж, улс орнууд үүнд нэгдэх үйл явц 2007 оны 3 дугаар сараас эхэлж, 2008 оны 5 дугаар сард хүчин төгөлдөр болсон олон улсын гэрээ юм. Монгол Улс ХБХЭК-д 2009 оны 12 дугаар сард нэгдэн орсон.

ХБХЭК-ыг олон улсын хүний эрхийн бусад гэрээтэй хамтаар нь харах ёстойг онцлох хэрэгтэй. Үүнд Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт зэрэгтэй шууд холбоотой хэрэглэх ёстой. Мөн заавал хэрэгжүүлэх хуулийн хүч байхгүй ч зарчмуудыг тогтоож өгдөг “зөөлөн хуулиуд” нь ХБХЭК-д маш чухал бөгөөд эдгээр нь 1993 оны *Хөгжлийн бэрхшээлтэй хүний боломжийг тэгшитгэх стандарт дүрэм*, *Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх Үйл ажиллагааны Дэлхийн хөтөлбөр* юм.

ХБХЭК нь зорилгоо хэрхэн тодорхойлсон бэ? ХБХЭК нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн хүний бүрэн эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих, түүнчлэн тэдний нэр төр, нандин чанарыг хүндэтгэн дэмжихэд

чиглэнэ гэж 1-р зүйлдээ тодорхойлжээ. Ингээд ХБХЭК-ын үйлчлэх хүрээг харах юм бол хэд хэдэн онцлог анзаарагдана.

Юуны өмнө уг Конвенц нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалж байгаа бөгөөд үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүд, мөн иргэний болон улс төрийн эрхүүд багтана. ХБХЭК нь эдгээр эрхийг олон улсын нэг гэрээ болгож нэгтгэсэн анхны олон улсын механизм юм.

ХБХЭК-ын бас нэг онцлог бол Конвенцын хэрэгцээг тодорхойлж, боловсруулах багт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний байгууллагууд НҮБ-ын хүний эрхийн гэрээ конвенцуудын түүхэнд хамгийн олноороо орж ажилласан явдал юм. ХБХЭК нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх мэдэлжүүлж өгсөн бөгөөд уг Конвенц нэг талаасаа хүний эрхийн механизм, нөгөө талаасаа дэлхийн хамгийн том цөөнхийн хувьд хөгжлийн механизм болж байгаагаараа өвөрмөц юм.

ХБХЭК-ын дараагийн нэг онцлог бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шинэ эрх бий болгож өгөөгүй, харин бусад иргэний нэгэн адил эрхээ эдлэхэд нь төр үүрэг хүлээгч болохыг тодорхой болгож өгсөн бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах төрийн үүрэг нь одоо стандарт, хөтөлбөрөөс бус заавал биелүүлэх үүрэгтэй хуулиар зохицуулагдаж байх болов.

ХБХЭК-д хөгжлийн бэрхшээлийг тодорхойлоогүй, харин хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж хэнийг үзэж болох тухай чиглүүлж өгсөн. Конвенцын Удиртгалд хөгжлийн бэрхшээл нь хувьсан өөрчлөгдөж байгаа ойлголт болохыг дурдаад, хөгжлийн бэрхшээл бол согог, эмгэгтэй хүн бусадтай адил тэгш нийгмийн амьдралд үр бүтээлтэй, бүрэн дүүрэн оролцох боломжийг нь хязгаарласан орчны саадтай тулгарснаар бий болдог гэж тайлбарлажээ. Энэ бол хөгжлийн бэрхшээлд хандах нийгмийн загварыг ашигласан хүний эрхийн тодорхойлолт юм.

Цаашилбал Конвенцын 1-р зүйлд “Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн урт хугацааны согогтой бөгөөд уг согог нь янз бүрийн саад тотгортой харилцан үйлчилсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад болохуйц этгээдийг хэлнэ” гэжээ. Дашрамд хэлэхэд, Конвенцын Монгол орчуулга нь алдаатай, “байнгын согогтой” гэснийг НҮБ-ын ХБХЭК-ын хорооноос Монгол Улсад сануулсан. Конвенцын 1-р зүйлд өгсөн тодорхойлолтод *disabled person* гэсэн хуучин нэршлээс татгалзаж, *person with a disability* гэж тайлбарласан байна. Энэ нь хөгжлийн бэрхшээл хүнийг бүхлээр нь тодорхойлохгүй, хүний нэг л тал болохыг онцолж буй хэрэг юм. Улмаар тахир дутуу, хомсдолтой зэрэг нэр томьёог хэрэглээнээс хасах шаардлагатай болоод байна. Янз бүрийн нутаг дэвсгэр, соёл, бүлгүүд өөр өөр нэр томьёо хэрэглэхийг илүүд үздэг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хувь хүмүүс ч мөн өөр нэр томьёо хэрэглэхийг хүндэтгэж хандаж хэрэгтэй.

3 дугаар зүйл дэх Нийтлэг зарчмууд нь ХБХЭК-ыг хэрхэн ойлгож, хэрэглэх талаар төр засаг, бусад оролцогч талуудад өгч байгаа заавар юм. 3 дугаар зүйлд багтсан нийтлэг зарчмууд нь хүний заяагдмал бие даасан байдлыг хүндэтгэн, хувийн хараат бус байдал, сонголт хийх эрхийг хүндэтгэхээс эхэлж байна. Дараагийн зарчим нь алагчлахгүй байх буюу хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар бусдаас ялгаатай хандах, ялгаварлан гадуурхахгүй байх зарчим юм. Цаашлаад нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох, ялгаатай байдлыг хүндэтгэхийг онцолж байгаа нь хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хүний эрхүүдээ эдлэх ёстой гэсэн зарчим билээ. Тэгш боломж олгох зарчим нь 1993 оны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний боломжийг тэгшитгэх стандарт дүрэм”-ийг сануулж буй хэрэг юм. Хүртээмжтэй байх, эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй байх зарчмууд мөн түсжээ. Хүүхдийн хувьсан өөрчлөгдөх чадамж, хүүхдийн эрхийг хүндэтгэх зарчим нь хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар хүүхдийг багаас нь ялгаварлахгүй байх, байнгын согогтой гэж хандахаас илүүтэй хувьсан өөрчлөгдөх, хөгжих чадвартай хувь хүн гэж хандахыг сануулжээ.

Дасгал 2.1.1.

Зарчмуудыг ойлгох нь: Доорх бичиг баримтыг уншаад, үл алагчлах, оролцоог хангах, бие даасан байдал, бие даан шийдвэр гаргах, дэмжлэгт шийдвэр гаргалт, тохирох хэрэглэгдэхүүн зэрэг ойлголтыг ярилцах

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай Монгол улсын анхдугаар илтгэлийн талаарх НҮБ-ын ХБХЭК-ын Хорооны дүгнэлт зөвлөмж

10. Хөгжлийн бэрхшээлээр алагчлах асуудлыг анхааралдаа авч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой бүх хууль тогтоомж дахь үл алагчлалын ойлголтыг бодитойгоор хэрэгжүүлж, холбогдох бүх хуульд оруулахыг зөвлөж байна. Мөн бүх хуульд тохирох хэрэглэгдэхүүнийг баталгаажуулан, тохирох хэрэглэгдэхүүнээр хангахгүй байх нь хөгжлийн бэрхшээлээр алагчилж буйн хэлбэр болох тул хууль болгож батлахыг зөвлөж байна. Мөн энэхүү хуулийг дагаж мөрдөх үр дүнтэй мониторингийн механизмыг бий болгохыг зөвлөж байна. Үүнд хөгжлийн бэрхшээлээс нь болж алагчилсны төлөө холбогдох нөхөн олговор, залруулах боломжийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олгох ёстой. Мөн улсын болон хувийн салбарт ажиллаж байгаа хүмүүс, түүний дотроос шүүгч, төрийн албан хаагч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудын төлөөлөлд хөгжлийн бэрхшээлээр алагчлах асуудал, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах үүрэг болон боломжуудын талаар шаардлагатай сургалт санаачилж, зохион байгуулахыг зөвлөж байна.

Дасгал 2.1.1-ийн үргэлжлэл

21. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа оюуны болон сэтгэц-нийгмийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрийнхөө амьдралд хамаатай асуудлаар сонголт хийх, бусдын нэгэн адил хуулийн чадамжаа эдлэх эрхийг баталгаажуулах хууль ёсны арга хэмжээ хангалгүй байна гэж Хороо үзэж байна. Мөн хөгжлийн бэрхшээлээсээ болоод сэтгэл зүйн хязгаарлалтад орсон хүнийг хуулийн байнгын чадамжгүй гэж үзэн хувь хүний асуудлууд, үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой асуудлаар шийдвэр гаргахыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асран хамгаалагч нарт оролцогч улс зөвшөөрч байна гэж Хороо үзэж байна. Иймэрхүү тогтолцоо нь дэмжлэгт шийдвэр гаргалтын оронд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орлон шийдвэр гаргах явдлыг дэмжиж, Конвенцын 12 дугаар зүйл болон хуулийн өмнө тэгш байх талаарх Хорооны Ерөнхий зөвлөмж 1-ийн эсрэг явдал болохыг Хороо тэмдэглэж байна

БХЭК нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн амьдралаас тусгаарлагдах, бодлогын анхаарлын гадна үлдэх эрсдэлтэй тул ийм зарчмуудыг дэвшүүлэн тавьжээ. Бие даасан байдлыг хүндэтгэх, үл алагчлах, тэгш хамруулж оролцоог хангах, хүртээмжтэй орчин бий болгох зарчмууд нь бусад олон улсын гэрээ конвенц, үндэсний хууль эрх зүйн орчинд хангалттай туссан байдаг ч ХБХЭК-т багтааснаар эдгээр нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хамаатай, тэдний амьдралд нөлөөлөх аливаа шийдвэрийг гаргахдаа төрөөс заавал баримтлах зарчим болж байгаа юм. Улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даасан байдлыг хүндэтгэн, үл ялгаварлан нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцох боломжийг хангах нь аливаа үйлчилгээ, үйл явц, орчинд тохируулга хийх, Конвенцын нэрлэснээр “боломжит тохируулга” хийх асуудалтай холбоотой.

Конвенцод тодорхойлсноор, **боломжит тохируулга** бол тодорхой тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил бүх эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх явдлыг хангахад зайлшгүй шаардлагатай бөгөөд зохистой. Гэхдээ хэт их, эсвэл хэрээс хэтэрсэн ачаалал үүсгэхгүйгээр хэрэгжүүлж болох өөрчлөлт, зохицуулалтыг хэлнэ гэж тодорхойлсон бөгөөд энэ нь үйлчилгээ, зохион байгуулалт, биет орчинд хийж болох боломжит зохицуулалт, өөрчлөлт, зохион байгуулалтын арга хэмжээ байж болно. Жишээлбэл, оюуны бэрхшээлтэй хүн сонгуульд санал өгөх, бусад асуудлаар дэмжлэгт шийдвэр гаргалтын үйлчилгээ ашигладаг туршлага дэлхийн олон оронд бий. Харааны бэрхшээлтэй хүүхэд шалгалт өгөхдөө уншигч программ, төхөөрөмж ашиглан, энэ нь илүү цаг шаардах тул цаг сунгах тохируулга хийх, мөн ангийн бусад хүүхдэд саад болохгүйгээр чихэвч ашиглах зэргээр орчныг хангаж өгнө. Япон Улсад удаан сууж чадахгүй сурагч ангидаа ортойгоо хичээллэж байгаа зургийг бидний олонх нь харсан.

Конвенцын монгол орчуулгад энэ нэр томъёог “**боломжит хэрэглэгдэхүүн**” гэсэн нь материаллаг зүйл байдлаар ойлгогдох эрсдэлтэй. Мөн **зайлшгүй шаардлагатай** гэснийг **нэн шаардлагатай** гэж орчуулсан нь хэрэгцээг бус ач холбогдлоор эрэмбэлэх үтгаар ойлгогдох эрсдэлтэй байна. Боломжит хэрэглэгдэхүүн гэж шаардлагатай тодорхой тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын нэгэн адил хүний бүх эрх, эрх чөлөөг эдлэх явдлыг хангах үүднээс зохицоогүй, эсвэл үндэслэлгүй саад тотгорыг арилгах, багасгахад чиглэгдсэн нэн хэрэгцээтэй бөгөөд шаардлагатай тохируулга хийх болон өөрчилж засварлахыг хэлнэ.

2016 оны УИХ-аас баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд боломжит тохируулгын ойлголтыг тохирох хэрэглэгдэхүүн хэмээх нэр томъёогоор тэмдэглэсэн бөгөөд 4.1.3-т “тохирох хэрэглэгдэхүүн гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг хэлнэ гэсэн байдаг.

Дасгал 2.1.2.

Боломжит тохируулгын тухай ойлголтоо бэхжүүлэх нь

Боломжит тохируулгын тодорхойлолтыг задалж судлаад, Конвенцын монгол орчуулгад байгаа тодорхойлолттой харьцуулна уу.

Боломжит тохируулга гэж тодорхой тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил бүх эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх явдлыг хангахад нэн шаардлагатай бөгөөд зохистой, гэхдээ хэт их юм уу, эсвэл хэрээс хэтэрсэн ачаалал үүсгэхгүйгээр хэрэгжүүлж болох өөрчлөлт, зохицуулалтыг хэлнэ.

- ☑ Боломжит - *reasonable* буюу үндэслэлтэй, боломжийн гэсэн утгатай үг;
- ☑ Тохируулга - *accommodation* буюу нийцүүлэн өөрчлөх, харгалзан зохицуулах, харгалзан тохируулах гэсэн утгатай. Жишээлбэл, “таны хүсэлтийг харгалзан уулзалтаа нэг цагаар хойшлуулав”;
- ☑ Тодорхой тохиолдолд - *in particular case* гэсэн нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бүхэлд нь бус, тодорхой арга хэмжээ, тодорхой хүн, тодорхой нөхцөл байдалд хийх зохицуулалт;
- ☑ Зайлшгүй шаардлагатай бөгөөд зохистой - *necessary and appropriate modification and adjustments* гэсэн нь тухай арга хэмжээ, үйл ажиллагаа, үйлчилгээнд оролцоход нь шаардлагатай бөгөөд;
- ☑ Хэт их, эсвэл хэрээс хэтэрсэн ачаалал үүсгэхгүй - *not imposing a disproportionate or undue burden*: тухай арга хэмжээ зохион байгуулагч, үйлчилгээ үзүүлэгчид дарамт болох хэмжээний зохицуулалтыг хийхээс татгалзаж болох боловч оролцоог хангах бусад арга хэмжээг авах үүрэгтэй.

Дасгал 2.1.2-ын үргэлжлэл

Конвенцын монгол орчуулга:

Боломжит хэрэглэгдэхүүн гэж шаардлагатай тодорхой тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын нэгэн адил хүний бүх эрх, эрх чөлөөг эдлэх явдлыг хангах үүднээс зохицоогүй, эсвэл үндэслэлгүй саад тотгорыг арилгах, багасгахад чиглэгдсэн нэн хэрэгцээтэй бөгөөд шаардлагатай тохируулга хийх болон өөрчилж засварлахыг хэлнэ.

Зохиогчдын орчуулснаар

Боломжит тохируулга бол тодорхой тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил бүх эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх явдлыг хангахад зайлшгүй шаардлагатай бөгөөд зохистой, гэхдээ хэт их юм уу, эсвэл хэрээс хэтэрсэн ачаалал үүсгэхгүйгээр хэрэгжүүлж болох өөрчлөлт, зохицуулалтыг хэлнэ.

(2016 онд баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд тохирох хэрэглэгдэхүүн)

Хүртээмж нь Конвенцын нийтлэг зарчим болохын зэрэгцээ биеэ даасан 9 дүгээр бүлэг юм. Цаашилбал хүртээмж нь Конвенцын маш чухал хэсэг тул шударга шүүхийн хүртээмжийн тухай 13 дугаар зүйл, бие даан амьдрах, орон нутгийн амьдралд оролцох тухай 19 дүгээр зүйл, мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний тухай 21 дүгээр зүйл, боловсролын тухай 24 дүгээр зүйл, эрүүл мэндийн тухай 25 дугаар зүйл, сэргээлт, нөхөн сэргээлтийн тухай 26 дугаар зүйл, ажил, хөдөлмөр эрхлэлтийн тухай 27 дугаар зүйл, амьжиргааны хүрэлцэхүйц түвшин, нийгмийн хамгааллын тухай 28 дугаар зүйл, улс төр, нийгмийн амьдралд оролцох тухай 29 дугаар зүйл, соёлын амьдрал, чөлөөт цаг, амралт, спортын арга хэмжээнд оролцох тухай 30 дугаар зүйлд дурдагдсан байна.

Дасгал 2.1.3.**Тохирох хэрэглэгдэхүүн/боломжит тохируулгын тодорхой тохиолдлуудтай танилцаад, асуултад хариулна уу?**

1. Сонсголын бэрхшээлтэй хүн эмнэлгийн үйлчилгээ авахад дохионы хэлний орчуулга шаардлагатай болох бөгөөд үүнийг орчуулагч хөлслөх, хөрвүүлэх программ ашиглах зэргээр шийдэж болох ч харин эмч, сувилагч нарыг дохионы хэлтэй болгох албагүй. Яагаад? Ямар тохируулга хийж болох вэ?
2. Тэргэнцэртэй хүүхэд сургуульд элсэн орвол ирэх болон харих зам, сургууль руу орох, сургууль дотор болон анги танхим дотор чөлөөтэй зорчих боломж олгосон хүртээмжтэй орчин бүрдүүлэх үүрэгтэй ч сумын сургууль цахилгаан шат барих албагүй. Яагаад? Ямар тохируулга хийж болох вэ?
3. 5 цаг үргэлжлэх шалгалтад тэргэнцэртэй хүн орж байгаа тул шалгалтыг сургууль дээр биш тэргэнцэртэй хүн орох, гарах боломжтой ариун цэврийн өрөөтэй Иргэний танхимд авах болов. Харин сургуулийн ариун цэврийн өрөөг өөрчлөн тэргэнцэртэй хүнд хүртээмжтэй болгож засварлах үүрэг байхгүй. Яагаад?

ХБХЭК-ын Нийтлэг зарчим хэмээх 3 дугаар бүлэгт дурдагдаад, бие даасан 5 дугаар бүлэг болж тусгагдсан асуудал бол тэгш боломжоор хангагдах, ялгаатай байдлаа хүндлүүлэх, ялгаварлан гадуурхагдахгүй байх зарчмууд юм. 5 дугаар бүлэгт хуулийн өмнө адил тэгш эрх, хөгжлийн бэрхшээлээр алагчлах явдлыг хориглох, тэгш байдлыг хөхиүлэн дэмжих, тэгш байдлыг де факто хангах асуудлыг төр хариуцах тухай заагаад, тэгш байдлыг бий болгоход чиглэсэн шаардлагатай тусгай арга хэмжээг алагчлал гэж үзэхгүй хэмээн онцолжээ.

Тэгш байдлыг де факто хангах гэдэг нь юу гэсэн үг вэ? Тэгш байдлын зарчмыг ойлгож хэрэглэхтэй холбоотой дараах 3 хандлага байдаг. Үүнд:

Эрх зүйн тэгш байдал буюу де юре тэгш байдал. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил эрхтэйг тунхагласан хууль баталж, эрх зүйн баталгаа бий болгох явдал юм. Тэгш байдлыг тунхаглах нь эхний алхам төдий бөгөөд амьдрал дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бодитоор тулгардаг өөр өөр нөхцөл байдлыг тооцон, оролцоог нь хязгаарласан саад тотгорыг арилгахад чиглэсэн арга хэмжээ авах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, хууль хэрэгжихгүй, эсвэл хангалттай хэмжээнд хэрэгжихгүй бол эрх зүйн тэгш байдал нь тунхаг болж үлдэх магадлалтай. Жишээлбэл, Үндсэн хуульд хүнийг ямар нэг байдлаар ялгаварлан гадуурхахыг хориглохын зэрэгцээ хүн бүр сурч боловсрох эрхтэйн дээр хүүхэд бүрт суурь боловсролыг төрөөс үнэгүй хүргэж, сурч боловсрох эрхийг нь хангахаар заасан байдаг. Улмаар хүнийг хөгжлийн байдал, хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлах ялгаварлан гадуурхалт болох тул хөгжлийн бэрхшээлтэй бүх хүүхэд суурь боловсролыг үнэгүй эзэмших эрхтэй тул энэ асуудлаар эрх зүйн тэгш байдлаар хангагдсан.

Тэгш боломж буюу боломжийг тэгшитгэх нь. Хүнээс өөрөөс нь шалтгаалахгүй, хамаарахгүй саад тотгор учирч болохыг энэ хандлага сануулдаг. Эдгээр саад тотгор нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх мэдлийн асуудал биш, шийдэл өөрөөс нь хамаарахгүй тул боломжийг нь хүмийх нөлөө үзүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүн бусадтай ижил тэгш оролцох, адил тэгш үр дүнд хүрч чадахгүй нөхцөлд хүргэнэ. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бусад хүнээс ялгаатай онцлог хэрэгцээнд нийцүүлэн тусгай арга хэмжээ авдаг. Тэгш боломжийн хандлагаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний жишээ бол - тохирох хэрэглэгдэхүүн буюу боломжит тохируулга юм. Монголын жишээн дээр буулгах юм бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын гадна үлдээхгүй, үнэ төлбөргүй суурь боловсрол эзэмшүүлэх амлалтаа биелүүлэн тусгай сургуулиуд байгуулан, ажиллуулж байна. Мөн ердийн ЕБС-д тэгш хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тохирох хэрэглэгдэхүүнээр хангах буюу боловсролын үйлчилгээнд боломжит тохируулга хийх замаар бусад хүүхэдтэй адил тэгш нөхцөлөөр суралцах бодлого батлан, хэрэгжүүлж эхлээд байна.

Жинхэнэ буюу де факто тэгш байдал. Энэ нь зөвхөн боломжийг тэгшитгэхээр хязгаарлагдахгүй хүрэх үр дүнг тэгш байлгахад чиглэсэн арга хэмжээ юм.

Дасгал 2.1.4.

Дараах жишээг судлаад, эрх зүйн тэгш байдал, тэгш боломж, жинхэнэ тэгш байдлын аль нь болохыг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд хэрхэн жинхэнэ тэгш байдал бий болгох алхмуудыг ярилцана уу.

Конвенцын эхний хэсэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралд маш чухал нөлөөтэй суурь зарчмуудыг Конвенцод нэвт тусгах, үйл ажиллагааны суурь болгох хүсэл эрмэлзлээс үүдэлтэй. Эдгээр зарчмыг тодорхой зааж өгснөөр энэхүү Конвенцын хүрээнд хэрэгжүүлэх бүхий л арга хэмжээ эдгээр зарчимд суурилж, хүрсэн үр дүн нь эдгээр зарчмын үүднээс тайлбарлагдаж, үнэлэгдэх юм.

Дасгал 2.1.5.

Доорх кейсүүдтэй танилцаад, хөгжлийн бэрхшээлээр алагчилсан явдал мөн эсэхийг ярилцаж, тохиолдол бүрт тэгш байдлыг хангахад чиглэсэн ямар арга хэмжээ авч болохыг тайлбарлана уу.

- Такси дуудлагын компани сонсголын бэрхшээлтэй жолоочийг дуудлагын таксины ажилд авахаас татгалзжээ. Шалтгаанаа диспетчертэй утсаар, үйлчлүүлэгчтэй биечлэн харилцах, онцгой байдал үүсвэл шуурхай харилцах боломжгүй гэж тайлбарлажээ.

Дасгал 2.1.5-ын үргэлжлэл

- Барилгын компани цагаар ажилласан оюуны бэрхшээлтэй залууг мөнгөө хаях, үрэх эрсдэлтэй гээд цалинг ээжийнх нь данс руу шилжүүлэв.
- Орон нутгийн музей хараагүй хүмүүст үйлчлэх брайл мэдээлэлтэй танхим нээв.
- Санал авах байр өндөр шаттай, өрөөний хаалга нь тэргэнцэр багтахгүй нарийхан тул хоёр хүн томилж, тэргэнцэртэй хүмүүсийг өргөж оруулах, саналаа дугуйлж байхдаа сандал дээрээс унахаас сэргийлж түшиж зогсох хүн гаргасан.
- Манай хороонд сонсголгүй 3 хүн байгаа. Хорооны Иргэдийн нийтийн хурал хийхдээ дохионы хэлний орчуулагч ажиллуулдаг. Хорооны ажилтнуудад дохионы хэл зааж сургах ёстой юу?
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дэмжих зорилгоор зар гаргаж хүн ажилд авсан. Орон тоо байхгүй учраас ажилтнуудтайгаа ярилцаад, хүн бүр сар бүр нэг өдрийн цалингаа хандивлаж, тэр хүнийхээ цалингийн санг бүрдүүлсэн.
- Тэргэнцэртэй зөөгч ажилд аваад, хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгч орж ирэхээр ажиллуулж байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгч цөөн учраас ажлын ачаалал нь бага, ядрахгүй байна гэж өөрөө хэлсэн.
- Оюуны бэрхшээлтэй охиныг 18 нас хүрэхээр нь өрхийн эмнэлгээс жирэмслэлтээс сэргийлэх эм өгч, сар бүр эм авах, ууж байгаад нь хяналт тавихыг ээжид нь хариуцуулсан.



**СЭДЭВ 2.2. ХБХЭК-оор ХАМГААЛАГДСАН ЭРХҮҮДИЙН ТОЙМ,
КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ, ХАНГУУЛАХ МЕХАНИЗМУУД**

Конвенц нь хүний эрхийн стандартуудыг хүлээн зөвшөөрч, хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалахтай холбоотой төрийн үүрэг, мөн хүний эрхийг хамгаалах олон улсын болон үндэсний механизмуудыг тодорхойлсон олон улсын гэрээ юм. ХБХЭК нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн хүний үндсэн эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн, эрх тэгшээр эдлэх явдлыг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих, түүнчлэн тэдний нэр төр, нандин чанарыг хүндэтгэн дэмжихэд оршино. Уг Конвенц нь хөгжлийн бэрхшээлтэй гэдэгт “бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн урт хугацааны согогтой бөгөөд уг согог нь янз бүрийн саад тотгортой харилцан үйлчилсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад болохуйц этгээдийг” багтаан ойлгож байна. ХБХЭК нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг баталгаажуулан эдгээр эрхийг хангах, хамгаалах үүрэг хүлээгч нь төр бөгөөд хөгжлийн бэрхшээлд хүний эрхийн байр сууринаас хандах ёстой болохыг тодотгон, эрхийн хэрэгжилтийг олон улсын болон үндэсний түвшинд хянах механизмуудыг бий болгож өгснөөрөө онцгой ач холбогдолтой эрх зүйн баримт бичиг юм.

ХБХЭК нь 50 бүлэгтэй, Удиртгал хэсгээр эхэлж, 1 дүгээр зүйлд Конвенцын зорилго, 2 дугаар зүйлд тодорхойлолт буюу зарим нэр томъёог тайлбарлаад, 3 дугаар бүлэгт зарчмуудаа жагсаажээ. 4 дүгээр бүлэг нь төр засгийн хүлээх үүргийг заасан, дараа дараагийн бүлэгт тодорхой эрхүүдийг зааж өгчээ.

ХБХЭК-ын бүтэц, ерөнхий агуулгын тойм

Удиртгал	Нөхцөл байдал, суурь асуудлууд, хөгжлийн бэрхшээл ба хөгжлийг тайлбарласан.	
1 дүгээр зүйл	Зорилго	Конвенц нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн хүний үндсэн эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн, эрх тэгшээр эдлэх явдлыг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих, түүнчлэн тэдний нэр төр, нандин чанарыг хүндэтгэн дэмжих зорилготой болохыг тунхагласан. Энд мөн хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт хэнийг багтааж байгааг тайлбарласан.
2 дугаар зүйл	Тодорхойлолт	Конвенцын чухал нэр томъёонуудыг тайлбарласны дотор харилцаа холбоо, хэл яриа, хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхах, боломжит тохируулга/тохирох хэрэглэгдэхүүн болон түгээмэл загвар багтана. Хөгжлийн бэрхшээл, хөгжлийн бэрхшээлтэй хүний тодорхойлолтыг өгөөгүй. Учир нь эдгээр нь хувьсан өөрчлөгдөж буй, хөгжиж буй ойлголт гэдгийг санал нэгтэй хүлээн зөвшөөрсөн.
3 дугаар зүйл	Нийтлэг зарчим	Конвенцыг ойлгох, эрхүүдийг хэрэгжүүлэхэд чухал зарчмуудыг нэгтгэсэн бүлэг. Аль нэг зүйл заалтын агуулгыг сайн ойлгохгүй байгаа тохиолдолд эдгээр зарчмыг чиглүүлэг болгож ашиглана. Жишээлбэл, бодлого боловсруулагчид дэмжлэгт шийдвэр гаргалтын зохицуулалт боловсруулж байгаа бол хүний хүний хувийн хараат бус байдал, бие даасан байдлыг хүндэтгэх зарчмаар шийдвэр гаргах эрх мэдэл, боломжийг дээд зэргээр баталгаажуулах.

Удиртгал	Нөхцөл байдал, суурь асуудлууд, хөгжлийн бэрхшээл ба хөгжлийг тайлбарласан.	
4 дүгээр зүйл	Нийтлэг үүргүүд	Конвенц нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхүүдийг ханган хамгаалах үүргийг хэн хүлээж буй, юу хийх, хэрхэн хийхийг тодорхойлж өгсөн (жишээлбэл, нэн даруй, эсвэл аажмаар, дэвшилттэйгээр, шат дараалан). Жишээлбэл: - Оролцогч улс Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухайд эдгээр эрхийг бүрэн дүүрэн эдлүүлэх нөхцөл байдлыг аажмаар бий болгох оролцогч улс бүр олон улсын эрх зүйн дагуу нэн даруй үүсэх энэхүү конвенцоор хүлээлгэсэн үүрэгтэй үл харшлах байдлаар өөрийн боломжит нөөцийг дээд хэмжээгээр ашиглах бөгөөд шаардлагатай тохиолдолд олон улсын хамтын ажиллагаанд түшиглэнэ. Энд улс орнуудын хөгжлийн болон орлогын түвшинд харгалзан үе шаттай төлөвлөн хэрэгжүүлэх боломжийг бий болгохын зэрэгцээ огт хэрэгжүүлэхгүй байх нөхцөлөөс сэргийлж, боломжийн хэрээр үе шаттай арга хэмжээ авч байх ёстой болохыг заажээ. - Энэхүү конвенцыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийг боловсруулж мөрдөх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой бусад шийдвэрийг гаргахдаа оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй зөвлөлдөх бөгөөд тэднийг төлөөлөх байгууллагаар дамжуулан тэднийг идэвхтэй оролцуулна. Уг заалт нь Нийтлэг зарчим хэсэгт байгаа оролцоо, тэгш хамрагдалтын зарчмыг төрийн үүрэг болгож тодорхойлсноор хэрэгжилтийг сайжруулах нөлөөтэй.

ХБХЭК-ын бүтэц, ерөнхий агуулгын тоймын үргэлжлэл

Удиртгал	Нөхцөл байдал, суурь асуудлууд, хөгжлийн бэрхшээл ба хөгжлийг тайлбарласан.	
5-30 дугаар зүйл	Нийтлэг асуудлууд	Конвенц нь үл ялгаварлал, тэгш байдлын зарчмыг тууштай баримтлан, соёл, эдийн засаг, улс төр, иргэний бүхий л эрхүүдийг тодорхойлоход хүрээ болгон ашиглаж байгаа. 5 дугаар зүйл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх тэгш байдлыг хангах, хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхахыг хориглохыг төрөөс шаарджээ. Уг ерөнхий шаардлагыг дараа дараагийн бүлгүүдэд тодорхой эрхүүдийн хүрээнд давтаж, де факто тэгш байдлыг бий болгоход шаардлагатай хориг болон дэмжих арга хэмжээг тодорхойлж өгсөн бөгөөд ийнхүү тусгайлан дэмжих утга агуулгатай арга хэмжээ бол ялгаварлан гадуурхалт биш болохыг Конвенц онцолжээ. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн тухай 6 дугаар зүйл, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тухай 7 дугаар зүйл нь Конвенцод бүхэлд нь баримтлах нийтлэг баримтлалуудыг тодорхой бүлэгт хамааруулан тайлбарлажээ.
	Тодорхой эрхүүд	Конвенцын шинэлэг тал нь тодорхой нэг эрхэд шууд хамааралгүй ч эрхийг хангахад чухал нөлөөтэй багц арга хэмжээг төрийн хариуцах асуудал болгож тодорхойлсон явдал юм. Эдгээр нь: - Мэдлэг ойлголтыг дээшлүүлэх (8 дугаар зүйл) - Хүртээмж (9 дүгээр зүйл) - Хүмүүнлэгийн гамшиг болон эрсдэл бүхий нөхцөл байдал (11 дүгээр зүйл) - Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох (13 дугаар зүйл) - Сэргээлт, нөхөн сэргээлт (26 дугаар зүйл) - Статистик болон мэдээлэл цуглуулах (31 дүгээр зүйл) - Олон улсын хамтын ажиллагаа (32 дугаар зүйл)

Удиртгал	Нөхцөл байдал, суурь асуудлууд, хөгжлийн бэрхшээл ба хөгжлийг тайлбарласан.
	Тодорхой эрхэд хамааралтай зүйл заалтууд нь хүн бүрийн эдлэх ёстой хүний эрхүүдийн агуулга, хамрах хүрээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хамааруулан тайлбарласан байна. - Амьд явах эрх (10 дугаар зүйл) - Хуулийн өмнө тэгш байх эрх (12 дугаар зүйл) - Эрх чөлөө, хувийн халдашгүй эрх (14 дүгээр зүйл) - Эрүүдэн шүүлт, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх (15 дугаар зүйл) - Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх эрх (16 дугаар зүйл) - Хувийн нэгдмэл байдлыг хамгаалах (17 дугаар зүйл) - Чөлөөтэй зорчих болон иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрх (18 дугаар зүйл) - Бие даан амьдрах болон тухайн оршин суугаа орчиндоо байх эрх (19 дүгээр зүйл) - Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөө (21 дүгээр зүйл) - Орон байр болон гэр бүлийг хүндэтгэх (23 дугаар зүйл) - Боловсрол (24 дүгээр зүйл) - Эрүүл мэнд (25 дугаар зүйл) - Ажил хөдөлмөр эрхлэлт (27 дугаар зүйл) - Амьжиргааны хүрэлцэхүйц түвшин, нийгмийн хамгаалал (28 дугаар зүйл) - Улс төр, нийгмийн амьдралд оролцох (29 дүгээр зүйл) - Соёлын амьдралд оролцох, чөлөөт цаг, амралтаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх (30 дугаар зүйл)

ХБХЭК-ын бүтэц, ерөнхий агуулгын тоймын үргэлжлэл

Удиртгал Нөхцөл байдал, суурь асуудлууд, хөгжлийн бэрхшээл ба хөгжлийг тайлбарласан.		
32 дугаар зүйл	Олон улсын хамтын ажиллагаа	Олон улсын, тэр дундаа хөгжлийн хамтын ажиллагаа чухал болохыг онцлох зорилгоор Конвенцод тусдаа зүйл болгожээ. Бусад олон улсын гэрээ конвенцтой харьцуулахад, энд хамтын ажиллагааны төрөл, хэлбэрийг илүү тодорхой заасан онцлогтой (жишээлбэл, судалгааны чиглэлээр хамтран ажиллах, хөгжлийн хамтын ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй, тэдний оролцоог хангасан байхад анхаарах гэх мэт). Олон улсын хамтын ажиллагааны тухай энэ зүйл нь бусад зүйл заалтуудтай харилцан хамааралтай, харилцан үялдаатай юм. Өөрөөр хэлбэл, олон улсын, тэр дундаа хөгжлийн хамтын ажиллагаа бол хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, Конвенцын хэрэгжилтийг сайжруулах арга зам юм.
31 ба 33 дугаар зүйл	Хэрэгжүүлэх, хяналт тавих	Эдгээрт Конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих арга хэмжээг заасан байна. 31 дүгээр зүйлд төр Конвенцыг хэрэгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай статистик болон судалгааны мэдээлэл цуглуулах тухай заасан. 33 дугаар зүйлд үндэсний хэрэгжилт, хяналтын тогтолцоог бий болгохын тулд төрөөс хэрэгжүүлэх алхмуудыг заажээ.
34–39 дүгээр зүйл	Хороо	Конвенцын өөрийнх нь институцийн бүтцийг тодорхойлсон эдгээр зүйлд оролцогч улсуудын давтамжтай тайланг хүлээн авч, дүгнэлт зөвлөмж өгөх чиг үүрэгтэй хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн Хорооны тухай заажээ.

ХБХЭК-ын бүтэц, ерөнхий агуулгын тоймын үргэлжлэл

Удиртгал	Нөхцөл байдал, суурь асуудлууд, хөгжлийн бэрхшээл ба хөгжлийг тайлбарласан.	
40 дүгээр зүйл	Оролцогч улсуудын бага хурал	Конвенцын хэрэгжилттэй холбоотой асуудлыг авч хэлэлцэх зорилготой Оролцогч улсуудын бага хурал нь тодорхой давтамжтай хуралдаж байх юм.
41 дүгээр зүйлээс цааш	Төгсгөлийн хэсэг	Гарын үсэг зурах, <i>The Convention sets out the procedures for signature</i> , соёрхон батлах, хүчин төгөлдөр болох зэрэг асуудлаар тавигдаж шаардлагыг тодорхойлжээ.

Дасгал 2.2.1.

Дараах асуултад хариулаад, шаардлагатай бол бусад эх сурвалжаас мэдээлэл хайж хариулт олоод, дараа нь бусад оролцогчтой ярилцаж саналаа солилцоно уу?

- ХБХЭК нь хууль мөн үү? ХБХЭК нь Монголд заавал дагаж мөрдөх ёстой хууль мөн үү? Яагаад?
- ХБХЭК-д давтан дурдагдаж байгаа ямар асуудлууд байна вэ? Яагаад дахин дахин давтсан бэ? Эдгээрээс аль нь Танд чухал санагдаж байна вэ?
- Унших материалыг ашиглан, 1 дүгээр зүйлд тодорхойлсон Зорилго, 3 дугаар зүйлд тодорхойлсон Нийтлэг зарчмуудыг уншиж судлаад, эдгээр нь Конвенцод бүхэлд нь хэрхэн холбогдож байгааг тайлбарлана уу.

Унших материал

1 дүгээр зүйл. Зорилго

Энэхүү конвенцын зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн (адил тэгш) эдлэх явдлыг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжихэд (тэдний төрөлх хүний эрхэм чанарыг хүндэтгэх) оршино.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт (урт хугацааны туршид) бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн

Дасгал 2.2.1-ийн үргэлжлэл

амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ.

**Конвенцын англи эх, монгол эхэд зөрсөн зарчмын нэр томъёо/ойлголтыг англи эхэд байгааг хүснэгтэд оруулсан болохыг анхаарна уу.*

3 дугаар зүйл. Нийтлэг зарчмууд

Энэхүү конвенцын зарчмууд нь:

- a) сонголт хийх эрх чөлөө болон хүний бие даасан байдлыг оролцуулан хүний нэр төр, нандин чанар, хувийн хараат бус байдлыг хүндэтгэх
- b) алагчлахгүй байх
- c) нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох болон хамрагдах
- d) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог байдлыг хүндэтгэх, тэднийг хүний ялгаатай байдал, хүн төрөлхтний нэг хэсэг гэж хүлээн авах
- e) тэгш боломж олгох
- f) хүртээмжтэй байх
- g) эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхтэй байх
- h) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсаж өөрчлөгдөх чадамжийг хүндэтгэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрийн онцлог байдлаа хадгалах эрхийг хүндэтгэх хандах.

Заавал дагаж мөрдөх ёстой олон улсын хүний эрхийн гэрээнүүд бүгд хэрэгжилтэд мониторинг хийх механизмуудыг агуулсан байдаг. Мониторингийн механизмууд нь оролцогч улсын төр засагтай тухайн гэрээг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар бүтээлч яриа хэлэлцүүлэг өрнүүлэх зорилготой бөгөөд төрийн хариуцлагыг бэхжүүлэх, урт хугацаандаа уг гэрээний хүрээнд хүлээсэн үүрэг, өгсөн амлалтаа хэрэгжүүлэх чадавхаа бэхжүүлэх арга зам болдог. Мониторинг нь мөн хувь хүмүүст эрхийн зөрчлийн талаар гомдол гаргаж, эрхээ сэргээлгэх арга зам болдог. ХБХЭК-д, түүний Нэмэлт протоколд хэрэгжилтийг нь хянах мониторингийн механизмуудыг зааж өгсөн.

Үндэсний түвшинд, улс орнууд өөр өөрийн Засгийн газрын бүтэц зохион байгуулалттай уялдуулан уг Конвенцын хэрэгжилтийн нэг юм уу, хэд хэдэн нэгжид хариуцуулах, мөн янз бүрийн салбар, засаглалын янз бүрийн түвшинд хэрэгжиж байгаа үйл ажиллагааг зангидах салбар хоорондын зохицуулалтыг хариуцах нэг нэгж байгуулах, эсвэл байгаа нэгжид оноож хариуцуулах асуудлыг нухацтай авч үзэх ёстойг зөвлөсөн байдаг. Үүний зэрэгцээ төр нь Хүний эрхийн Үндэсний комисс гэх мэт хараат бус институцуудын уг Конвенцыг таниулан сурталчлах, хамгаалах, хэрэгжилтийг нь хянах чадавхыг хадгалах, бэхжүүлэх эсвэл бий болгох үүрэгтэй.

Асуудал хариуцсан нэгж/нэгжүүд болон салбар хоорондын зохицуулалтын нэгж нь ХБХЭК-ын хүрээнд эрх мэдэлтэй бөгөөд өөрчлөлт авчрах бодит оролцоотой байж болох чухал механизмууд юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг тодорхой нэг яам, голдуу Эрүүл мэндийн яам, эсвэл Нийгмийн хамгааллын яам хариуцаж ирсэн түүхэн туршлага бий. Үүний улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал нийтийн асуудал байхаа больж, тусдаа зэрэгцээ үйлчилгээ бий болох эрсдэлтэй. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг Хөдөлмөрийн яам биш халамж хариуцсан нэгж хариуцах юм бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс үндсэн тогтолцооны гадна үлдэх эрсдэлтэй болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх нь

нийгмийн тодорхой бүлгийн эрхийн нэгэн адилаар хүний амьдралын бүхий л талыг хамруулан салбар дамнасан шинжтэй байдаг. Жишээлбэл, хүүхдийн эрх бол төрийн нэг байгууллага дангаараа хариуцах боломжгүй, боловсрол, эрүүл мэнд, гэр бүлийн хөгжил, нийгмийн хамгаалал, эцэг эх, асран хамгаалагчийн хөдөлмөр эрхлэлт, мөн ядуурлыг бууруулах, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гээд олон яам, нэгжийн хамтын ажиллагааны талбар юм. Залуучуудын, эмэгтэйчүүдийн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо, хөгжил, тэгш байдлын асуудал мөн л олон салбар дамнасан асуудал юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хэрэгжилтийг хянах үүргийн нэг, эсвэл хэд хэдэн тодорхой нэгжид хариуцуулан, салбар дамнасан зохицуулалт хийх механизм бий болгосноор хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах ажил хариуцах эзэнтэй болж салбар, түвшнүүдийн хэрэгжүүлэх болон хэрэгжүүлж байгаа ажлыг уялдуулах, зангидах замаар үр дүнг сайжруулах боломж бүрдэнэ. Эдгээр механизмын хэлбэр, бүтцийг улс орон болгон өөрийн онцлогт нийцүүлэн бүрдүүлэх боломжтой бөгөөд жишээлбэл, зохицуулалтын механизмыг иргэний нийгэм, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийг багтаасан үндэсний Зөвлөл хэлбэрээр байгуулах туршлага өргөнөөр дэлгэрч байна.

Олон улсын түвшинд, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороо нэртэй экспертийн зөвлөл байгуулахаар Конвенцод заажээ. Анх 12 гишүүнтэй байгуулагдаж байсан Хороо нь Конвенцыг 60 улс соёрхон баталсны дараа 18 гишүүнтэй болж өргөжжээ. Хорооны гишүүдийг оролцогч орнуудын Бага хурлаас сонгох бөгөөд Хорооны гишүүд аль нэг улс, байгууллагыг төлөөлөхгүй хувь шинжээчийн байр сууринаас ажиллана.

Уг Хороо нь улс орнуудын засгийн газрын ирүүлсэн хэрэгжилтийн ээлжит тайланг судалж, тодорхой улс оронд хандсан Ерөнхий дүгнэлт, зөвлөмж боловсруулж өгдөг. Конвенцын Нэмэлт протоколоор нэгдэн орсон бол Конвенцын аливаа зүйл, заалтыг зөрчсөн тухай гомдлыг ямар ч байгууллага, хувь хүн Хөгжлийн бэрхшээлтэй хүний

эрх (ХБХЭ)-ийн Хороонд хүргүүлэх боломжтой болно. Мөн Нэмэлт протоколоор ХБХЭ-ийн Хороо нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн ноцтой, эсвэл тогтмол зөрчил гарч байгаа тухай найдвартай мэдээлэл байгаа улсад оролцогч улсын зөвшөөрснөөр шалгалт хийж болох юм.

ХБХЭК-д оролцогч орон болгон уг Конвенцыг соёрхон баталж, тухайн оронд хүчин төгөлдөр үйлчилж эхэлсний эхний 2 жилд багтаан Конвенцыг хэрэгжүүлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний анхны тайлангаа ирүүлэх үүрэгтэй. Анхны тайланд Конвенцыг хэрэгжүүлэхтэй холбоотой үндсэн хуулийн, эрх зүйн болон захиргааны зохицуулалтуудыг бий болгосон; Конвенцын зүйл заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор батлан гаргасан бодлого, хөтөлбөрүүд болон тэдгээрийн хэрэгжилтийн үр дүнгийн талаарх мэдээллийг тусгасан байна. Үүнээс хойш 4 жил тутамд, эсвэл Хорооноос шаардсаны дагуу оролцогч орон хэрэгжилтийн ээлжит тайлангаа хүргүүлэх үүрэгтэй. Ээлжит тайланд Хорооноос өмнөх тайлантай холбоотой ирүүлсэн Ерөнхий дүгнэлтэд дурдсан асуулт, асуудлуудад хариу өгөх; тайлант хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан ахиц дэвшлийг танилцуулах; тайлант хугацаанд Конвенцыг хэрэгжүүлэхэд төр, бусад оролцогчдод учирсан хүндрэл, саадыг дурдана. Конвенцын хэрэгжилтийн анхны тайлан нь цогц буюу Конвенцын бүх зүйл заалтын хэрэгжилтийн мэдээллийг багтаах бол ээлжит тайлангуудад өмнөх мэдээллийг давтахгүй, шинэ мэдээллийг өгнө. Оролцогч орны төр засаг нь Конвенцын хэрэгжилтийн тайланг нээлттэй, ил тод байдлаар, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний төлөөллийн байгууллагуудыг оролцуулан, тэдэнтэй зөвлөлдөж бэлтгэх ёстой.

Хороо нь оролцогч улс орны ээлжит тайланг хүлээн авч судлаад, уг тайлантай холбоотой Ерөнхий дүгнэлт, Зөвлөмж боловсруулан тодорхой асуудлаар мэргэшсэн ЮНЕСКО, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, ДЭМБ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр зэрэг агентлаг, хөтөлбөрүүдэд хүргэн, техникийн дэмжлэг үзүүлэх асуудлаар зөвлөлдөнө.

Дасгал 2.2.2.

Хувь хүн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороонд гомдол гаргах дараах процедурыг уншиж судлаад, хандаж болох нэг асуудлыг томьёолж, үе шатуудыг хэлэлцэнэ үү.

Хувь хүн Хороонд гомдол гаргах процедур нь дараах алхмаас бүрдэнэ:

- Хороо гомдлыг хүлээж авна.
- Хороо нь уг гомдлыг хүлээж авах боломжтой эсэхийг шийднэ. Зарим тохиолдолд хүлээж авах боломжтой эсэхийг шийдэхдээ гомдлын үндэслэлтэй эсэхийг зэрэг шийднэ. Өөрөөр хэлбэл, Хороо нь нэг хурлаар уг гомдол нь Хорооны зүгээс хүлээж авах боломжтой эсэх шийдвэр, мөн хөндөгдсөн тухайн асуудал нь төрийн зүгээс үүргээ зөрчсөн эсэх шийдвэр гаргана.
 - Хороо нь гомдлыг дараах тохиолдолд хүлээж авах боломжгүй гэж үзнэ. Үүнд:
 - Гомдол нь нэргүй буюу хохирогч нэргүй гомдол явуулсан;
 - Гомдол нь Конвенцын зүйл заалтыг буруугаар ашигласан, эсвэл тэдгээрт нийцэхгүй;
 - Үндэсний өргөдөл, гомдлын механизмуудад хандаагүй;
 - Уг гомдлоор олон улсын юм уу, бүс нутгийн өргөдөл гомдлын өөр механизм ажиллаж байгаа;
 - Ижил гомдлыг Хороо өмнө нь авч үзэж байсан.

Дасгал 2.2.2-ын үргэлжлэл

- Хороо нь гомдлыг судалж, дүгнэлт гаргаад, тухай оролцогч орны төр засагт хүргүүлнэ.
- 6 сарын дотор оролцогч орны төр засаг нь бичгээр тайлбар, эсвэл тодруулга өгсөн мэдэгдэл хүргүүлж, асуудлыг шийдвэрлэх зорилгоор арга хэмжээ авч хэрэгжүүлсэн бол дурдана.
- Төр засгийн хариуг гомдол гаргагч үзэж танилцан, өөрийн тайлбарыг өгөх боломжтой.
- Хороо нь гомдол гаргагчийн эрхийг хамгаалсан түр арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг оролцогч улсын төр засгаас хүсэж болно.
- Хороо нь гомдлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ.
- Хороо нь шаардлагатай бол тодорхой санал, зөвлөмжийг оролцогч орны төр засаг болон гомдол гаргагчид хүргүүлэх ба үүний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл ирүүлэх хүсэлт гаргадаг.
- Хороо нь санал, зөвлөмжөө тайландаа оруулж нийтэлнэ.

Конвенцод заасан олон улсын хяналтын өөр нэг механизм нь зөвлөлдөх шинжтэй оролцогч орнуудын Бага хурал юм. Конвенцод нэгдэн орсон улс орнуудын төлөөлөгчид 2 жилд нэг удаа хуралдан, ХБХЭК-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлуудыг хэлэлцдэг.



Модуль 3. Сурч боловсрох эрх

Модуль 3-ыг судалснаар оролцогчид хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрх, тэгш хамран сургах боловсролын талаар мэдлэгтэй болж, нөлөөллийн ажилдаа НҮБ-ын ХБХЭК, болон манай улсын эрх зүйн орчны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролтой холбоотой зүйл заалтуудыг ашиглах мэдлэг, туршлагатай болно.



СЭДЭВ 3.1. БОЛОВСРОЛ ДАХЬ ТЭГШ БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ

ДЭМБ болон Дэлхийн банкны тооцоолсноор манай дэлхийн хүн амын 1 тэрбум орчим нь ямар нэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байгаагаас 93- 150 сая нь хүүхэд байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд үе тэнгийн хөгжлийн бэрхшээлгүй хүүхэдтэй харьцуулахад сургуульд сурахгүй байх магадлал 10 дахин бага бөгөөд сургуульд явж байгаа хөгжлийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ихэнх нь тусгай сургууль, ангид тусгаарлагдан сурч байгаа гэж *Plan International* байгууллага мэдээлжээ. Дэлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 80 орчим хувь нь хөгжиж буй орнуудад амьдарч байгаа бөгөөд бага болон дунд орлоготой улс орнуудад амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 90 хувь нь сургуулийн гадна үлддэг ажээ. Ядуу, дүрвэгч, шилжин суурьшсан өрхүүдийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучууд, хөгжлийн

бэрхшээлтэй охид, бүсгүйчүүд боловсрол, нийгмийн үйлчилгээнд хамрагдахдаа давхар саадтай нүүр тулдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуульд анх элсэн орох нь бага хувьтай байдаг бөгөөд элсэн орсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд эрт завсардах, дунд сургуульд орохгүй байх нь их (GCE, Equal right, equal opportunity report, 2014). Японы олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагын судлаачид хөгжлийн бэрхшээлтэй монгол хүүхдүүд 1 ба 2 дугаар ангид сургууль завсардах нь их байгаа тухай судалж тогтоосон байна. БСШУСЯ (хуучин нэрээр)-аас 2016 онд хийсэн судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 40 орчим хувь нь цэцэрлэг, сургуульд сурч байгаад анги ахих тусам завсардсаар, ахлах ангид 14 хувь болж буурч байгааг тогтоосон бөгөөд тэдний ихэнх нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тусгай 6 сургуульд сурдаг хүүхдүүд байдаг. ЮНЕСКО мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуулийн орчинд дээрэлхэлт, хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй бөгөөд энэ нь тэдний сурч боловсрох эрхээ эдлэхэд ноцтой саад болдог талаар дэлхий нийтийн тайландаа 2016 онд онцолсон байдаг.

Боловсролын түүхийг харах юм бол хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид ерөнхий боловсролын үйлчилгээний гадна, тусгай сургуульд суралцаж ирсэн. Зарим улс оронд тусгай сургууль нь асрамжийн газрын хэлбэртэй болж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд гэр бүлээсээ салангид, орон нутгийн амьдралаас салангид, үе тэнгийнхнээсээ тусдаа, тусгаарлагдсан орчинд сурч, амьдарч байсан ба одоо ч амьдарсаар байна. 2012 оны байдлаар Зүүн Европын орнууд хамгийн олон тооны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асрамжийн газар ажиллуулж байжээ.

Хүн төрөлхтөн 17 дугаар зуунаас албан боловсролын тогтолцоог хөгжүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг огт хамруулахгүй, хамруулах шаардлагагүй гэж үзэж байсан үе аль эрт улирч өнгөрчээ. 19 дүгээр зуунд анагаах

ухааны хөгжлийн үсрэнгүй хөгжлийн ачаар бие, оюуны олон согогийг оношилдог болсноор хөгжлийн бэрхшээлээс айх айдас бүүрч, зарим дэвшилтэт үзэлтэй сурган хүмүүжүүлэгч, эмч нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг алслагдсан хөдөө орон нутагт асрамжийн газарт эмчилж, сургах ажлыг эхлүүлсэн түүхтэй. 19 дүгээр зууны сүүл, 20 дугаар зууны эхээр хөгжлийн бэрхшээлийн төрөл хэлбэрээр дагнасан сургалтын тусгай хөтөлбөр гарган, тусгайлан багш бэлтгэж, тусгай сургуулийн тогтолцоог хөгжүүлж эхэлжээ.

Тусгай сургуулийн тогтолцоо нь хэд хэдэн үе шатыг дамжин хөгжиж, өнөөдөртэй золгожээ. Ерөнхий боловсролын тогтолцоотой огт холбоогүй, бие даасан тусгай сургуулийн тогтолцоо байсныг Тусгай боловсрол гэж нэрлэж байжээ. Энэ арга хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмээс тусгаарлах, нийгэм нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлах үр дагаварт хүргэсэн. Дараа нь тусгай боловсролыг ерөнхий боловсролд нэгтгэн, ерөнхий боловсролын орчинд нэмэлт арга зүй, хүний нөөц ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг интеграцчилан сургадаг болсныг Тусгай хэрэгцээт боловсрол гэж нэрлэх болжээ.³ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг “ердийн” орчинд оруулж ирэх гэсэн энэ оролдлого нь голдуу тусгай анги хэлбэрээр хэрэгжиж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургууль дотроо ялгаварлагдахад хүргэжээ.

Тусгай боловсролыг ердийн ерөнхий боловсролын тогтолцоо руу интеграцчилах хөдөлгөөн 1960-1970-аад онд идэвхтэй өрнөсөн байна. Интеграцчиллыг анхандаа түр буюу шилжилтийн үйл явц гэж ойлгож, боловсролын тусгай хэрэгцээг шаардлагатай нэмэлт дэмжлэгээр хангах үзэл баримтлалаас татгалзахгүйгээр энгийн анги танхимд сургах, ингэхдээ тусгай буюу бусад хүүхдээс ялгаатай хөтөлбөр,

³ Эх сурвалж: <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000145940/PDF/145940eng.pdf.multi>


арга зүйгээр сургах хандлагаас холдох арга замаа олох аядуу үйл явц гэж ойлгож байжээ.⁴ Интеграцчилсан тусгай хэрэгцээт боловсрол нь мөн л өөр өөр хэлбэрээр хэрэгжиж, зарим газар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тусгай ангид суралцан бусад хүүхэдтэй зөвхөн завсарлага, үдийн цайны цагаар хамт байх нэг хувилбар байхад мөн л тусгай ангийн хүүхдүүд бусад хүүхэдтэй зарим хичээл дээр нэг анги болж хичээллэдэг загвар ч байв. Зарим тохиолдолд ганцаарчилсан хандлага баримтлан, хөгжлийн бэрхшээлтэй нэг хүүхэд энгийн ангид бусад хүүхэдтэй хамт бүх, эсвэл ихэнх хичээлээ үзэж байв.

Интеграцчилах загвар яагаад “ажиллаагүй” вэ? Яагаад дэлхийн орон оронд тусгай хэрэгцээт боловсролыг интеграцчилах хандлагын талаар шүүмжлэл тасрахгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын тогтолцоог эрс өөрчлөх шаардлага хурцаар тавигдах болсон бэ? Хамгийн гол шүүмжлэл нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн “боловсролын тусгай хэрэгцээ”-г тогтоох, тодорхойлохтой холбоотой байв. Хөгжлийн бэрхшээлийг эмнэлгийн загвараар ойлгож, тусгай хэрэгцээг тогтоох эмнэлгийн загварт суурилсан арга хандлага дэлгэрч эхэлсэн нь асуудал болжээ. Өөрөөр хэлбэл, сурах, анги танхим болон сургуулийн амьдралд оролцож, сурлага болон нийгмийн харилцааны үр чадвараа хөгжүүлэхтэй холбоотойгоор хүүхдэд тулгарч байгаа бэрхшээлийг хүүхдийн өөрийнх нь чадвар хязгаарлалт, хомсдолоор тайлбарлах болсон нь шүүмжлэлийн үндэс болсон байна. Яагаад? Энэ хандлагаар сурлага, нийгмийн оролцооны амжилт гаргаж чадахгүй байгаа нь тухайн хүүхдийн өөрийнх нь асуудал болж, сургуулиуд яагаад хүүхдүүдийг сургаж чадахгүй байгаа асуудлыг ярих, судлах боломжийг хаажээ. Үүнийг ойлгосноор тэгш хамруулан сургах боловсрол гэх ойлголт бий болжээ.

⁴ Мөн тэнд

Дасгал 3.1.1.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн оролцооны 4 хэлбэрийг загварчлан харуулсан доорх 4 зургийг харьцуулж судлаад, боловсролын тухайд загвар тус бүрийн тухайд: 1. хэрхэн нэрлэх, 2. мөн чанар, онцлог нь юу болох; 3. үр дагавар/үр дүн нь юу болох тухай дүгнэж ярилцаарай. Мөн өмнөх сургалтуудаар танилцуулсан хөгжлийн бэрхшээлд хандах 4 загварын аль нь тухайн тохиолдолд нөлөөлж байгааг бас судлан дүгнээрэй.



Зураг 1	
Зураг 2	
Зураг 3	
Зураг 4	

Сурах явцад хүүхдэд тулгарч байгаа бэрхшээл нь сургууль, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байгаа байдал, сургах арга хэлбэртэй холбоотойг олж харснаар сурагчдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрсөн уян хатан сургууль, заах арга зүй шаардлагатай байгаа тухай ярих болжээ. Сонирхол, сурах арга барил, сайн сурахад нь шаардлагатай дэмжлэгийн хувьд хүүхдүүд хоорондоо ялгаатай гэдгийг хүлээн зөвшөөрөх юм бол боловсролын салбар нь суралцагчдын хоорондын ялгаатай байдлыг асуудал гэж харахаа больж, харин ч сурах үйл явцыг баяжуулах боломж болгон ашиглахад анхаарна. Цаашилбал боловсролын үйлчилгээг ердийн ба тусгай гэж салгахыг хүний эрхийн талаас, мөн зардал үр ашиг талаас шүүмжлэх нь нэмэгдэж байна.

Дүгнэж харахад, тэгш хамруулах боловсрол нь өмнөх үеийн тусгай хэрэгцээт боловсролын интерграцчиллаас ялгаатай. Интеграцчилал нь хүүхдийн боловсролын “тусгай хэрэгцээ”-г илрүүлэх, тогтоох, явагдаж байгаа сургалтад оролцох дэмжлэгүүдийг хангаж өгөхөд анхаардаг. Харин тэгш хамруулах боловсрол бол хүүхдийн сурч боловсрох эрх, уг эрхийг хангах төр тухайлбал, сургуулийн үүргийн тухай юм.

Хүүхэд бүр сурч боловсрох эрхтэй бөгөөд энэ эрхийг хангах үүрэг хүлээгч нь төр юм. Төр нь боловсролын үйлчилгээг хүн бүрт хүргэх үүргээ хэрэгжүүлэх зорилгоор боловсролын тогтолцоог зохион байгуулж, уг тогтолцоог жил бүр иргэдийн татвараас бүрддэг улсын төсвөөс санхүүжүүлж байна. Сургуулийн түвшинд хэрэгжиж байгаа боловсролын үйлчилгээнд хүүхэд бүр хамрагдан, амжилттай суралцаж байх нь зөвхөн ангид сургалт явуулж байгаа багшаас хамаарахгүй, Боловсролын яам, боловсролын дунд шатны менежерүүд, сургуулийн үйл ажиллагааг зохион байгуулж, гарч байгаа асуудал, амжилтыг үнэлж дүгнэж байгаа сургуулийн удирдлагаас хамаарна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуульд элсэхгүй, элссэн зарим нь бага ангидаа завсардаж байгаа, тэдний эзэмшиж байгаа боловсрол чанаргүй байгаа нь хүүхдийн сурч боловсрох эрхийн зөрчил бөгөөд энэ нь бүх иргэнийнхээ сурч боловсрох эрхийг хангах үүрэг хүлээсэн төр хариуцах ёстой асуудал юм. Гэтэл дээр тайлбарласанчлан, сургууль, багш нар сайн ажиллаж байгаа ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд өөрөө сурч чадахгүй байна гэх нь хөгжлийн бэрхшээлд хандах эмнэлгийн загвартай хандлага бөгөөд сурч чадахгүй байгаагийн шалтгаан нь сургалтын үйл ажиллагааны зохион байгуулалт, сургах арга зүйн уламжлалаас бус, харин эдгээрээс ашиг шим хүртэхэд саад болж байгаа хүүхдийн согог, эмгэг юм гэж ойлгоход хүргэнэ. Ингэснээр сургууль, анги танхим, сургах арга зүйгээ өөрчлөх бус, харин хүүхдийн эмгэг, согогийг даван туулахад анхаарлаа чиглүүлж, согог, эмгэгийг даван туулах боломжгүй тул сургах ч бас боломжгүй юм байна гэсэн буруу ойлголтын битүү тойрог үүснэ.

Сурч боловсрох нь хүний эрх тул төр үүрэг хүлээгч болохынхоо хувьд боловсролын үйлчилгээний уламжлалт зохион байгуулалт, багш нарт эзэмшүүлж байгаа уламжлалт сурган хүмүүжүүлэх арга зүйгээ эргэн харж, сургалтын үйл явц, хөтөлбөр, үйл ажиллагааг хүмүүс хоорондын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрсөн байдлаар өөрчилснөөр тэгш хамруулан сургах боловсролын үзэл баримтлал хэрэгжих юм. Эдгээр өөрчлөлт нь зарим хүүхдийн сурч боловсроход саад болж байгаа биет болон институцийн, хандлагын, мэдээллийн саад тотгоруудыг арилгахаас эхэлнэ. Боловсролын үйлчилгээ дэх биет болон нийгэм, эрх зүйн саадунд арилаагүй байгаа учраас л ерөнхий боловсролын үйлчилгээ зарим хүүхдэд хүртээмжгүй болж, үүнийг нөхөх зорилгоор тусгай сургууль бий болсон юм биш үү? Тэгвэл одоо саад тотгоруудаа нэг нэгээр нь арилгаж, ерөнхий боловсролын үйлчилгээгээ Монгол Улсын Үндсэн хуульд заасан ёсоор бүх нийтийн боловсрол болгох хэрэгтэй байна.

Тэгш хамруулан сургах боловсролын үзэл баримтлалын түүхийг товч авч үзье.

Боловсролд бүх хүүхдийг тэгш хамруулан сургах асуудал Олон улсын бичиг үсгийн жилээр зарлагдсан 1990 онд Тайланд Улсын Жомтейн хотноо хуралдсан Бүх нийтийн боловсролын Дэлхийн бага хурлаар анх хөндөгдсөн билээ. 155 орны төлөөлөгч уг хурлаас суурь боловсролыг бүх нийтэд хүргэх уриалга гаргаж, Бүх нийтийн боловсролын дэлхийн тунхаглал (Жомтейны тунхаглал гэж нэрлэгддэг), мөн Сурах суурь хэрэгцээг хангах Үйл ажиллагааны хөтөлбөр баталжээ. Уг баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаар товч дурдсан нь “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурах хэрэгцээнд тусгайлан анхаарах шаардлагатай байна. Бүхий л төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст боловсролоор тэгш хүртээмжтэй хангах асуудлыг боловсролын тогтолцооны салшгүй хэсэг болгоход чиглэсэн алхмуудыг хийх шаардлагатай байна” (3.5 дугаар зүйл) гэж заажээ. Уг заалт нь тухайн хуралд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хоёр байгууллагын хүчин чармайлтын үр дүнд уг тунхаглалд багтсан түүхтэй.

Дараагийн чухал алхам нь 1993 онд НҮБ-аас баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тэгшитгэх стандарт дүрмүүд болов. Уг баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролыг нэгдсэн орчинд зохион байгуулах, тэдний боловсрол нь гишүүн орон бүрийн боловсролын тогтолцооны салшгүй хэсэг байхад анхаарах шаардлага тавигджээ.

1994 онд ЮНЕСКО-аас Испани Улсын Саламанка хотноо зохион байгуулсан Тусгай хэрэгцээт боловсролын дэлхийн бага хурлаас боловсролын философи, боловсролын салбарын стратеги, арга ажиллагааг өөрчлөн шинэчлэх замаар тэгш хамруулан сургах сургуулиудыг бий болгоход анхаарлаа хандуулахыг уриалсан Саламанкагийн тунхаглал гарсан. 92 орны засгийн газар, олон улсын 25 байгууллага уг тунхаглалыг дэмжиж, тэгш хамруулан сургадаг сургуулиудыг дэлхийн боловсролын хэм хэмжээ болгох амлалтад нэгдэн, ердийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургах ажлыг хэрэгжүүлэхэд чиглэсэн Үйл ажиллагааны хөтөлбөрт нэгджээ. Уг бага

хурлаас гарсан тунхаглалд тэгш хамрагдалт, оролцоо бол хүний нэр хүнд, нандин чанарын салшгүй бүрдэл, хүний эрхээ эдлэхийн чухал хэсэг мөн гэж тэмдэглэсэн байна.

2006 онд НҮБ-ын ХБХЭК батлагдсанаар хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсролд тэгш хамрагдах нь эрх болж баталгаажжээ.

Тэгш хамруулах боловсролын цөм нь 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 26 дугаар зүйл буюу хүний сүрч боловсрох эрх юм. 1989 оны НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хүүхдүүдийг ялгаварлан гадуурхахгүй байхыг тунхагласан 2 дугаар зүйл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг тунхагласан 23 дугаар зүйл, боловсролд тэгш эрхтэй хамруулах тухай заасан 29 дүгээр зүйл чухал ач холбогдолтой.

Цаашилбал ялгаварлан гадуурхалтыг хориглох, устгахад чиглэсэн ЮНЕСКО-ын Боловсролын салбар дахь ялгаварлан гадуурхалттай тэмцэх тухай конвенц (1960), Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (1979) чухал юм. Эдгээр нь хүүхэд бүр яс үндэс, нийгмийн байдал, шашин шүтлэг, хүйс, дүрвэгчийн статус, хөгжлийн бэрхшээл зэргээр ялгаварладаггүй боловсролын үйлчилгээ авах эрхтэй болохыг баталгаажуулахыг зорьжээ.

Дасгал 3.1.2.

Боловсрол дахь тэгш бүс байдлыг ойлгох зорилготой дараах дасгалыг багаар гүйцэтгэнэ.

1. Оролцогчдыг 5 бүлэг болгоно.
2. Эхний бүлэг хамгийн олон хүнтэй байх ба тэд тойрог болж зогсоод улаан утсаар тойргоо хүрээлж хэнийг ч, юуг ч нэвтрүүлэхгүй байх дүрэмтэй. Энэ хэсгийн бодлого, үйлчилгээ, соёл зөвхөн энэ тойрогт үйлчлэх тухай тайлбарлана. Энэ бүлгийнхэнд чихэр/печень тарааж өгнө. Тойргийн гадна байгаа группүүдэд өгөхгүй бөгөөд тойргийн гаднаас хүн чихэр/печень өгөхийг хүсэхэд өгөх хариуг багаараа бэлтгэнэ.
3. Дараагийн алхмаар бүгд нийлээд хэлэлцүүлэг хийж, манай боловсролын өнөөгийн хүртээмж нь улаан утсаар хязгаарлагдаж байгаа бол тойрог дотор болон гадна хэн байх (алслагдсан орон нутгийн, шилжин суурьшсан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, үндэсний цөөнх зэрэг), тойрог доторх хүмүүс гадна байгаа хүмүүсийг оруулахгүй, тэдэнд хүрэхгүй байгаагаа ямар шалтгаанаар тайлбарлахыг ярилцана. Эдгээр шалтгаан нь боловсролын үйлчилгээнд хамрагдахад саад болж байгаа бэрхшээлүүд бөгөөд эдгээр бэрхшээл, саадыг арилгах нь хэний үүрэг хариуцлага болох, яагаад гэдгийг мөн нийтээрээ ярилцана.

Дасгал 3.1.2-ын үргэлжлэл

4. Үлдсэн хүмүүсийг тус тусад 4 бүлэг болгож хуваагаад, цагаан, хөх, шар, ногоон өнгийн утсаар хязгаарласан тусдаа тойрог үүсгээд, алслагдсан орон нутгийн, шилжин суурьшсан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, үндэсний цөөнх зэргээр нэрлэнэ. Тойрог бүр нь ямар онцлог хэрэгцээний улмаас улаан тойргоос тусдаа байгаа, боловсролын ямар бодлого тэдэнд үйлчилж байгаа, улаан тойргоос ялгаатай ямар хэрэгцээ байгааг хэрхэн шийдэх, ямар зардал гарах, ямар үр ашиг гарах зэргээр ярьж, бусад нь сонсож, санал нэмэрлэж болно.
5. Улаан тойргийг тэлж, бусад тойргийг оруулж, гэхдээ өөр өнгөтэй утсаар хязгаарлан бөөгнөрүүлсэн байдлаар тойргуудаа нэгтгэнэ. Энэ нөхцөл байдлыг ярилцаж дүгнэх ба үүнд бодлого боловсруулагчдын анхаарал, төсөв хөрөнгө, жижиг бүлгүүдийн дуу хоолой зэргийг дүгнэн ярилцахыг хичээнэ.

Тойргуудыг хязгаарласан олон өнгөтэй утсыг хаяж, оролцогчид нэг том тойрог болж холилдож зогсоно. Одоо хүмүүс ямар нэг шинж байдлаараа ялгарахгүй, бие биеэ янз бүрийн шинж байдлаар ангилж шошиглохгүй сайн талтай болно. Гэхдээ онцлог хэрэгцээ нь ил харагдахгүй тул хүн бүрийн хэрэгцээг ажиглах, сурахад нь дэмжлэг болох ганцаарчилсан арга хэмжээ авч ажиллах шаардлага үүснэ. Энэ тохиолдолд ажлын ачааллын дийлэнхийг дан багшид үүрүүлэхгүй, дээрх ганцаарчилсан арга хандлагыг дэмжсэн тогтолцоо чухал болохыг анхааруулж, дасгал ажлыг дуусгана.



СЭДЭВ 3.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ НЬ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамруулан сургах боловсролын тогтолцоог амжилттай хэрэгжүүлэхийн тулд анхнаасаа асуудлыг харах өнцөг, хэрхэн тодорхойлж байгаагаа өөрчлөх хэрэгтэй болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч чадахгүй байна гэж харснаас болж тэд боловсролын гадна үлдэж байгааг ойлгож, боловсролын үйлчилгээг хэрхэн зохион байгуулж байгаад анхаарлаа хандуулах хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчаас болж боловсролын үйлчилгээ хүрэхгүй байгаа гэсэн ойлголт хандлагаас татгалзаж, боловсролын тогтолцоо маань сурах ялгаатай хэрэгцээ, арга барилуудыг тооцож ажиллаж чадахгүй байгаагаа хүлээн зөвшөөрөх хэрэгтэй байна. Хөгжлийн бэрхшээлд хандах нийгмийн болон хүний эрхэд суурилсан хандлага баримтлан, боловсролын үйлчилгээний зохион байгуулалтаа харж, боловсролын үйлчилгээнд оршин байгаа саад бэрхшээлүүдээ илрүүлж, арилгахад чиглэсэн арга хэмжээг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлснээр Үндсэн хуульд тунхагласан бүх нийтийн боловсрол жинхэнэ утгаараа буюу де факто хэрэгжих эхлэл тавигдана.

Тэгш хамруулах боловсролыг хөгжүүлэх эрх зүйн буюу де юре орчин бүрдсэн байна. Үүний эхлэл 1990-ээд онд ЮНЕСКО-ын манлайлал дор эхэлж, 2006 онд НҮБ-ын ХБХЭК-оор олон улсын гэрээ болж баталгаажжээ. 2009 онд Монгол Улс ХБХЭК-д нэгдэн орсноор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэм, улс төр, эдийн засгийн олон эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах амлалт авсны дотор тэгш хамруулан сургах боловсролыг хэрэгжүүлэх амлалт багтсан юм. 2016 онд Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (ХБХЭХ) баталснаар олон улсын гэрээг дэмжсэн үндэсний эрх зүйн орчин бий болсон.

ХБХЭХ-ийн 14.1-д хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад иргэний хамт сурч боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй гэж заажээ. Цаашилбал уг хуулийн 14.3.2 –т хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг тэдний хүйс, оршин суугаа газар, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлээс үл хамааран бүх шатны боловсролд тэгш хамруулах тухай заасан байна. Улмаар ХБХЭХ-иар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг боловсролд тэгш хамруулан сургах үзэл баримтлал баталгаажсан бөгөөд уг үзэл баримтлалыг хэрэгжүүлэхийн тулд Боловсролын тухай багц хуульд тэгш хамруулан сургах боловсролын зорилтыг тусгаж, хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, үйл явцыг тусган хуульчлах шаардлагатай байна.

Харамсалтай нь, 2016 онд ХБХЭХ батлагдсанаас хойш БСШУСЯ-аас хэд хэдэн журам, аргачлал гарган, сургууль, орон нутгийн түвшинд 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлж эхлээд байгаа боловч Боловсролын багц хуулийн ХБХЭХ-д нийцүүлэх ажил хийгдээгүй байгаа тул Боловсролын хуулиудад тэгш хамруулан сургах боловсролын үзэл баримтлал бүрэн утгаараа тусаагүй байна. Боловсролын хуулиудад одоогоор тусгай сургууль бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сэргээн засах болон боловсролын үйлчилгээ үзүүлэх байгууллага мөн болохыг заагаад, бусад ЕБС нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг элсүүлэн сургах орчин нөхцөл бүрдүүлэх тухай ерөнхийд нь заажээ. Гэтэл НҮБ-ын ХБХЭК болон УИХ-аар баталсан ХБХЭХ нь үүнээс хамаагүй илүү тодорхой заалт, хэрэгжүүлэх арга хэмжээг заасан.

Энэ байдлыг харгалзан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах боловсролын асуудлыг судлахдаа НҮБ-ын ХБХЭК, мөн Монгол Улсын ХБХЭХ-ийг баримтлах хэрэгтэй.

ХБХЭК-ын 24 дүгээр зүйл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсролын тухай бүлэг юм. ХБХЭК-ын 24 дүгээр зүйл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрч, хангахыг амлажээ. Уг эрхийг хангах зорилгоор Конвенцын оролцогч улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг ямар

нэг алагчлалгүй, тэгш боломжийн үндсэн дээр эдлүүлэх үүднээс бүх түвшний боловсролын байгууллагад тэгш хамруулан сургах болоод насан туршийн сургалтын тогтолцоог баталгаажуулна гэж 24.1 дүгээр зүйлд амлажээ. Хачирхалтай нь, Конвенцын 24.1 дүгээр зүйлийн монгол орчуулгад *inclusive* буюу тэгш хамруулан сургах гэдэг хэсэг нь байдаггүй, “*inclusive education system*” гэснийг “боловсролын тогтолцоо” гэж орчуулсан нь уг заалтын үндсэн утга санааг алдагдуулахад хүргэсэн гэж үзэж болно. Уг нь Конвенцын англи эхэд тэгш хамруулан сургах боловсролыг тусгайлан дурдсан байх юм.

Article 24

Education

1. States Parties recognize the right of persons with disabilities to education. With a view to realizing this right without discrimination and on the basis of equal opportunity, States Parties shall ensure an inclusive education system at all levels and lifelong learning (directed at...)

24 дүгээр зүйл

Боловсрол

Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүний сүрч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг ямар нэг алагчлалгүй, тэгш боломжийн үндсэн дээр эдлүүлэх үүднээс оролцогч улсууд нь дараах зорилгод чиглэсэн бүх түвшний болон насан туршийн сургалтын боловсролын тогтолцоог бий болгоно

Тэгш хамруулан сургах боловсролын дараах 4 онцлогийг ЮНЕСКО дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Тэгш хамрагдалт бол үйл явц буюу процесс юм. Тэгш хамрагдалт буюу *inclusion* нь хүмүүсийн ялгаатай байдлыг уян хатнаар тооцох зорилготой мөнхийн эрэл хайгуул, үйл явц юм. Энэ нь ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, ялгаатай байдлаас суралцаж амьдрах тухай асуудал ажээ.
- Тэгш хамрагдалт нь ялгаатай байдлынхаа улмаас саад бэрхшээлтэй тулгарч байгаа бүлэг, хувь хүмүүст тохиолдож байгаа саад, бэрхшээлийг тодорхойлж, илрүүлэн, арилгах үйл явц юм. Улмаар тэгш хамрагдах үйл явц нь олон эх сурвалжаас мэдээлэл цуглуулж, нэгтгэн дүгнээд, үнэлсний үндсэн дээр бодлого, үйл ажиллагаагаа сайжруулах төлөвлөлт хийн, хэрэгжүүлэх үйл явц юм.
- Тэгш хамруулан сургах боловсрол бол бүх сурагчийн элсэлт, оролцоо, сургалтын амжилтыг хангах үйл явц юм. Энэ хүрээнд элсэлт нь хүүхэд хаана сурч байгаа, хэр тогтмол бөгөөд тасралтгүй суралцаж байгаа асуудал, оролцоо нь хэр байгаа, тэр элсэн суралцаж байгаа газраа хэр чанартай суралцаж байгаа тухай байх тул сурагчдын өөрсдийн санал бодлыг тусган байж хэмжих ёстой асуудал, харин сурлагын амжилт бол шалгалт, авсан оноог бус харин сургалтын хөтөлбөрийн зорилтуудтай харьцуулсан сургалтын үр дүнгийн тухай асуудал юм.
- Тэгш хамрагдалт нь бодлогын анхаарал, боловсролын үйлчилгээний гадна үлдэх эрсдэлтэй, сурлагын амжилт гаргаж чадахгүй үлдэх эрсдэлтэй бүлгүүдэд онцгой анхаарахыг шаарддаг. Улмаар статистикийн мэдээ мэдээллээр эрсдэлтэй болох нь харагдаж байгаа бүлгүүдэд тууштай мониторинг хийх, шаардлагатай бол тэдний элсэлт, оролцоо, сурлагын амжилтыг хангах нэмэлт арга хэмжээ авах үйл явц нь тэгш хамрагдалт юм.

Тиймээс Конвенцын монгол эхээс “тэгш хамруулах” гэсэн хэсгийг хассан нь боловсролын үйлчилгээг бусадтай ижил тэгш боломжийн үндсэн дээр авч чадахгүй байх эрсдэлтэй бүлгүүдийг анхаарахгүй орхих, тэдний элсэлт, оролцоо, сурлагын амжилтыг бусад суралцагчтай ижил түвшинд хүргэх нотолгоонд суурилсан бодлого, төлөвлөлт хийхгүй орхих эрсдэл бий болгож байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрч, хангахыг амласан ХБХЭК-ын 24 дүгээр зүйлтэй ижил утгатай заалт манай ХБХЭХ-д бий. Дээр дурдсан 14.1 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад иргэний хамт сурч боловсрох эрхтэй гэж заасны зэрэгцээ 6.3.3 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан боловсролын үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, сурч боловсрох сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгэм, хамт олны дунд бие хүн болж төлөвших, хөгжихийг хязгаарлах ... нь ялгаварлан гадуурхалт гэж үзэх тухай заасан байдаг. Улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүнд боловсролын үйлчилгээ хүртээмжгүй байх, амжилттай сурах орчин нөхцөл бүрдэхгүй байх, үе тэнгийнхэнтэйгээ хамт суралцаж хөгжих боломж бололцоогоор хангахгүй байх нь хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхсан үйлдэл, хүний эрхийн зөрчил болох эрх зүйн орчин 2016 оноос хойш Монгол Улсад үйлчилж байна.

Алагчлахгүй буюу ялгаварлан гадуурхахгүй байх. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролын үйлчилгээнд алагчлагдахгүй, бусадтай ижил тэгш байх үндсэн дээр хамрагдах боломжтой байх ёстой. Үүнд хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар үе тэнгийн бусад хүүхдээс тусгаарлагдахгүй, мөн сурлагын амжилт гаргахад шаардлагатай дэмжлэгээр хангагдах эрх багтана. Боловсролд тэгш хамрагдаж чадахгүй үлдэх эрсдэлтэй бүх хүүхэд, үүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд үе тэнгийн бусад хүүхдийн адил сургуульд элсэн, сургалтын үйл явц болон сургуулийн амьдралд оролцон, сурлагын амжилт гаргахад нь ямар нэг байдлаар саад болж буй эрх зүй, биет, харилцааны, хэлний, нийгмийн, санхүүгийн, хандлагын,

мэдээллийн саад бэрхшээлийг илрүүлж, арилгах нь төрийн үүрэг юм. “Хэрвээ энэ хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй байсан бол түүнд ийм зүйл тохиолдох байсан уу?” гэсэн асуултад “тохиолдохгүй байсан” гэж хариулах боломжтой бол алагчлагдаж байх магадлалтай. Жишээлбэл, хэрвээ 6 настай Э. хөгжлийн бэрхшээлгүй байсан бол нэгдүгээр ангид элсэхгүй үлдэх нөхцөл үүсэх байна уу? Хэрвээ 9 настай Т. хөгжлийн бэрхшээлгүй байсан бол түүнийг 3 дугаар ангийн хөтөлбөрийг гүйцэхгүй байгаа шалтгаанаар сургуулиас гаргах байсан уу?

Цаашилбал ХБХЭХ-ийн 14.3.2 дугаар заалтын эхний хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг тэдний хүйс, оршин суугаа газар, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлээс үл хамааран бүх шатны боловсролд тэгш хамруулах тухай заасан ч 14.3.2-т үргэлжлүүлээд “тухайн хүүхэд, залуучуудын онцлог, хэрэгцээг харгалзсан боловсролын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, тэдний шаардлагад нийцсэн хичээлийн анги, танхимыг ердийн сургуулиудад зохион байгуулах”, 14.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөр, стандартыг боловсруулна гэсэн нь ЕБС-д элссэн нь тусгай ангид суралцах, ердийн анги танхимд хичээллэж байгаа ч тусгай хөтөлбөрөөр сурах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай боловсролын стандарт боловсруулах зэргээр бусад хүүхдээс ялгарах, тусгаарлагдах нөхцөл үүсэх эрсдэлтэй.

НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн Хорооноос 2016 онд гаргасан “24 дүгээр зүйл: Боловсролд тэгш хамрагдах эрх” нэртэй Ерөнхий зөвлөмжийн 4-т тэгш хамруулан сургах боловсролыг хүртээмжтэй болгоход саад болж байгаа нэг бэрхшээл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлах явдал арилахгүй байгаа явдал бөгөөд энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс хүлээх хүлээлтийг бууруулах байдлаар илэрч байгааг онцолжээ. Улмаар манай ХБХЭХ-д хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт хийсэн хөтөлбөр, анги танхим, стандарт боловсруулна гэсэн нь дээрх Зөвлөмжийн заалтыг зөрчсөн байх магадлалтай. ЮНЕСКО-ийн Боловсрол

дахь алагчлахтай тэмцэх тухай конвенцын 1 дүгээр зүйлд сурч боловсрох эрхийг ямар нэг алагчлалгүй, бусадтай адил тэгш боломжийн үндсэн дээр хангах тухай заасан байдаг бөгөөд 2 дугаар зүйлд сургалтын хөтөлбөр адил байгаа тохиолдолд тусгайлан сурахыг алагчлал гэж үзэхгүй гэжээ. Улмаар сургалтын хөтөлбөр, боловсролын стандарт нь нэг ижил бол тусгай анги, тусгай сургуульд сургахыг алагчлал гэж тооцохгүй боловч ихэнхдээ тусгай сургууль, тусгай анги нь цөм хөтөлбөр, боловсролын стандартыг хэрэгжүүлэхгүй байх нь нийтлэг.

ХБХЭХ-д хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхах үзэгдлийг хүний эрхийн байр сууринаас тодорхойлсон байдаг бөгөөд уг хуулийн 4.1.2.“хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхсанд тооцно гэжээ.

Дасгал 3.2.1.

Дараах тохиолдлуудыг судлаад, алагчлал мөн эсэхийг дүгнэж, хэн ямар арга хэмжээ авч болох тухай ярилцана уу.

- Цэцэрлэгт элсүүлэх хүүхдийн тоо гүйцсэн шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй 1, бэрхшээлгүй 2 хүүхдийг авахгүй гэв.
- Энэ жил нэгдүгээр анги авч байгаа багш нараас тусгай хэрэгцээт сургалтын арга зүй эзэмшсэн багш байхгүй гээд хүүхдийг Насан түршийн боловсролын төвд элсүүлэх албан бичгийг сургуулийн захирал хийж өгсөн.
- Тархины саажилттай хүүхэд гэнэт гараа саваад, ангийн хүүхдүүд цохих байх гэж айдаг болсон, мөн бусад хүүхдүүд хажууд нь суух дургүй байгаа тул хүүхдээ тусгай сургууль руу явуулах тухай багш нь зөвлөжээ.
- Багш дутагдалтай шалтгаанаар 6Г ангийг тарааж, сурагчдыг бусад ангид тараасан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ангийнхаа 3 хүүхдийн хамт өөр сургуулийн 6 дугаар ангид сурах болжээ.

Боловсролын зорилгоо хангаж байх: Боловсрол нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүх чадвар, потенциалыг бүрэн дүүрэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, нийгэмд үр дүнтэй оролцохыг нь дэмжин, хүний эрх, эрх чөлөө, хүний ялгаатай байдал, хүлээцтэй хандах, байгаль орчноо хайрлах талаар ойлголт мэдлэгтэй

болоход туслах ёстой. ХБХЭ-ийн Хорооны Ерөнхий зөвлөмж 4-ийн 17-д ХБХЭК-ын 1 дүгээр зүйлд боловсролын зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг чөлөөт нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход чиглэсэн байх тухай заасан бөгөөд Хүүхдийн эрхийн тухай конвенцын 23 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн оролцоо, хувийн хөгжлийг боломжийн хэмжээнд бүрэн дүүрэн хангахад чиглэсэн боловсролыг хүртээмжтэй болгох үүргийг төр хүлээж байгааг сануулжээ. Манай ХБХЭХ-ийн 14.1.1-д төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт нийцүүлэн авьяас билэг, бүтээлч чанар, оюуны болон бие бялдрын чадварыг хөгжүүлэх, 14.1.2-т хувь хүний чадамж болон өөрийгөө үнэлэх үнэлэмжийг хөгжүүлж, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авна гэж заажээ. Төр энэхүү амлалтаа хэрэгжүүлэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ганцаарчилсан дэмжлэгээр хангах, боловсролын үйлчилгээндээ ялгаатай байдлыг харгалзсан боломжит тохируулгуудыг хийх шаардлагатай.

Дасгал 3.2.2.

Дараах тохиолдлуудыг судлаад, боловсролын зорилгод нийцэж байгаа эсэхийг дүгнэж, авч болох арга хэмжээг ярилцана уу.

- Сургууль нь оюуны бэрхшээлтэй өсвөр насны хүүхдийг амьдралд бэлтгэх хөтөлбөрөөр барилгын өрлөгчний зэрэгтэй болгосон ба зөвхөн биеийн тамир, дууны хичээл дээр ангийнхантайгаа хичээллэдэг.
- Сурлагаар хоцорсон хөгжлийн бэрхшээлтэй дунд ангийн хүүхдүүдийг нэг анги болгон, ганцаарчилсан хөтөлбөрөөр сургаж байгаа.

Боловсролын үйлчилгээнээс хасахгүй: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын гадна үлдээж болохгүй. Ерөнхий боловсролын хүртээмжийг хязгаарласан аливаа эрх зүйн заалтыг хүчингүй болгох ёстой. Хөгжлийн бэрхшээлийн улмаас боловсролд тэгш хамрагдахад саад болдог шууд ба шууд бус хязгаарлалтууд байдаг бөгөөд эдгээрийг бүгдийг арилгах, хүчингүй болгох шаардлагатай юм. Шууд хязгаарлалтын жишээнд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй бол сургуульд элсүүлж болох тухай заалт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрийнх нь “чадамжийн хэрээр сургах” зэрэг нөхцөл тавих, боломжит тохируулга хийхгүй байх боломжийг хуулиар олгох зэргийг нэрлэж болно. Хүүхдүүдийн чадавхыг үнэлж, сурах боломжгүй хэмээн тодорхойлох боломж олгосон зохицуулалт нь шууд хязгаарлалтын өөр нэг жишээ болно.

Монгол Улсад хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоож, шаардлагатай хөгжүүлэх болон нийгмийн үйлчилгээнд холбон зуучлах үүрэгтэй Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын тогтолцоо ажиллаж байна. Уг Комисс нь салбар хоорондын зохицуулалт, холбон зуучлал хийх, үзүүлж буй үйлчилгээнд хяналт тавих чиг үүрэгтэй. Харин ХБХЭХ-ийн 14.2 ...бүх шатны боловсролын байгууллага нь энэ хуулийн 37.2.1-д заасан Комиссын дүгнэлтээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүүхдийн хөгжлийн цогц хөтөлбөрийн дагуу боловсрол эзэмшүүлэх” гэж заасан нь буруу ойлгогдох эрсдэлтэй байна. Уг Комисс нь ганцаарчилсан хөтөлбөрөөр сурах хүүхдүүдийг илрүүлж, сургуульд зөвлөн ажиллахаар эрх зүйд заасан боловч зарим орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ердийн сургуульд сурах, эсвэл тусгай сургуульд сурах шийдвэрийг уг Комисс гаргаж байсан тохиолдол бий. Гэхдээ ХБХЭХ-ийн 14.1.3-т бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг түслалцаа үзүүлэх тухай заасан нь түүштай хэрэгжүүлж чадвал хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдийг боловсролын аль ч шат, чиглэлийн үйлчилгээнээс хасагдахгүй байх боломжийг олгох юм.

Шууд бус хязгаарлалтад тохирох хэрэглэгдэхүүнээр хангахгүйгээр сурах чадвартайгаа баталсан шалгалт өгөхийг санал болгож, тодорхой үр чадвар хөгжүүлсний дараа сургуульд авах нөхцөл тавих зэрэг болно. Жишээлбэл, хүүхэд үзэг бариад сурчих юм бол нэгдүгээр ангид элсүүлэхэд татгалзах зүйлгүй гэсэн албан бичгийг сургуулиас гаргаж өгч байсан тохиолдол бий. Гэхдээ боловсролын салбарт ийм тохиолдлын тоо цөөрч байгаа нь ажиглагддаг.

Дасгал 3.2.3.

Дараах тохиолдлуудыг судлаад, ерөнхий боловсролын үйлчилгээ үзүүлэхээр татгалзсан явдал мөн эсэхийг тодорхойлж, авч болох арга хэмжээг ярилцана уу.

- Хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд биш Насан түршийн боловсролын төвд сургах боломжтой.
- Байнгын асаргаа шаардлагатай, хэвтрийн дэглэмтэй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сургуулийн багш нар долоо хоногт 2 удаа гэрээр очиж хичээл заадаг.
- Гэрт нь ойрхон тусгай сургууль байгаа болохоор тусгай сургуульд явуулахыг захирал зөвлөсөн.
- Дохионы хэлтэй багш байхгүй тул хүүхдийг элсүүлэх боломжгүй байгааг захирал тайлбарлав.
- Харааны бэрхшээлтэй хүүхэд брайл сурах бичиг байхгүй гэсэн шалтгаанаар гэрийн даалгавраа тогтмол хийхгүй, үүний улмаас сурлагаар хоцорч байна гээд сургуулиас хасахаар болжээ.

Бага, дунд боловсролын хүртээмж: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тэгш хамруулан сургадаг, чанартай, үнэ төлбөргүй бага, дунд боловсролыг амьдарч байгаа орчиндоо эзэмших эрхтэй. ХБХЭрхийн Хорооны 2016 оны 4 дүгээр Ерөнхий зөвлөмжийн 20-д төрийн болон төрийн бус хэвшлийн чанартай сайн сургалтын байгууллага, хөтөлбөрүүд хангалттай тоогоор байх шаардлагатай бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлэх боловсролын байгууллагыг өргөнөөр байлгах нь төрийн хариуцах асуудал болохыг онцолжээ.

Хүртээмжтэй орчин гэдэг ойлголтод сургуулийн орчныг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ашиглах боломжтой байх (үүнд сургуулийн барилга, автобус, тоглоомын талбай, ариун цэврийн өрөө, сургалтын хөтөлбөр, сургалтын материал, сургалтын арга зүй, шалгалт, дэмжих үйлчилгээ зэрэг багтана)-аас гадна хүлээн зөвшөөрөгдөх асуудал багтах тул сургууль, боловсролын үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ, соёл, хэл харилцааг хүлээн зөвшөөрөгдөхүйц байлгах асуудлыг багтаана. Ингэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг байгаа орчин нөхцөлд дасан зохицохыг шаардах бус, харин сургууль нь хүүхдүүдийн ялгаатай хэрэгцээнд үйл ажиллагаагаа нийцүүлэх ёстой.

НҮБ-ын ХБХЭрхийн Хорооны зөвлөмж 23-т хүртээмжтэй байхын тулд боловсрол нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд өртөг зардлын хувьд нэмэлт дарамт болох ёсгүй бөгөөд боломжит тохируулга/тохирох хэрэглэгдэхүүн нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нэмэлт зардал учруулах ёсгүй. Үнэ төлбөргүй, хүртээмжтэй суурь боловсрол бол Монгол Улсын иргэн бүрт Үндсэн хуулиар олгогдсон эрх учраас шууд хэрэгжүүлэх ёстой төрийн үүрэг болно.

Дасгал 3.2.4.

Дараах тохиолдлуудыг судлаад, бага дунд боловсролын хүртээмжтэй үйлчилгээний жишээ мөн эсэхийг тодорхойлоод, авч болох арга хэмжээг ярилцана уу.

- Сургуулийн барилга урдаа өндөр шаттай тул тэргэнцэртэй 2 хүүхэд сургуулийн арын хаалгаар орж болохоор засвар хийсэн.
- Гадаа модон жорлонтой сургууль тэргэнцэртэй 2 хүүхдээ хажуугийн цайны газрын ариун цэврийн өрөөг ашиглаж байхаар зохицуулсан.
- Дохионы хэлний орчуулагч байхгүй тул эцэг эх нь орчуулагч хөлсөлж, хичээл дээр нь багшид түслүүлж байгаа.
- Хувийн сургуулийн сургалтын хөтөлбөр нь өндөр ачаалалтай тул хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг элсүүлэх боломжгүй.
- Брайл сурах бичиг байхгүй тул хичээлийн дараа ангийнхаа хүүхдүүдийг гүйж уншуулаад, хамт даалгавраа хийж байгаа.
- Сонсголын бэрхшээлтэй сурагчийг дууны хичээлээс, тэргэнцэртэй сурагчийг биеийн тамирын хичээлээс, харааны бэрхшээлтэй сурагчийн тооны хичээлээс чөлөөлдөг.

Боломжит тохируулга буюу тохирох хэрэглэгдэхүүн. ХБХЭХ-д тохирох хэрэглэгдэхүүн (ХБХЭК-д боломжит тохируулга)-ээр хангахгүй байх нь хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхалт мөн болохыг тодорхойлж, мөн хуулийн 14.1.3-т бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сүрч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлэх тухай заагаад, уг ажлыг боловсролын асуудал эрхэлсэн сайд хариуцахаар хуульчилсан байна. Улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүний тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах эрх нь де юре буюу эрх зүйн хувьд баталгаажжээ.

ЮНЕСКО-оос хөгжлийн бэрхшээлтэй суралцагч тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах нь бусадтай ижил тэгш суралцах нөхцөлөөр хангагдаж байгаа хэрэг хэмээн тайлбарлажээ. Манай ХБХЭХ-ийн тодорхойлолтоор, тохирох хэрэглэгдэхүүн гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг хэлнэ гэжээ. Тиймээс тохирох хэрэглэгдэхүүн нь зөвхөн материаллаг хангамжаар хязгаарлагдахгүй, тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоо, хөгжлийг хангах орчин, үйлчилгээ, программ хангамжийг багтаасан ойлголт юм.

Дасгал 3.2.5.

ХБХЭХ-ийн дараах тайлбаруудыг судлаад, доорх жагсаалтад багтсан зүйлс тохирох хэрэглэгдэхүүн буюу боломжит тохируулга мөн эсэхийг ялгаж, тухай бүрт нь үндэслэл өгнө үү.

Тодорхойлолт:

4.1.1. “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг;

4.1.2. “хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг;

4.1.3. “тохирох хэрэглэгдэхүүн” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг;

4.1.4. “түгээмэл загвар” гэж нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад тохиромжтой, энгийн бүтээгдэхүүн, программ, орчин болон үйлчилгээний хэв маягийг хэлнэ.

Жагсаалт

- тэргэнцэр, цагаан таяг, энгийн суга таяг зэрэг туслах хэрэгсэл

Дасгал 3.2.5-ын үргэлжлэл

- хиймэл хөл/гар/нүд, өндөрлөсөн ултай гутал зэрэг протез, ортопедийнн бүтээгдэхүүн
- живх, истомын уут зэрэг ариун цэвэр, эрүүл ахуйн материал
- хөтөч нохой
- дохионы хэлний хэлмэрч, орчуулагч
- харааны бэрхшээлтэй хүний ашигладаг ярьдаг ном, сурах бичиг, текстийг аудио руу хөрвүүлэгч
- сонсголгүй хүүхдүүдийн театр
- сонсголгүй хүүхдүүдийн олимпиад
- тэргэнцэртэй хүүхдийн ангийн бүх хичээлийг 1 дүгээр давхарт байхаар хуваарь гаргах
- хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн шалгалтын цагийг сунгах
- тархины саажилттай хүүхдийн бичгийн гэрийн даалгаврыг аман даалгавраар солих
- харааны бэрхшээлтэй хүүхдийн тооны шалгалтын зарим даалгаврыг хасах
- сонголттой хариулт бүхий шалгалтыг компьютер дээр гүйцэтгэхийг зөвшөөрөх
- сонголттой хариулт бүхий шалгалтын материалыг харааны бэрхшээлтэй хүүхдэд уншиж өгөх, хүүхдийн өгсөн хариултыг цаасан дээр тэмдэглэх туслах хүн гаргах
- чимээнд мэдрэмтгий хүүхдийн анхаарал төвлөрлийг дэмжих зорилгоор амрах харанхуй өрөө гаргах, шалгалтын үеэр ганцаараа суух тусдаа өрөө гаргах

Ямар төрлийн тохируулга хэрэгтэй болохыг хүүхэд хамт шийдэх ёстой бөгөөд шаардлагатай бол эцэг эх, асран хамгаалагчийг оролцуулж болно.

Тохирох хэрэглэгдэхүүнийг хүүхдийн онош, согогоос хамааруулан сонгож болохгүй. Харин тухай хүүхдийг сургуульд ирэх, анги танхимын үйл ажиллагаанд бусад хүүхдийн адил оролцох боломжийг нь хязгаарлаж байгаа саад тотгоруудыг арилгах зорилгоор сонгоно.

Тохирох хэрэглэгдэхүүнээр хангахгүй байх нь ялгаварлан гадуурхалтад тооцогдох тул сургууль, үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тохирох хэрэглэгдэхүүнээр хангахаас татгалзсан шийдвэр гаргах юм бол хөгжлийн бэрхшээлтэй хүн гомдол гаргах эрхтэй. ХБХЭХ-ийн 6.7-д төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд эрх тэгш, бүрэн дүүрэн оролцохыг баталгаажуулах зорилгоор тэднийг тохирох хэрэглэгдэхүүнээр хангах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ гэж заасан нь манай дотоодын эрх зүйд тохирох хэрэглэгдэхүүнээр хангах асуудал хуульчлагдсан байна гэж үзэх бүрэн үндэслэлтэй. Харин хүний эрхийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ гэж юу болохыг албан ёсны тайлбараас үзье.

Олон улсын хүний эрхийн гэрээ конвенцод эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангахтай холбоотой төрийн үүрэг нь аажмаар, дэвшилттэйгээр буюу үе шаттайгаар хэрэгжүүлэх зарчимд суурилсан байдгаараа улс төрийн болон иргэний эрхийг хангахтай холбоотой төрийн үүргээс ялгаатай. Энэ тохиолдолд **“үе шаттай хэрэгжүүлэх”** гэдэг нь байгаа нөөц бололцооны хэрээр хүний эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг бүрэн дүүрэн хангахад чиглэсэн зохистой арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг юм. **“Боломжит нөөцийн хэрээр”** гэсэн нь эдгээр эрхийг хэрэгжүүлэхэд хөрөнгө нөөц дутах явдал тодорхой хэмжээний саад учруулж болох бөгөөд эдгээр эрхийг бүрэн дүүрэн хангахад тодорхой хугацаа шаардлагатай болохыг хүлээн зөвшөөрсөн байна. ХБХЭК-ын 4.2-т Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухайд

эдгээр эрхийг бүрэн дүүрэн эдлүүлэх нөхцөл байдлыг аажмаар бий болгох оролцогч улс бүр олон улсын эрх зүйн дагуу нэн даруй үүсэх энэхүү конвенцоор хүлээлгэсэн үүрэгтэй үл харшлах байдлаар өөрийн боломжит нөөцийг дээд хэмжээгээр ашиглах бөгөөд шаардлагатай тохиолдолд олон улсын хамтын ажиллагаанд түшиглэнэ гэж тодорхой заажээ.

Дасгал 3.2. 6.

Дараах эрхүүдийг Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад тодорхойлсноор нь хоёр салгаж бичээрэй. Анхааруулахад Эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүд нь иргэний болон улс төрийн эрхүүдээс салшгүй бөгөөд ийнхүү ялгаж байгаа нь эрх зүйн баримт бичигт дурдсанаар баримжаалж байгаа болно. Дараа нь асуултуудад хариулна уу (сургагч багшид зориулж эдгээр эрхийг салгаж бичсэн бөгөөд оролцогчдод тараахдаа эрхүүдийг бүлэглэхгүй, хольж байршуулахыг зөвлөж байна).

Иргэний болон Улс төрийн эрх

Эх сурвалж: Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт

- Амьд явах эрх
- Эрүү шүүлтээс ангид байх эрх
- Эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрх

Эдийн засаг, нийгэм, соёлын эрх

Эх сурвалж: Хүний Эрх Хөгжил Төв

http://www.chrd.org.mn/images/НЕНТ/mongolia%20-%20icescr%20-%20pp_mon.pdf

- Ард түмэн өөртөө засан төвхнөх эрх
- Хөдөлмөрлөх,
- Ажиллах шударга, таатай нөхцөлтэй байх

Дасгал 3.2.6-ийн үргэлжлэл

- Улсынхаа дотор чөлөөтэй зорчих, амьдран суух газраа чөлөөтэй сонгох эрх
- Шүүхийн өмнө адил тэгш байх эрх
- Чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрх
- Үзэл бодлоо илэрхийлэх эрх
- Үг хэлэх эрх
- Хуран цуглах эрх
- Эвлэлдэн нэгдэх эрх
- Гэрлэх, өрх тусгаарлах эрх
- Сонгох, сонгосон эрх
- Өмчтэй байх эрх
- Үйлдвэрчний эвлэл байгуулах, түүнд нэгдэх эрх
- Нийгмийн даатгал болон нийгмийн хамгаалал эдлэх эрх
- Гэр бүлээ хамгаалуулах эрх
- Зохистой орон байр, хоол хүнстэй байх эрх
- Өлсгөлөнгөөс ангид байх эрх
- Бие бялдар болон сэтгэцийн эрүүл мэндийн хүрч болох дээд түвшинд байх эрх
- Усны эрх
- Сурч боловсрох эрх
- Соёлын амьдралд оролцох эрх
- Шинжлэх ухааны дэвшлийн үр шимийг хүртэх, ашиглах эрх
- Өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээлээс хүртэх ёс суртахууны болон эд материалын ашиг сонирхлоо хамгаалуулах зохиогчийн эрх эдлэх

Асуултууд: дараах асуултуудыг ярилцаж, боломжтой бол гэрийн даалгаварт өгөх

1. Улс төр, иргэний эрхийг нэн даруй, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг аажмаар дэвшилттэйгээр хэрэгжүүлэх үүргийг төр хүлээнэ гэснийг тайлбарлах
2. Хэдийгээр Улс төр, иргэний эрх, Эдийн засаг, нийгэм, соёлын эрх гэж ялгах ч эдгээр нь хоорондоо холбоотой, нэг нь нөгөөгөөсөө илүү эсвэл чухал гэсэн санаа агуулаагүй болохыг онцлон ярилцах

Аажмаар дэвшилттэйгээр буюу үе шаттай хэрэгжүүлэх зарчмыг төр хангалттай нөөц боломжтой болох хүртэл эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангах, хамгаалах албагүй гэж буруугаар ойлгож болохгүй. Харин ч эсрэгээрээ, олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орсон даруйд төрөөс иргэдийнхээ эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх чиглэлд зохистой арга хэмжээ авах нэн даруй үүрэг үүснэ. Нөөц боломж хязгаарлагдмал байгаа нь эдгээр эрхийг хангахтай холбоотой эс үйлдэхүйн, эсвэл тодорхойгүй хугацаагаар хойшлуулахын үндэслэл болохгүй. Нөөц хөрөнгө нэн хязгаарлагдмал байгаа нөхцөлд ч гэсэн төрөөс эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүдийг иргэддээ эдлүүлэхийн тулд дээд зэргээр хүчин чармайлт гаргаж байгаагаа тодорхой харуулах ёстой.

Энэ тайлбараас харахад тэгш хамрах боловсрол нөөц их шаарддаг тул одоохондоо хэрэгжүүлэх боломжгүй, эсвэл нөөцөө бүрдүүлж байгаад хэрэгжүүлж эхэлнэ гэсэн тайлбараар төр эс үйлдэхүйгээ хамгаалах ёсгүй. Тэгш хамруулах боловсрол бол чанартай боловсролоос хоцрох эрсдэлтэй бүх хүүхдийг боловсролд хамруулах үйл явц тул үүнд чиглэсэн алхмууд аажмаар, гэхдээ дэвшилттэйгээр хэрэгжиж байх ёстой. Үүний нэгэн адилаар, тохирох хэрэглэгдэхүүн буюу боломжит тохируулга бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүрэн дүүрэн оролцоог хязгаарлаж байгаа саадүүдыг илрүүлэн, арилгах үйл явц юм. Нөөцөө бүрдүүлсний дараа, багш нараа сургаж байгаад хэрэгжүүлэх алхам биш аажмаар гэхдээ дэвшил гарган хэрэгжүүлсээр байх үйл явц юм.

Тохирох хэрэглэгдэхүүн нь тухайн нөхцөл байдалд нийцсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээг үр дүнтэй хангаж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хэт их дарамт учруулахгүйгээр оролцоог хангах шийдэл юм. Гэхдээ дээр дурдсанчлан, байгууллагад хэт их дарамт болж байгаа шалтгаанаар тохирох хэрэглэгдэхүүн/ боломжит тохируулгыг хангахаас татгалзах боломжгүй бөгөөд татгалзсан тохиолдолд хөгжлийн бэрхшээлээр алагчилсан явдал болж, хөгжлийн бэрхшээлтэй

хүний эрх зөрчигдөх аюултай. Боловсролын үйлчилгээнд тохирох хэрэглэгдэхүүн/боломжит тохируулгыг ерөнхий дэмжлэг, ганцаарчилсан дэмжлэг, тодорхой хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй онцлог дэмжлэг гэж ангилан үзэж болно.

- **Ерөнхий дэмжлэг** нь бүх хүүхдийн амжилттай сурахтай холбоотой асуудал бөгөөд үүнд хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нь жишээлбэл, мэргэжлийн багштай байх, багш нь аргазүйн дэмжлэгээр хангагдсан байх, нийгмийн ажилтан, сургуулийн эмчийн үйлчилгээнд хамрагдах боломжтой байх, тэтгэлгээр сурах боломжтой байх, санхүүгийн дэмжлэгт хамрагдах боломжтой байх зэргийг багтааж болно.
- **Ганцаарчилсан дэмжлэг** нь хөгжлийн бэрхшээлтэй тодорхой хүүхдийг тухайн сургууль, тухайн ангид, тодорхой хичээлээр бусадтай ижил нөхцөлд сурах боломж олгоход чиглэгдсэн нэмэлт арга хэмжээ юм. Эдгээр дэмжлэгийг Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх журам манайд үйлчилж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болгонд ийм тодорхой дэмжлэг шаардагдахгүй бөгөөд жишээлбэл, нуруу нугасны эсвэл тулах эрхтний гэмтэл, согогийн улмаас тэргэнцэр хэрэглэдэг хүүхэд хүртээмжийг хангасан сургуулийн орчинд нэмэлт дэмжлэггүйгээр суралцах боломжтой. Ганцаарчилсан дэмжлэгийг сурагчтай хамтран, шаардлагатай бол эцэг эх, асран хамгаалагчийг оролцуулан төлөвлөх бөгөөд хэрэгжилтийг тогтмол хугацаанд дүгнэн, өөрчлөх боломжтой.
- **Тодорхой хөгжлийн бэрхшээлтэй холбоотой саадыг даван туулахад чиглэсэн ганцаарчилсан дэмжлэг.** Зарим төрлийн хөгжлийн бэрхшээл нь тусгайлсан үйлчилгээ шаарддаг бөгөөд энэ үйлчилгээ нь тэднийг боловсролд хамруулах, сурлагын амжилт болон нийгэмшихүйн үр чадвараа ахиулахад шаардлагатай. Тухайлбал:

- Хараагүй, хараа алдагдалтай сурагчдад брайл хэл бичиг заах, сургуулийн орчинд орон зайн баримжаатай болгох, хөдөлгөөний үр чадварыг хөгжүүлэх үйлчилгээ шаардлагатай. ХБХЭХ-ийн 13.1-д Брайл бичиг нь хараагүй хүний хэрэглэдэг үндсэн бичиг бөгөөд брайл бичгийг ашиглан мэдээлэл авах, боловсрол эзэмшин нийгмийн харилцаанд оролцох нөхцөл боломжоор хангана гэж заажээ. Мөн хуулийн 15.1.5-д боловсролын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурах идэвх, санаачилгыг нэмэгдүүлэхэд чиглэсэн, тэдний онцлог хэрэгцээнд нийцүүлэн брайл үсэг... хэрэглэх, орон зай, чиг баримжааны чадвар олгох, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээж байна. Хуулийн 15.11-д ... брайл болон программ хангамжийг монгол хэл рүү хөрвүүлэх, сургалтын тоног төхөөрөмжийг улсын төсөвт тусгах санхүүжүүлэх тухай заажээ.
- Сонсголгүй, сонсголын бэрхшээлтэй сурагчдад дохионы хэл сургах, хэл яриа, үгийн баялгийг нь хөгжүүлэх, хэл заслын үйлчилгээнд хамруулах, яриаг текст рүү хөрвүүлдэг технологи болон сонсголын аппараттай радио долгионоор холбогддог технологийг эзэмшихэд сургах шаардлага гарна. ХБХЭХ-ийн 12.1-д Монгол дохионы хэл бол сонсголгүй хүний эх хэл мөн бөгөөд сонсголгүй хүн дохионы хэлээрээ нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхтэй болохыг заагаад, 15.1.5-д хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурах идэвх, санаачилгыг нэмэгдүүлэхэд чиглэсэн, тэдний онцлог хэрэгцээнд нийцүүлэн дохионы хэл болон харилцааны бусад арга хэлбэрийг хэрэглэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх; 15.11-д ... дохионы хэлний толь бичиг зохиох, хэвлэх, түгээх, засан сайжруулах, сургалтын тоног төхөөрөмж худалдан авах хөрөнгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр заажээ.

- Хэл ярианы болон харилцааны согогтой сурагчдад харилцааны хувилбарт аргуудыг ашиглан өөрийгөө илэрхийлэх боломж олгох, эдгээр арга зүй, технологид сургах хэрэгтэй. Манай дотоодын хуульд хувилбарт харилцааны аргууд, зурган харилцаа зэрэг асуудлыг тусгаагүй байна.
- Нийгмийн харилцааны хүндрэл бэрхшээлтэй сурагчдын хувьд хичээл сургалтын зохион байгуулалт чухал ач холбогдолтой учраас багш жижиг багаар болон хосоор ажиллах, багшид ойр суулгах, хичээлийн явцыг тогтсон хэмнэлтэй, анги танхимын орчныг танил бөгөөд нэг хэвийн байлгахад чиглэсэн менежментийг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай. Одоогоор манай дотоодын эрх зүйд энэ асуудал тусаагүйгээр барахгүй багш бэлтгэх, багшийн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт анги танхимын менежментийн агуулга тусгагдаагүй байна.
- Оюуны бэрхшээлтэй хүүхдүүдэд багш энгийн хэл найруулгатай унших материал өгөх, хичээлийн өрнөлтийг тогтсон хэмнэлтэй, ойлгомжтой болгоход анхаарна. Мөн оюуны бэрхшээлтэй хүүхдэд боловсролын тохируулга хийх нэг арга нь сургалтын хөтөлбөрийн модификацын арга юм. Модификац нь оюуны бэрхшээлтэй хүүхдэд мэдээлэл хүлээж авах, боловсруулах үнэлгээ хийж, өөрийнх нь биологийн наснаас зөрүүтэй ч мэдээлэл боловсруулах насанд нь нийцтэй хөтөлбөрийг Ганцаарчилсан сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх арга юм. Ингэхдээ хүүхдийг үе тэнгийн буюу биологийн насны хувьд чацуу хүүхдүүдтэй нэг ангид, тухайн ангийн хичээлийн явцад бусдад аль болох ажиглагдахгүйгээр модификац хийсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг шаардана. Уг модификац хийсэн хөтөлбөрийг зохих шатны боловсролын мэргэжлийн байгууллагаар хянуулан батлуулж, хэрэгжүүлдэг туршлага бусад оронд байдаг.

Тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэхэд маш чухал нөлөөтэй өөр нэг зүйл бол **бэлтгэгдсэн багш нар** юм. Тэгш хамруулан сургах орчинд үр дүнтэй ажиллахад багш нарыг сургах, мэргэжил арга зүйн дэмжлэгээр хангах хэрэгтэй. Манай улсад сургууль доторх Дэмжлэгийн багийн тогтолцоо бий болж байгаа бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын Сайд, Эрүүл мэндийн Сайдын 2018 оны А/304, А/699, А/460 дугаартай хамтарсан тушаалаар уг багийг бий болгосон. Багшийг дэмжих энэхүү механизм нь сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, сургуулийн эмч, анги удирдсан багш, бусад хичээл заах багш нарыг багтаасан арга зүйн зөвлөл юм. Дэмжлэгийн баг нь шаардлагатай хүүхдэд “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө” боловсруулахаас гадна хүүхдийн хэрэгцээнд нийцсэн тохирох хэрэглэгдэхүүн байгаа эсэхэд хяналт тавих үүрэгтэй ажээ. Уг Баг нь одоогийн байдлаар сургууль болгон дээр ажиллаж эхлээгүй байгаа ч ажиллаж байгаа туршлагатай сургуулиудын багш нарыг нэгтгэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ангидаа элсүүлэн сургаж байгаа багшид мэргэжил, арга зүйн болон сэтгэл санааны, мөн эцэг эхэд мэдээллийн дэмжлэг болж байна.

Цаашилбал хүмүүсийн ялгаатай байдал нь мэргэжлийн амжилт гаргахад нөлөөлөхгүй гэдгийг биечлэн харуулах, нийгэмд ялгаатай байдлыг тэвчих үнэт зүйл бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний эцэг эхэд урам зориг, үлгэр дуурайлал үзүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллаж байгаа багш нар эерэг нөлөөтэй гэж олон улсын байгууллагууд зөвлөж байна.

ХАВСРАЛТ 1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ

24 дүгээр зүйл

Боловсрол

1. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг ямар нэг алагчлалгүй, тэгш боломжийн үндсэн дээр эдлүүлэх үүднээс оролцогч улсууд нь дараах зорилгод чиглэсэн бүх түвшний болон насан туршийн сургалтын боловсролын тогтолцоог бий болгоно:
 - a) хүний чадвар, нандин чанарын мэдрэмж болон өөрийгөө үнэлэх үнэлэмжийг бүрэн дүүрэн хөгжүүлж, хүний эрх, үндсэн эрх чөлөө болон хүний ялгаатай байдлыг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх;
 - b) хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийн шинж чанар, авьяас чадвар, бүтээлч чанар болон тэдний оюуны болон бие махбодын чадварыг байж болох хамгийн бүрэн дүүрэн хэмжээгээр хөгжүүлэх;
 - c) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг чөлөөт нийгэмд үр дүнтэйгээр оролцох боломжийг олгох.
2. Эдгээр эрхийг хэрэгжүүлэх үүднээс оролцогч улсууд нь дараах зүйлээр хангана:
 - a) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь хөгжлийн бэрхшээлийн улмаас ерөнхий боловсролын тогтолцооны гадна, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хөгжлийн бэрхшээлийн улмаас үнэ төлбөргүй, заавал эзэмших ёстой бага боловсрол болон дунд боловсрол олгох үйл ажиллагааны гадна үлдэхгүй;

- b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь өөрсдийн амьдарч буй орчиндоо бусадтай адил тэгш байх үндсэн дээр тусгай, үнэ төлбөргүй, чанартай, бага боловсрол болон дунд боловсролыг эзэмших боломжтой байх;
 - c) хувь хүний онцлог шаардлагад нийцсэн боломжит хэрэглэгдэхүүнээр хангагдах;
 - d) ерөнхий боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь өөрсдийн үр дүнтэйгээр сурч боловсрох нөхцөл байдлыг хангуулах үүднээс шаардлагатай дэмжлэг туслалцаа авах;
 - e) түүнчлэн, мэдлэг олгох болон нийгмийн хөгжилд аль болох дэмжлэг үзүүлснээр хувь хүнд зориулж авах арга хэмжээг үр дүнтэй байлгаж, бүрэн дүүрэн оролцуулах зорилтыг хангах.
3. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн гишүүний хувьд боловсролд бүрэн дүүрэн, тэгш оролцоход нь дэмжлэг үзүүлэх амьдралын болон нийгмийн хөгжлийн үр чадваруудыг эзэмших боломжийг олгоно. Үүний тул оролцогч улсууд нь дараах зүйлийг оролцуулан шаардлагатай бусад арга хэмжээ авна:
- a) брайл үсэг болон түүнтэй төстэй өөр үсэг, нэмэлт болон сонголтот арга, төрөл хэлбэр, харилцаанд хэрэглэх бусад хэв маяг, түүнчлэн орон зайн чигийг баримжаалах болон хөдөлгөөн дэмжих үр чадвар эзэмшүүлэх, үе тэнгийнхэн болон сургагч нараас үзүүлэх туслалцаанд дэмжлэг үзүүлэх;
 - b) дохионы хэл сургахад туслалцаа үзүүлэх болон дүлий хүмүүсийн хоорондын хэл ярианы өвөрмөц онцлогийг хөхиүлэн дэмжих;
 - c) мэдлэг олгох болон нийгмийн хөгжилд аль болох дэмжлэг үзүүлснээр хүмүүс, ялангуяа хараагүй, дүлий, хараагүй-дүлий хүүхдүүдэд олгох боловсролыг тухайн хүний онцлогт нийцсэн хамгийн зохистой хэл яриа, арга хэлбэр, харилцаанд хэрэглэх бусад хэв маягаар олгох явдлыг хангах.

4. Эдгээр эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор оролцогч улсууд нь багш нар, ялангуяа брайл үсэг эсхүл дохионы хэл эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй багш нарыг ажиллуулах талаар зохих арга хэмжээ авч, боловсролын бүх түвшинд ажилладаг ажилтан, мэргэжилтнүүдийг сургах зохистой арга хэмжээ авна. Ийм сургалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх болон зохистой нэмэлт болон сонголтот арга зам, төрөл хэлбэр, харилцаанд хэрэглэх бусад хэв маяг, хөгжлийн бэрхшээлтэй хүнд туслах боловсролын заах арга зүй, сургалтын материал хэрэглэх явдлыг хамарвал зохино.
5. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш, үл алагчлах үндсэн дээр дээд боловсрол эзэмших, мэргэжлийн сургалтад хамрагдах, насанд хүрэгсдийн болон насан туршийн сургалтад хамрагдах явдлыг хангана. Эл зорилгоор оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг боломжит хэрэглэгдэхүүнээр хангах явдлыг баталгаажуулна.

ХАВСРАЛТ 2. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр

Улаанбаатар хот

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг;

4.1.2. “хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг;

4.1.3. “тохирох хэрэглэгдэхүүн” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг;

4.1.4. “түгээмэл загвар” гэж нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад тохиромжтой, энгийн бүтээгдэхүүн, программ, орчин болон үйлчилгээний хэв маягийг;

4.1.5. “хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг бүрдүүлж, гэр бүл, хамт олны дунд эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэхийг;

4.1.6. “боломжит дээд хэмжээ” гэж тухайн хүний хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамаарч алдагдсан чадварыг нь сэргээж болох дээд хэмжээ;

4.1.7. “урьдчилан сэргийлэх” гэж иргэн, хамт олны оролцоотойгоор өвчин эмгэг, осол гэмтлийн эрсдэлээс хамаарах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээлэл, сургалт сурталчилгаа явуулах, өвчин эмгэгийг эрт илрүүлж эмчлүүлэх, тэдгээрээс үүдэн гарах эрүүл мэндийн болон нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулах үйл ажиллагааг;

4.1.8. “туслах хэрэгсэл” гэж биеийн бүтцийн гажиг, үйл ажиллагааны алдагдлыг орлох, засах, хамгаалах, дэмжих, гэмтэл учрахаас урьдчилан сэргийлэх зориулалт бүхий хэрэгслийг;

4.1.9. “асаргаа сүвилгааны хэрэгсэл” гэж асруулж байгаа хүний эрүүл мэндийн хэвийн байдлыг хангах, асарч байгаа хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх зориулалт бүхий хэрэгслийг;

4.1.10. “ариун цэвэр-эрүүл ахуйн материал” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүний өдөр тутмын эрүүл ахуйн шаардлагыг хангах, зайлшгүй хэрэгцээтэй материал хэрэгслийг;

4.1.11. “бие даан амьдрах эрх” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн өөртэй нь холбоотой аливаа асуудлаар бие даан шийдвэр гаргах, сонголт хийх, оролцох боломжийг;

4.1.12. “хөтөч нохой” гэж хараагүй хүн тухайн орчинд зөв чиг баримжаатай, саадгүй, аюулгүй зорчиход нь туслах зорилгоор тусгайлан сургаж, бэлтгэсэн нохойг;

4.1.13. “дохионы хэлний хэлмэрч, орчуулагч” гэж сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний дохионы хэлийг хэлмэрчилдэг хүнийг.

5 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад баримтлах зарчим

5.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад дараах зарчмыг баримтална:

5.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг үл тэвчих;

5.1.2. хөгжлийн бэрхшээлтэй хүний сонголт хийх эрх, хараат бус байдлыг хүндэтгэх;

5.1.3. сүрч боловсрох, хөдөлмөрлөх, нийгэмших зэрэг бүхий л харилцаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг саадгүй, хүртээмжтэй хангах орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

5.1.4. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжих эрхийг хангах, тэдний онцлог байдлыг хүндэтгэх;

5.1.5. хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш, хүртээмжтэй хүргэх явдал нь бүх нийтийн үүрэг байх;

5.1.6. хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөллийн оролцоог хангах.

6 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үл ялгаварлан гадуурхах

6.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд энэ хуулийн 6.2-т зааснаас гадна иргэн, хуулийн этгээдийн дараах үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ.

6.4.1. ажлын байрны сонгон шалгаруулалтад оролцуулахаас татгалзах, сонгон шалгаруулалтад тэнцсэн хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас ажилд авахаас татгалзах;

6.4.2. хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний албан тушаал ахих, дэвших боломжийг хязгаарлах;

6.4.3. байгууллага, аж ахуйн нэгж нь ажиллагсдыг хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварласан дүрэм, журам, удирдлагын арга барилыг хэрэглэх, ашиглах;

6.4.4. гэр бүлийн гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар хүнийг ажилд авахаас татгалзах, чөлөөлөх, бусад хэлбэрээр ажил, хөдөлмөр эрхлэх эрхийг нь хязгаарлах;

6.4.5. хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдлэг ур чадвар, онцлогт тохирсон ажлын байрыг зохион байгуулахаас татгалзах, цалин хөлсийг ялгавартай тогтоох;

6.4.6. хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт тохирсон ажлын байрны тохирох хэрэглэгдэхүүн бий болгохгүй байх.

6.5. Дараах үйлдлийг бусад ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:

6.5.1. хүнийг хөгжлийн бэрхшээлээр нь доромжлох, тохуурхах, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүл, эцэг эхийг гадуурхах, олон нийтэд хөгжлийн бэрхшээлийн талаар буруу ойлголт төрүүлэхүйц мэдээлэл, зар сурталчилгаа явуулах, соёл урлагийн бүтээл хийх, хүний сүсэг бишрэл, итгэл үнэмшилд суурилан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэд халдсан аливаа зөвлөгөө өгөх;

6.5.2. гэр бүлийн гишүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмээс тусгаарлах, нуух түүнийг нийгмийн харилцаанд оролцохыг аливаа хэлбэрээр хязгаарлах, хөгжүүлэх чадваржуулах үйлчилгээнд хамруулахаас зайлсхийх;

6.5.3. хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан хүнийг үр хүүхдээ асрамждаа авах эрхийг хязгаарлах.

6.6. Төрөөс хүнийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан бүх хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглосон, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс нь хамгаалсан нийгэм, эдийн засаг, хууль зүйн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6.7. Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд эрх тэгш, бүрэн дүүрэн оролцохыг баталгаажуулах зорилгоор тэднийг тохирох хэрэглэгдэхүүнээр хангах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.

6.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн амьдралд тэгш оролцох эрхийг нь бодитой хангах зорилгоор онцлогт нь тохируулан авч хэрэгжүүлж байгаа тусгай арга хэмжээг ялгаварлан гадуурхалт гэж үзэхгүй.

12 дугаар зүйл. Монгол дохионы хэл

12.1. Монгол дохионы хэл бол сонсголгүй хүний эх хэл мөн бөгөөд сонсголгүй хүн дохионы хэлээрээ нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхтэй.

12.2. Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журмыг боловсролын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

12.3. Энэ хуулийн 12.2-т заасан үйлчилгээг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.

13 дугаар зүйл. Брайл үсгийн стандарт

13.1. Брайл бичиг нь хараагүй хүний хэрэглэдэг үндсэн бичиг бөгөөд брайл бичгийг ашиглан мэдээлэл авах, боловсрол эзэмшин нийгмийн харилцаанд оролцох нөхцөл боломжоор хангана.

13.2. Брайл үсгийн стандартыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын төв байгууллага батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ

14 дүгээр зүйл. Сурч боловсрох эрх

14.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад иргэний хамт сурч боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй бөгөөд энэхүү эрхийг нь хангах чиглэлээр төрөөс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

14.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт нийцүүлэн авьяас билэг, бүтээлч чанар, оюуны болон бие бялдрын чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, орчныг бий болгох;

14.1.2. хувь хүний чадамж болон өөрийгөө үнэлэх үнэлэмжийг хөгжүүлж, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх;

14.1.3. бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлэх;

14.1.4. хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөр, стандартыг боловсруулах.

14.2. Бүх шатны боловсролын байгууллага нь энэ хуулийн 37.2.1-д заасан комиссын дүгнэлтээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүүхдийн хөгжлийн цогц хөтөлбөрийг бүх шатны боловсролын байгууллага хэрэгжүүлэх орчныг бүрдүүлж, бэлтгэл ажлыг хангаж, боловсрол эзэмшүүлнэ.

14.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч, боловсрох, мэргэжил эзэмших эрхийг хангах чиглэлээр төрөөс энэ хуулийн 14.1.1, 14.1.2, 14.1.3, 14.1.4-т зааснаас гадна дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

14.3.1. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тухайн бэрхшээлээс нь үл хамаарч бүх шатны боловсролын байгууллагад бүрэн хамруулах;

14.3.2. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг тэдний хүйс, оршин суугаа газар, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлээс үл хамааран бүх шатны боловсролд тэгш хамруулах, тухайн хүүхэд, залуучуудын онцлог, хэрэгцээг харгалзсан боловсролын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, тэдний шаардлагад нийцсэн хичээлийн анги, танхимыг ердийн сургуулиудад зохион байгуулах үүргийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээх.

14.4. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол эзэмшүүлэх сургалтад хамруулах үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлэхэд нь боловсролын байгууллагын болон нийгмийн ажилтан холбогдох мэдээллээр хангах үүрэгтэй.

14.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах, хөгжүүлэх, бүх шатны боловсрол олгох үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг Засгийн газар батална.

15 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох нөхцөл

15.1. Бүх шатны сургалтын байгууллага болон мэргэжил олгох төв нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид амьдрах ухаан, мэргэжлийн үр чадварыг үр дүнтэй эзэмшүүлэх бөгөөд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

15.1.1. тухайн суралцагчийн онцлогт тохирсон хамгийн зохистой арга хэлбэрээр боловсрол олгох;

15.1.2. хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг онцлог хэрэгцээнд нь тохирох ном, сурах бичиг, гарын авлага, материал, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах;

15.1.3. сургалтын тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалтыг явуулах;

15.1.4. сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцсэн заах арга зүй, арга барил эзэмшсэн багш, сурган хүмүүжүүлэгч явуулдаг байх;

15.1.5. хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурах идэвх, санаачилгыг нэмэгдүүлэхэд чиглэсэн, тэдний онцлог хэрэгцээнд нийцүүлэн брайл үсэг, дохионы хэл болон харилцааны бусад арга хэлбэрийг хэрэглэх, орон зай, чиг баримжааны чадвар олгох, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх;

15.1.6. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бие дааж амьдрах чадвар олгох, бүрэн болон бүрэн бус дунд боловсрол эзэмшсэн бол цаашид суралцах, эсхүл хөдөлмөр эрхлэх, мэргэжлээ сонгоход нь туслалцаа үзүүлэх;

15.1.7. элсэлтийн шалгалтыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд нээлттэй, хүртээмжтэй, онцлог хэрэгцээ, шаардлагыг нь хангасан орчин, нөхцөлд авах;

15.1.8. боловсролын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй оюутныг ажил олгогчдод танилцуулах, зуучлах үйл ажиллагааг зохион байгуулах.

15.2. Бүх шатны сургалтын байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

15.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

15.4. Хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн ганцаарчилсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг тухайн сургалтын байгууллагын мэргэжил арга зүйн зөвлөл, эцэг эхийн оролцоотойгоор боловсруулж батална.

15.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн явц, ахицын өөрчлөлтийг сургууль, цэцэрлэгийн удирдлага эцэг, эхийн оролцоотой хэлэлцэж, дүгнэлтийг энэ хуулийн 37.2.1-д заасан комисст хүргүүлнэ.

15.6. Элсэлтийн шалгалтад тэнцэж, дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагад суралцах эрхтэй болсон хөгжлийн бэрхшээлтэй хүний бакалавр,

магистр, докторын зэрэг олгох сургалтын зардлыг, хөдөлмөрийн чадвараа алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг боловсролын зээлийн сан хариуцна.

15.7. Ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагад суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцсэн ном, сурах бичиг, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслийг худалдан авах зардлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн тухайн жилийн төсөвт тусгана.

15.8. Энэ хуулийн 15.6-д заасан сургалтын зардлын хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.

15.9. Энэ хуулийн 15.7-д заасан ном, сурах бичиг, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслийн жагсаалт, зардлын хэмжээ, олгох журмыг боловсрол болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

15.10. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь харьяалах засаг захиргааны нэгжид үйл ажиллагаа явуулж байгаа бүх шатны боловсролын байгууллагыг энэ хуулийн 15.1-д заасан сургалтын орчныг бүрдүүлэхэд зориулж тусгай хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлж, холбогдох зардлыг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлэнэ.

15.11. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сургалтын онцлог хэрэгцээг хангах сургалтын хөтөлбөр, ном, сурах бичиг, гарын авлага, дохионы хэлний толь бичиг зохиох, хэвлэх, түгээх, засан сайжруулах, брайль болон программ хангамжийг монгол хэл рүү хөрвүүлэх, сургалтын тоног төхөөрөмжийг худалдан авах болон шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах ажлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулна.

15.12. Ерөнхий боловсролын тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үдийн хоолоор үйлчлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

16 дугаар зүйл. Багшийн мэргэжил

16.1. Багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллах агуулга, арга зүйг тусгана.

16.2. Бүх шатны боловсрол олгох сургалтын байгууллагын багш, нийгмийн ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн заах арга зүй, арга барилыг эзэмшсэн байна.

16.3. Энэ хуулийн 16.2-т заасан арга зүй, арга барилыг олгох сургалт болон зөвлөх үйлчилгээг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллага гүйцэтгэж болно.

16.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох багш, хэл засалч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, дохионы хэлний багш, сэтгэл зүйч, арга зүйчийг сургалтын төрийн сангийн зардлаар дотоод, гадаадад сургаж бэлтгэнэ.

ISBN 991996780-7



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамьян гүний гудамж-5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240

Утас: (976) 76113207

И-Мэйл: osf@forum.mn

Вэб: www.forum.mn

Нээлттэй Нийгэм Форумын
мэдээллийн сүвгүүд:

<http://www.forum.mn>

<http://www.twitter.com/ForumOS>

<http://facebook/OpenSocietyForum>

http://www.instagram.com/open_society_forum